

**ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2026 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр, Лхагва гараг*

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>		
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>		1-2
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>		3-57
1. Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаерын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт тусгагдсан “Хүүхдийн хоол, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хэрхэн хангаж байгаа талаар мэдээлэл сонсох” арга хэмжээний хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсролын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдээлэл сонсох		3-57

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Өргөдлийн байнгын хорооны  
4 дүгээр сарын 01-ний өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Өргөдлийн байнгын хорооны дарга О.Номинчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 02 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Баттулга, Ц.Мөнхтуяа;  
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батбаяр, С.Цэнгүүн;  
Тасалсан: Ж.Батсуурь, Б.Батцэцэг, С.Ганбаатар, Б.Пунсалмаа,  
Р.Эрдэнэбүрэн.

**Нэг.Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт тусгагдсан “Хүүхдийн хоол, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хэрхэн хангаж байгаа талаар мэдээлэл сонсох” арга хэмжээний хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсролын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдээлэл сонсох**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баярмагнай, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Бадамжав, Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга Т.Түмэнжаргал, Санхүүгийн хэлтсийн дарга Э.Адъяасүрэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Батшагай, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, мөн яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Янжмаа, мөн газрын ахлах байцаагч Н.Одончимэг, Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Б.Цэцэгсайхан, мөн газрын шинжээч Б.Оролзодмаа, Боловсролын ерөнхий газрын Хоол үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Б.Энхтайван, мөн газрын шинжээч Б.Дуламханд, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын газрын дарга Б.Бямбадорж, Нийслэлийн боловсролын газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга Б.Болормаа, мөн газрын мэргэжилтэн Б.Өлзийбаяр, Нийслэлийн эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн дарга М.Мөнхгэрэл, Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хяналтын хэлтсийн дарга Ц.Цэрмаа, Нийслэлийн Мал эмнэлгийн газрын Мал эмнэлгийн хорио цээр, баталгаажуулалт, хяналтын хэлтсийн дарга Х.Нямбаатар, “Хүүхдийн хоол үйлдвэрлэл, шим тэжээлийн сургалт, арга зүйн үндэсний төв”-ийн захирал Ж.Туяацэцэг, “Асгат” ОНӨААТҮГ-ын захирал Х.Нармөнх, “Багачууд хүнс”

ОНӨААТҮГ-ын захирал Б.Мөнхнасан, “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ-ын захирал Д.Идэрзаяа, “Өсвөр үе хүнс” ОНӨААТҮГ-ын захирал Г.Мөнхзул нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Л.Зулцэцэг, референт Б.Батцэцэг, Г.Нямсүрэн нар байлцав.

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баярмагнай, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин нар тус тус танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Ч.Ундрам, С.Эрдэнэбат, Х.Баасанжаргал, Б.Бейсен, Д.Рэгдэл, О.Саранчулуун, Б.Бат-Эрдэнэ, Д.Ганмаа, Г.Лувсанжамц, М.Мандхай, О.Номинчимэг нарын тавьсан асуултад Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга Т.Түмэнжаргал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, мөн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Б.Цэцэгсайхан, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин, Сангийн яамны Зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа, М.Мандхай, Р.Сэддорж нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Боловсролын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яам, Сангийн яам, Нийслэлийн Засаг даргын мэдээллийг сонсов.

*Уг асуудлыг 18 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 3 цаг 13 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 64.0 хувийн ирцтэйгээр 18 цаг 15 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

О.НОМИНЧИМЭГ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2026 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим  
15 цаг 02 минут.

### **ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**О.Номинчимэг:** Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны хурал эхлэх гэж байна. Байнгын хорооны эрхэм гишүүддээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Өргөдлийн байнгын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Өнөөдөр 14 цагаас хурлаа зарласан, цагтаа ирсэн гишүүддээ баярлалаа. Хүрэлбаатарын Баасанжаргал, Хажекберийн Жангабыл, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Отгоны Саранчулуун, Сүхбаатарын Эрдэнэбат, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Мягмардашийн Сарнай, Жанчивын Галбадрах, Ганзоригийн Лувсанжамц, Дүгэрийн Рэгдэл, Чинбатын Ундрэм, Жаргалсайханы Золжаргал гишүүд буюу нийт 25 гишүүнээс 13 гишүүн 52 хувийн ирцтэй Байнгын хороо эхэлж байна. Өнөөдөр гадаад томилолттой Мөнхтуяа гишүүн, Баттулга гишүүн байна. Орон нутгийн чөлөө авсан Замира, гишүүн Цэнгүүн гишүүн байна. Бусад гишүүд маань одоогоор хараахан учир шалтгаан ирээгүй, бүгд ирцдээ бүртгүүлээгүй байна гэсэн үг. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр нэг асуудал танилцуулахаар та бүхэнд мэдээллийг хүргүүлсэн байгаа. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсролын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн /ХХААХҮ/-ийн сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд, Нийслэлийн Засаг дарга /НЗД/-ын мэдээлэл сонсох байгаа. Өнөөдөр ЗГ бүрэн бүрэлдэхүүнээрээ томилогдож амжаагүй байгаа учраас энэ яамнуудын мэдээллийг Төрийн нарийн бичгийн дарга нар нь хийхээр хүрэлцэн ирж байгаа. Тэгээд хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс саналтай гишүүн байна уу? Алга байна. Тэгвэл хэлэлцэх асуудлаа ингээд баталж, асуудалдаа орёе.

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт манай Байнгын хорооноос тусгасан нэг асуудал хүүхдийн хоол, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хэрхэн хангаж байгаа талаар мэдээлэл сонсох гэсэн асуудал байгаа. Энэ арга хэмжээний хүрээнд Ерөнхий боловсролыг сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсролын яамны ТНБД Ханджавын Батжаргал дарга эхлээд танилцуулгаа хийнэ. Танилцуулга хийхээс өмнө ажлын хэсгийг танилцуулах ёстой.

Өнөөдөр энэ хуралд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүд буюу мэдээлэл танилцуулахаар ирсэн төрийн албан хаагчдын мэдээллийн та бүхэнд танилцуулъя.

Боловсролын яамны ТНБД Батжаргал дарга, Боловсролын яамны Бодлогын төлөвлөлтийн газрын дарга Бадамжав дарга, Түмэнжаргал Боловсролын яамны Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга, Адъяасүрэн Боловсролын яамны Санхүүгийн хэлтсийн дарга, Энхтайван Боловсролын ерөнхий газрын Хоол үйлдвэрлэлийн хэлтсийн дарга, Туяацэцэг Хүүхдийн хоол үйлдвэрлэл, шим тэжээлийн сургалт, арга зүйн үндэсний төвийн захирал, Дуламханд Боловсролын ерөнхий газрын шинжээч оролцож байна. Эхлээд энэ хуулийн хэрэгжилттэй холбоотой Боловсролын яамны мэдээллийг Боловсролын яамны ТНБД Ханджавын Батжаргал хийнэ. Таныг мэдээлэл хийхийг урьж байна, 1 дүгээр микрофон. Мэдээллийг 10-аас 15 минутад багтаагаад танилцуулахыг хүсье. Бичгээр ирсэн тайлан мэдээллийг гишүүдэд тараан хүргүүлсэн байгаа. 1 номерын микрофон.

**Х.Батжаргал:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

2025-аас 2026 оны хичээлийн жилд төрийн өмчийн ерөнхий боловсролын 717 сургуульд 739382 суралцагч, 1046 цэцэрлэгт 231241 хүүхэд, 527 дотуур байранд 334177 хүүхэд ийнхүү боловсролын үйлчилгээнд нийт 2299 байгууллагад 1078756 суралцагчид хамрагдаж байна. Ерөнхий боловсролын сургууль /ЕБС/-ийн нийт сурагчдын 47,2 хувь буюу 349430 бага ангийн суралцагчид үдийн хоол хөтөлбөрт хамрагдаж байна. Хүүхдийн хоол хүнсний төсөв, санхүүжилтийн талаар.

Сургуулийн өмнөх боловсрол /СӨБ/ буюу цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг нийслэл хотод 4 мянган төгрөгөөр тогтоон эцэг эх, асран хамгаалагчаас мянган төгрөгийг хариуцуулж байгаа бол орон нутагт 3 мянган төгрөгөөр тогтоон мөрдөж байна. ЕБС-ийн бага ангийн сурагчдын үдийн хоолны зардлыг 2500 төгрөг, тусгай хэрэгцээт хүүхдийн хоолны зардлыг 3400 төгрөг, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 6 мянгаас 6300 төгрөгөөр тус тус тогтоон мөрдөж байна. 2026 оны улсын төсөвт ЕБС-ийн бага ангийн сурагчдын үдийн хоолны зардал 141,3 тэрбум төгрөг, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардалд 122,4 тэрбум төгрөг, дотуур байрны хүүхдийн хоолны зардалд 60,2 тэрбум буюу нийт 323,9 тэрбум батлагдсан байгаа.

Засгийн газар /ЗГ/-ын 2024 оны 73 дугаар тогтоолоор нийслэлийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал 4 мянган төгрөгөөр тогтоон Боловсролын ерөнхий хуулийн дагуу хоолны зардлын тодорхой хувийг эцэг эх, асран хамгаалагч хариуцан санхүүжүүлж байгаа. Нийгмийн халамжийн тухай хуулийн 20.2-т заасан зорилтот бүлгийн хүүхдийн хоолны түүхий эдийн зардлыг улсын төсвөөс бүрэн хариуцаж 62 хувь буюу 84602 хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс хоолны түүхий эдийн зардлын мянган төгрөгийг санхүүжүүлж байгаа. Энэ нь 10 хүүхэд тутмын 6 хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын тодорхой хувийг эцэг эх, асран хамгаалагчидтай хамтран санхүүжүүлж байна.

Тогтоолын хэрэгжилтийн явцад хяналт үнэлгээ хийж, нийт 26 мянга гаруй эцэг эх, асран хамгаалагчаас сэтгэл ханамжийн судалгаа авахад 72,2 хувь нь хоолны чанар сайжирсан гэж үзсэн бол цаашид нэмэгдүүлэх шаардлагатай гэж 60 орчим хувь нь хариулсан байна. Боловсролын яамнаас хүүхдийн хоолны шим тэжээл, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр ЗГ-ын тогтоолын төслийг боловсруулан яамдаас санал авах түвшинд боловсруулалт явагдаж байна. Уг төслөөр 2026 оны батлагдсан төсөвт багтаан хамрах хүрээг өргөжүүлж, орон нутгийн цэцэрлэгүүдийн дээрх зохицуулалтад нэгдсэн байдлаар тэгш хамруулахаар төлөвлөж байгаа болно.

ЕБС-ийн хоол хүнсний хангамжийн 60,5 хувь нь нээлттэй тендер сонгон шалгаруулалтаар, 39,5 хувь нь зах болон худалдааны төв, иргэдээс худалдан авах хэлбэрээр улсын хэмжээнд зохион байгуулагдаж байна. Хүүхдийн хоол, хүнсний хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэхэд хоолны түүхий эдийн зардлыг нэмэгдүүлэхээс гадна олон нэр төрлийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг тогтвортой ханган нийлүүлэх, батлагдсан норматив, зардлын үр ашгийг дээшлүүлэх, хоол хүнсний баталгаат байдлыг хангуулах нь нэн чухал байдаг.

Боловсролын яамнаас хүүхдийн хоол, хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, шат дамжлагыг цөөлөх, үйлдвэрлэгчээс шууд хагас боловсруулсан байдлаар баталгаат хүнс нийлүүлэх зорилгоор Төрийн худалдан авах ажиллагааны газартай хамтран ерөнхий гэрээ буюу цахим дэлгүүрийн худалдан авалтын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Түүнчлэн орон нутагт хүнсний худалдан авалтыг ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах ажлыг 2026 онд Дархан-Уул, Орхон аймгуудад хэрэгжүүлж эхлүүлж байна. Сургуулийн хоол үйлдвэрлэл, орчныг сайжруулах чиглэлээр ЕБС-ийн Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10.2.2-т сургуулийн Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үндэсний стандартыг боловсруулж батлуулахаар заасны дагуу ЕБС, цэцэрлэг, дотуур байрны хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага MNS 7005 2023 үндэсний стандартыг боловсруулан батлуулсан.

Хуулийн 7.1.4-д сургууль доторх стандартын шаардлага хангасан ундны цэвэр усаар үнэ төлбөргүй хангахаар заасан. Нийт сургуулийн 83,6 хувь нь ус цэвэршүүлэх төхөөрөмжөөр хангагдсан бөгөөд холбогдох стандартаар 75 хүүхдэд нэг төхөөрөмж байхаар заасан хэдий ч төрийн өмчийн сургуулийн 81 хүүхдэд нэг цэвэрлэх цэвэршүүлэх төхөөрөмж ноогдож байна. Цаашид бүх сургуулийг уг төхөөрөмжөөр хангах, хүчин чадлыг стандартад нийцүүлэх, усны чанар, стандартад хяналт тавьж, урсгал засвар үйлчилгээг тогтмол хийж явах шаардлага бий болоод байгаа. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрыг стандартын шаардлага хангуулах чиглэлээр 2022 оноос олон улсын төсөл, хөтөлбөр хөгжлийн түнш байгууллагуудтай хамтран тухайлбал Жайка олон улсын байгууллага /ОУБ/, Койка ОУБ, Дэлхийн боловсролын түншлэл ОУБ зэрэг нийт 12 сая ам.долларын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.

Тухайлбал Койка ОУБ-тай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд 10 сургуулийн эрүүл ахуйн стандартыг шаардлага хангасан жишиг хоол үйлдвэрлэлийн газрыг байгуулж, хоол хүнсний үйлчилгээг зохион байгуулах оновчтой шийдлийг гарган цаашид бусад сургуулиудад улсын хэмжээнд түгээн дэлгэрүүлэх төлөвлөлтийг хийж байна. Хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах асуудал нь хоол үйлдвэрлэлийн чиглэлд хамгийн чухал асуудал байдаг. 2025-аас 2026 оны хичээлийн жилд төрийн болон хувийн өмчийн ерөнхий боловсролын 900 сургуулийн хоол, үйлдвэр, үйлчилгээнд нийт 3243 албан хаагч ажиллаж байгаагаас 319 хоол зүйч, төрийн өмчийн сургуульд 302 хувийн өмчийн 17 сургуульд, мөн 1722 мэргэжлийн тогооч, 1202 туслах тогооч ажиллаж байна.

Хүүхдийн хоолны чанар, хүртээмжийг сайжруулах, эрүүл, шим тэжээллэг хоол хүнсээр үйлчлэхэд хүний нөөцийн мэргэжлийн чадвар, мэдлэг тэднийг тасралтгүй хөгжүүлэх асуудал чухал байдаг. Үүнтэй холбогдуулан Койка ОУБ-тай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд хүүхдийн хоол үйлдвэрлэл, шим тэжээлийн сургалт, арга зүйн төвийг ШУТИС-ийг түшиглэн байгуулж, энэ төвөөр дамжуулан боловсролын сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хүний нөөцийн тасралтгүй хөгжлийг хангах, боловсролын үйлчилгээнд оролцогч

бүхий л талуудын удирдлага болох багш, албан хаагчид суралцах, эцэг эх, асран хамгаалагчид, хүнс ханган нийлүүлэгчид, хоол шим тэжээлийн боловсрол олгох чиглэлээр энд суралцаж буй оюутнууд, ажиллаж буй багш, эрдэмтэд дэвшилтэт технологид суурилсан сургалт шинжилгээ хийх зэрэг бүхий л боломжийг энэхүү орчинд бүрдүүлсэн болно.

Эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр Монгол Улсын Их Хурлын 2022 оны Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 36 дугаар тогтоолд хүүхдийн хоол, хүнсний хангамжийн оновчтой тогтолцоог бий болгох асуудлаар холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах талаар туссаны дагуу Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлтийн төслийг хууль тогтоомжийн хуульд заасны дагуу холбогдох эрх зүйн баримт бичгийг боловсруулж, шаардлагатай судалгаа, шинжилгээ хийж, үр дүнг нь гаргаж, хэлэлцүүлгийн түвшинд санал авах ажил хийгдэж байна. Энэхүү хуулийн төсөлд сургуулийн хоол хүнсний ханган нийлүүлэлтийн тогтолцоо, төр, хувийн хэвшлийн хамтарсан зарчим, зарим чиг үүрэг, орон нутгийн хүнс үйлдвэрлэгчдийн оролцоог бүрэн хангах, бусад хууль тогтоомжтой уялдуулан тэдэнд үзүүлэх дэмжлэг урамшууллын механизмыг тодорхой болгох, цэцэрлэг, сургуулийн хоол, хүнсний үйлчилгээг хүргэхэд шаардагдах өртгийг газар зүйн байршил, хүүхдийн тоо, ялгаатай хэрэгцээ, бүс нутгийн онцлог байдлаас хамааран Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, хөгжлийн бодлоготой нийцүүлэн зарим нэг тооцох, санхүүжилтийн механизмыг илүү тодорхой болгож, боловсронгуй болгож байгаа.

Шаардлагатай төсвийг бүрдүүлэх олон талт санхүүжилтийн эх үүсвэр, хувийн хэвшил, орон нутаг, улсын төсөв, зээл, тусламж гэх мэт тодорхой болгох олон талт эх үүсвэрийг улам нэмэгдүүлэх, зарцуулалтад хяналт тавих эрх зүйн энэ тогтолцоог шинэчлэхээр хуулийн төсөлд тусгаж байгаа. Орон нутгийн бие даасан байдлыг нэмэгдүүлж, салбар дундын оролцоог хангах, эрх зүйн зохицуулалтыг тодотгож өгч байгаа. Сургуулийн хоолны үр дүн хүүхдийн эрүүл мэндийн өсөлт, хөгжлийг хэмжих, баталгаажуулах, хяналт үнэлгээ хийх гэсэн зохицуулалтуудыг нэмэлтээр хуулийн төсөлд оруулж байгаа. Хуулийн шинэчлэлийн хүрээнд хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний санхүүжилтийн тогтолцоог шинэчилж, хүүхэд бүрд тэгш үйлчилгээг хүргэх боломжийг бүрдүүлж, чанар стандартын шаардлага хангасан хүнсний түүхий эд бүтээгдэхүүнээр тогтвортой ханган нийлүүлэх, орон нутгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх, хөтөлбөрийн үр дүнг хянах, үнэлэх иж бүрэн тогтолцоог бүрдүүлэхийг энэхүү хуулийн төсөлд зорьсон болно. Танилцуулга дууслаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

**О.Номинчимэг:** ТНБД Батжаргалд баярлалаа. Дараагийн мэдээллийг Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн талаар ХХААХҮЯ-ны ТНБД Төмөр-Уяагийн Жамбалцэрэн мэдээлэл танилцуулна, 5 номерын микрофон дээр урьж байна Жамбалцэрэн дарга. Манай яамнууд танилцуулгууд РРТ-ээр байхгүй юу, зүгээр мэдээлэл унших гэж байна уу? Ямар ч байсан яамдаас ирсэн мэдээллүүдийг урьдчилж гишүүддээ тараасан байгаа учраас Жамбалцэрэн даргын микрофоныг өгье.

**Т.Жамбалцэрэн:** Байнгын хорооны дарга, гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. ХХААХҮЯ сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний жагсаалтыг хамтран батлах, хүнсний аюулгүй байдлын сургалт зохион байгуулах, дотоодын хөдөө аж ахуй /ХАА/-н гаралтай түүхий эд,

бүтээгдэхүүний гарал үүслийг баталгаажуулах чиглэлээр мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангаж ажиллаж байгаа.

Түүнчлэн яам нь энэ чиг үүргийнхээ хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2022 оны Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 36 дугаар тогтоолоор хүүхдийн хоол хүнсний хангамжийн тогтолцоог сайжруулах, салбар хоорондын уялдааг бэхжүүлэх, хүнсний үйлдвэрлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх бодлогын орчныг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байгаа. Хуулийн хэрэгжилтийг боловсронгуй болгох хүрээнд 2025 оны 6 сарын 6-ны өдөр Боловсролын ерөнхий газартай, мөн 21 аймгийн Боловсрол, Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтнүүдийн оролцоотой үндэсний хэмжээний хэлэлцүүлгийг зохион байгуулж, тус хэлэлцүүлгээр сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тулгамдаж буй асуудлыг хэлэлцэж, хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тусгах саналыг нэгтгэж авсан. Улмаар хүнсний хангамжийн тогтолцоог сайжруулах төлөвлөгөөний төсөлд 5 санал, хуулийн төсөлд 7 саналыг тус тус боловсруулж хүргүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2022 оны Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээний тухай 36 дугаар тогтоолоор баталсан арга хэмжээний төлөвлөгөөний 1.2.2-т хоол, хүүхдийн хоол хүнсний хангамжийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх зорилгоор ЕБС-ийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тусгагдсан. Энэ хүрээнд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, хүнсний хангамж, дэд бүтцийн үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах, төр, хувийн хэвшлийн хамтарсан менежмент бүхий төвийг бий болгох, орон нутагт үйлдвэрлэдэг хүнсний бүтээгдэхүүн, түүхий эд, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, бүс нутгийн онцлогт тохирсон уламжлалт хоол, ундааны хэрэглээ, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар үдийн хоолыг баяжуулах, мөн хүүхдийн бие бялдар, өсөлт хөгжлийн үзүүлэлтийг тогтмол үнэлэх зэрэг цогц арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан.

Дээрх зорилтын хүрээнд Боловсролын сайд, ХЗДХ-ийн сайдтай хамтран хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн үзэл баримтлалыг баталж, хуулийн төслийг боловсруулах ажлыг хамтран хэрэгжүүлж ажиллаж байгаа. 2025 оны салбарын судалгаагаар ЕБС-ийн хоол үйлдвэрлэлд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлт буюу үндэсний үйлдвэрлэгч цехийн тоо 1775 болж өссөн нь ханган нийлүүлэлтийн чадавх нэмэгдэж байгааг харуулж байгаа юм. Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолын хүрээнд үндэсний үйлдвэрлэгчдийн нийлүүлэлтийн сүлжээнд холбогдох ажлыг эрчимжүүлсний үр дүнд сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хэрэгцээнд зориулсан хүнсний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор 2023-аас 2024 онд хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээлд 44 ААН хамрагдсанаас 6 ААН ерөнхий гэрээ байгуулан хүүхдийн хоол хүнсний бүтээгдэхүүн нийлүүлж ажиллаж байна.

Үүнээс гадна ерөнхий гэрээний танилцуулах уулзалтад үндэсний үйлдвэрлэгч болон уг тогтоолын хүрээнд зах зээл, хүрээнд зээл авсан ААН-үүдийг хамруулснаар Ерөнхий гэрээгээр бүтээгдэхүүн нийлүүлэгчдийн тоо 2023 онд 9, 2024 онд 14, 2025 онд 17 болж өссөн дүн харагдаж байна. 2025-аас 2026 оны хичээлийн жилд төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан 17 ААН ерөнхий гэрээ байгуулж, нийтдээ 257 сургууль, цэцэрлэгийн 11000468,7 сая төгрөгийн төсөвт захиалгыг ханган ажиллаж байна. Үүнд 157 СӨБ-ын сургуулийн байгууллага, 100 ЕБС-ийн байгууллага хамрагдаж, орон нутгийн 29 цэцэрлэг, 11 сургууль, 1 мах боловсруулах үйлдвэрлэл нийлүүлэлтийн сүлжээнд оролцож байна. Мах, махан бүтээгдэхүүн, сүү

сүүн бүтээгдэхүүн, төмс хүнсний ногоо, жимс жимсгэнийн төрлийн бүтээгдэхүүн, будаа, элсэн чихэр зэрэг нэр төрлийн бүтээгдэхүүн нийлүүлж байгаа нь дотоодын үйлдвэрлэлийн оролцоо бодитоор нэмэгдэж байгааг харуулж байна.

Хяналт шалгалтын чиглэлээр 2025-аас 2026 оны жилийн хичээлийн бэлтгэл ажилд хийсэн урьдчилсан сэргийлэх хяналт шалгалтаар 593 байгууллага хамрагдаж, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, чанар аюулгүй байдлын баталгаажилт, тээвэрлэлт, хадгалалт, боловсруулалтын горимд хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар нийтдээ 1787 зөрчил илрүүлж, 749 буюу 41,9 хувийг арилгуулан, 176 албан шаардлага, 108 зөвлөмж хүргүүлсэн байна. Илэрсэн зөрчлийг задалж үзвэл хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын 33,7 хувь нь хүнсний бүтээгдэхүүний төрөлжсөн агуулахгүй, 25 хувь нь хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, хүрэлцээ хангалтгүй, 21,9 хувь нь технологийн карт, шим тэжээлийн үзүүлэлтээ бүрэн баталгаажуулаагүй, 17,9 хувь нь хэрэглэж буй амтлагч, хүнсний нэмэлтийн бүртгэл, баталгаажилтгүй байсан нь хяналт шалгалтыг цаашид эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байгаа юм.

Хүнсний хангамжийн төвүүдийн үйл ажиллагаанд мөн анхаарах шаардлагатай байна. Нийслэлийн төрийн өмчит сургууль, цэцэрлэгийн хүнсний хангамжийг холбогдох төвүүдээр дамжуулан зохион байгуулж байгаа боловч зарим тохиолдолд эдгээр төвүүд нь зөвхөн дамжуулалтын үүрэг гүйцэтгэж, хүнсний бүтээгдэхүүн, нэр төрлийг бүрдүүлэх, үнийн зохистой байдлыг хангах чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байна гэж үзэж байна. Үүний улмаас хүүхдийн хоол, хоолны шим тэжээлийн тэнцвэрт байдалд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүсэж болзошгүй нөхцөл байдал байна.

Хүний нөөц чадавхын хувьд хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын 48,9 хувь нь хоол зүйчгүй буюу хангалтгүй байгаа нь дотоодын хяналт сул байгааг илтгэж байна. Мөн мэргэжилтнүүдийг тогтмол сургах шаардлага хэрэгцээ өндөр байна. Энэ хүрээнд 2025 онд ХХААХҮЯ, Боловсролын яам, Боловсролын ерөнхий газар, Койка олон улсын байгууллагуудтай хамтраад 21 аймгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, танхимын болон цахим хосолсон хэлбэрийн сургалтыг 9 удаагийн сургалтыг зохион байгуулж, нийтдээ 711 оролцогчийг хамруулсан байна. Цаашид анхаарах чиглэлээр ажиллах шаардлагатай байна.

Үүнд 1 дүгээрт, ерөнхий гэрээний хүрээг өргөжүүлж 36 дугаар тогтоолын хүрээнд зээл авсан үндэсний үйлдвэрлэл эрхлэгчдийг сургуулийн хүнсний хангамжийн сүлжээнд илүү өргөн хүрээнд холбох. 2 дугаарт, хүнсний хангамжийн төвүүдийг зөвхөн дамжуулагч бус, анхан шатны боловсруулалт, төрөлжсөн агуулах, хүйтэн хэлхээний тогтолцоонд үе шаттай шилжүүлэх шаардлагатай байна. 3 дугаарт, хүнсний бүтээгдэхүүний түүхий эдийн гарал үүсэл, баталгаажилт, лабораторийн хяналтыг чангатгах, тогтмолжуулах шаардлага байна. 4 дүгээрт сургууль, цэцэрлэгийн удирдлага, хоол зүйч, технологич, тогооч, нярав болон нийлүүлэгч ААН-үүдийг хүнсний аюулгүй байдал, дотоод хяналт, ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангуулах чиглэлээр төрөлжсөн сургалтад тогтмол хамруулах. Төгсгөлд нь хэлэхэд энэхүү хуулийн хэрэгжилтэд хүүхдийн эрүүл мэнд, шим тэжээл, аюулгүй байдлаас гадна үндэсний үйлдвэрлэл, төрийн худалдан авалт, хүний нөөц, хяналтын тогтолцоо уялдааг шаардсан салбарын дундын цогц асуудал яригдаж байгаа юм.

Иймд Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хүрээнд хэрэгжсэн арга хэмжээний үр дүнд бий болсон суурийг хадгалж, цаашид үндэсний үйлдвэрлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхэд бүрд эрүүл, аюулгүй, шим тэжээлтэй хоол хүргэх тогтолцоог бэхжүүлэх, төр, хувийн хэвшлийн орон нутгийн байгууллагуудын хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах шаардлагатай байна. Анхаарал тавьсан явдалд баярлалаа, танилцуулж дууслаа.

**О.Номинчимэг:** Жамбалцэрэн ТНБД-д баярлалаа. Бид өнөөдөр энэ холбогдох яам, нийслэлээс нийтдээ 5 мэдээлэл сонсоно. 3 дахь мэдээллийг Эрүүл мэндийн яам /ЭМЯ/-ны ТНБД Дагвадоржийн Очирбат дарга танилцуулна. Хүүхдийн хоолны шим тэжээл дээр илүү хуулийн хэрэгжилтийн асуудлаар танилцуулахаар байгаа. 3 дугаар микрофоныг нээж өгье. Очирбат даргыг урьж байна.

**Д.Очирбат:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр эрүүл мэндийн салбараас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүний үр дүн, тулгамдаж байгаа асуудлын талаар товч танилцуулгыг хийе. Хуулийн хэрэгжилтийн хүрээнд хүн амын хоол тэжээлийн байдлыг үнэлэх зорилгоор Монгол Улсын хүн амын хоол тэжээлийн 6 дугаар судалгааг 23-аас 24 онд улсын хэмжээнд зохион байгуулж, 2025 онд үр дүнг нь нийтэд мэдээлсэн байдаг. Судалгааны дүнгээс харахад ЕБС-ийн суралцагчдын дунд илүүдэл жин таргалалт нэмэгдэх хандлагатай байгаа юм. Тухайлбал нийт суралцагчдын 19,6 хувьд нь илүүдэл жинтэй, 6,2 хувьд нь таргалалттай байна. Мөн бага ангийн сурагчдын дунд энэ үзүүлэлт нь 23,7 хувьтай байгаа нь өмнөх судалгаатай харахад харьцуулсан харьцангуй өссөн үзүүлэлтүүд харагдаж байгаа юм.

Үүний зэрэгцээ өсөлт хоцрогдол, туранхай байдал тодорхой хувиудыг эзэлж байгаа нь хүүхдийн хооллолт, хоол хүнсний асуудал харилцан тэнцвэргүй, амьдралын хэв маяг зохистой бус байгааг харуулж байгаа юм. Мөн бичил биет бодисын дутагдал анхаарал татахуйц түвшинд байна. Ялангуяа суралцагчдын иодын хангалт буурсан, Д амин дэмийн дутагдал хүүхэд, жирэмсэн эхчүүдийн дунд өндөр хувьтай байгаа нь хүнсний баяжуулалт урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна. Сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүний жагсаалтыг батлан мөрдүүлж, хэрэгжилтэд нь тогтмол хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд 2025 онд нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиуд дунд хийсэн хяналт шалгалтаар уг зохицуулалтын хэрэгжилт нь 87,5 хувьтайгаар үнэлэгдсэн байдаг.

Гэсэн хэдий ч сургуулийн орчин дахь хүнсний бүтээмж, сонголт, ялангуяа шинэ төрлийн болон импортын бүтээгдэхүүнтэй холбоотой эрсдэлийг хамруулах хяналтын тогтолцоог боловсронгуй болгох шаардлага хэвээрээ байгаа юм. Хүүхдийн хоолны илчлэг, шим тэжээлийн хэрэгцээг тодорхойлсон стандарт зөвлөмжийг батлан мөрдүүлж байгаа боловч тэдгээрийн хэрэгжилт ялангуяа үдийн хоолны чанар стандарт хангалтгүй байгаа нь ажиглагдаж байгаа. Энэ хүрээнд 2024 онд ерөнхий боловсролын сургуулиудын үдийн хоолны чанар, аюулгүй байдал, илчлэг, шимт бодисын агууламжид хийсэн хяналт шалгалтын дүнгээс харахад үдийн хоолны найрлага, шим тэжээлийн бүтэц нь батлагдсан зөвлөмжтэйгөө харьцуулахад харьцангуй тэнцвэргүй байдалд байна. Тодруулбал гурил, төмс, будаа, мах, гурилан бүтээгдэхүүн, ургамлын тосны хэрэгцээний зөвлөмж хэмжээг

ерөнхийд нь хангаж байгаа боловч сүү, сүүн бүтээгдэхүүн, хүнсний ногоо, жимс жимсгэнийн хэрэгцээ хангалтгүй байгаа юм.

Үдийн хоолны дундаж илчлэг 394,7 килокалори, уураг 17,5гр, өөх тос 12гр, нүүрс ус 54,1гр байгаа нь батлагдсан норм шаардлагад хүрэхгүй бөгөөд хүүхдийн хоногийн шим тэжээлийн хэрэгцээг хангаж чадахгүй байна. Энэ нь үдийн хоолны чанар, шим тэжээлийн агуулга хангалтгүй, хоолны цэс нэг төрөлд хэтэрхий төвлөрсөн байгааг харуулж байгаа бөгөөд хүүхдийн өсөлт, хөгжил, дархлаанд сөргөөр ч нөлөөлөх ийм боломжтой байгааг, ийм эрсдэлийг нэмэгдүүлж байгааг харуулж байгаа юм.

Цаашид сургуулийн орчин дахь хүнсний аюулгүй байдлын чиглэлээр 2025 онд 6 удаагийн хоолны хордлого гарч, халдварын дэгдэлт бүртгэгдсэн. Нийтдээ 504 хүүхэд өртсөн нь дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, зохион байгуулалт хангалтгүй байгааг харуулж байна. Мөн 2025 онд нийт 310 ерөнхий боловсролын байгууллагад хийсэн хяналт шалгалтаар 5082 зөрчил илрүүлж, 66,9 хувийг нь газар дээр нь арилгуулж, үлдсэн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлэн ажилласан. Ерөнхий боловсролын сургуулиуд хийсэн эрсдэлийн үнэлгээгээр сургуулийн 12,5 хувь нь их, 43,3 хувь нь дунд, 44,2 хувь нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн нь тодорхой ахиц гарсан хэдий ч эрүүл ахуй, халдвар хамгаалал, дэд бүтэц, хүний нөөцийн чадавхын асуудал шийдэгдэж чадахгүй байна.

Цаашид дараах чиглэлд бодлогын болон хэрэгжилтийн арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай байна. Үүнд сургуулийн үдийн хоолны шим тэжээлийн чанар, стандартыг бодитоор хангах дотоод хяналт шалгалтыг тогтмолжуулах, хоолны цэс, технологийг сайжруулж, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх ёстой. Хүнсний түүхий эд, нийлүүлэлтийн тогтолцоо, чанар, аюулгүй байдлын шаардлагад нийцсэн энэ шаардлагыг шинэ түвшинд гаргахгүй бол аюулын харанга дэлдээд байгаа юм. Сургуулийн орчин дахь хүнсний аюулгүй байдлын дотоод болон гадаад хяналтын тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай байгаа юм. Эцэг эх, суралцагчдад чиглэсэн хоол тэжээлийн боловсрол, зан үйлийн өөрчлөлтийг дэмжих арга хэмжээг өргөн зохион байгуулах шаардлага тулгарч байна. Хуулийн хэрэгжилтийг бодит үр дүнд хүргэхэд салбар дундын уялдаа, хамтын ажиллагаа онцгой чухал болохыг энд тэмдэглэж хэлье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**О.Номинчимэг:** Очирбат ТНБД-д баярлалаа. 4 дэх танилцуулгыг ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр хэрэгжүүлсэн дотоодын болон олон улсын төсөл хөтөлбөрийн явц, санхүүжилтийн талаар Сангийн яамны ТНБД Мягмарсүрэнгийн Баярмагнай мэдээлэл танилцуулна. 4 номерын микрофон, Баярмагнай даргыг урьж байна.

**М.Баярмагнай:** Сайн байцгаана уу. Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Түрүүн Боловсролын төрийн нарийны мэдээлэлтэй зарим хэсэг нь давхцаж, хуулийн заалт давхцаж байгаа учраас тэр хэсгийг би товчлоод шууд ерөнхий боловсролын үдийн хоол, дотуур байрны хүүхдийн хоолны түүхий эдийн зардалд зориулсан төсвийн мэдээллийг шууд танилцуулъя гэж бодож байна. Үдийн хоол хөтөлбөртэй холбоотой ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10.1.2-т заасны дагуу 2019-өөс 2025 онд Монгол Улсын төсвийн тухай хуульд туссан

сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зардал дараах байдалтай байгааг хэлье. 19-өөс 25 оронд өссөн дүнгээр нь би товчлоод хэлье гэж бодож байна.

Нийт дотуур байранд амьдарч буй хүүхдийн тоо 244 мянга 19 оноос хойш жил бүр жишээлбэл сүүлийн 2 жил 35,5, 2025 онд 34,4 байх жишээтэй. Нийт хоолны дотуур байрны хоолны зардалд 202,4 тэрбум төгрөг зарцуулсан. Үдийн хоолонд хамрагдаж буй нийт хүүхдийн тоо 2,5 сая 19 оноос 25 оны хооронд, үдийн хоолны зардалд нийт өссөн дүнгээр 474,8 тэрбум төгрөг зарцуулсан байна, өнгөрсөн 25 оны төсвөөр 149,8 тэрбум төгрөг гэсэн үг. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд 1-ээс 5 дугаар ангийн 341900 хүүхдийг үдийн хоол хөтөлбөрт хамруулахаар тооцож, хоолны түүхий эд, материалын зардалд 141,3 тэрбум төгрөг, дотуур байрны хүүхдийн хоолны зардалд нийт 67 тэрбум төгрөгийг тусгасан.

Ерөнхий боловсролын бүх хүүхдийг үдийн хоол хөтөлбөрт хамруулах замаар хүүхдийн өсөлт, хөгжлийг дэмжих, сурлагын чанарыг дээшлүүлэх, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, орлого багатай өрхийн хүүхдүүдийн сурах идэвхийг нэмэгдүүлэхэд бодит үнэ оруулах нь ЗГ-ын тэргүүлэх зорилт билээ. Мөн Сангийн яам, Нэгдсэн Үндэстний Байгууллага /НҮБ/-ын Хүүхдийн сантай хамтран хүүхдийн сургалтын орчныг сайжруулах, хүүхдэд чиглэсэн төлөвлөлтийг үр ашгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд ЕБС-ийн үдийн хоолны нөхцөл байдлын шинжилгээ хийж, үдийн хоолны төсвийн загварчлалыг боловсруулсан. Тус судалгаагаар үдийн цай хөтөлбөрөөр шим тэжээлийн хэрэгцээний 35 хувийг авах ёстойгоос сургуулиудын хэрэгжилтийн түвшинд 27 хувийг нь л олгож байгаа бөгөөд тус хувийг бүрэн олгохын тулд нэг хүүхдийн хоолны зардлын норматив 992 төгрөг нэмэлтээр олгох шаардлагатай гэсэн үр дүн гарсан.

Тиймээс ЗГ төсвийн боломжтой уялдуулан дунд хугацаанд үдийн хоол хөтөлбөрийн хамрагдалт, норм, нормативыг үе шаттайгаар нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Ингэхдээ хоолны зардлын тодорхой хэсгийг эцэг эх, асран хамгаалагчид хариуцуулах, хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хувийн хэвшлийг оролцуулах зэргээр аль болох богино хугацаанд хоол үйлдвэрлэл, ханган нийлүүлэлтийн хүчин чадлыг төсөвт дарамт багатай, үр ашигтай байдлаар шийдвэрлэх асуудлыг ЗГ-ын түвшинд салбар яамдын оролцоо, манлайлалтай хамт хэрэгжүүлэх бас зайлшгүй шаардлагатай гэж үзэж байгаа.

Гадаад зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хувьд Боловсролын дэлхийн түншлэл ОУБ-ын 5 сая ам.долларын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл нь 2022-оос 25 онд хэрэгжсэн. Уг төсөл нь нийт 3 бүрэлдэхүүн хэсгээс бүрдэх бөгөөд үүний 2 дугаар бүрэлдэхүүн хэсэг болох сургуулийн үдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд нийт 1,8 сая доллар ойролцоогоор 6,5 тэрбум төгрөг, төсвөөр Улаанбаатар хот болон орон нутгийн ерөнхий боловсролын 45 сургуулийн гал тогоог шаардлагатай тоног, төхөөрөмж туслах хэрэгслээр бүрэн хангаж, иж бүрэн тохижуулж, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчныг сайжруулсан.

Мөн хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор ерөнхий боловсролын сургуулиудад ажиллах 36 мэргэжлийн хоол зүйчийг 1-ээс 1,5 жилийн хугацаатай сургалтаар бэлтгэн, зорилтот сургуулиудад ажиллах нөхцөлийг бүрдүүлж, 60 тогоочийг хүүхдийн хоолны тогооч сэдэвт танхим, дадлага хосолсон сургалтад хамруулснаар хүүхдийн хоол бэлтгэх мэдлэг, ур чадварыг дээшлүүлсэн. Түүнчлэн төслийн хүрээнд Монгол Улсад анх удаа орон нутаг болон алслагдсан бүсийн

дотуур байрны сурагчдад зориулсан хүүхэд төвтэй хоол тэжээл эрүүл мэндийн хөтөлбөр болон бага, дунд, ахлах ангийн сурагчдад зориулсан гарын авлагууд, хоол тэжээлийн тусгай хэрэгцээт хүүхдийн хооллолтод дэмжлэг үзүүлэх аргачлалыг боловсруулж, зорилтот сургуулиудад туршин хэрэгжүүлсэн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй зарим нэгэн төсөл арга хэмжээний тухай. Улсын төсөв, төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны үйлдвэрлэл, үйлчилгээний орчныг сайжруулах, гал тогооны тохижилт, тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл, арга хэмжээг жил бүр Боловсролын сайдын багцад тусган хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд 2019-өөс 25 оны улсын хэмжээнд нийт 22 төсөл, арга хэмжээнд 7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, 21 аймаг болон нийслэлийн дүүргүүдийн ЕБС, дотуур байрны гал тогоог хоол үйлдвэрлэлийн аюулгүй байдал, стандарт техникийн шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжөөр ханган орчныг үе шаттайгаар сайжруулсан бөгөөд санхүүжилтийн мэдээллийг 19-өөс 25 оны хооронд нийт 7 тэрбум төгрөг гэж хэлсэн.

Монгол Улсын 26 оны төсвийн хөрөнгө оруулалтаар Боловсролын сайдын багцад нийт 2,8 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсан. Тус санхүүжилтийн хүрээнд шинээр ашиглалтад орох 79 ЕБС, 15 дотуур байрны гал тогоонд шаардлагатай тоног, төхөөрөмжийг нийлүүлэхээр төлөвлөж байна. Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

**О.Номинчимэг:** Баярлалаа. Сүүлчийн мэдээллийг ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн талаар НЗД-ын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч Амгаланбаярын Амартүвшин мэдээлэл хийнэ. РРТ байгаа билүү, бас зүгээр мэдээлэл үү? 2 номерын микрофон, Амартүвшин даргын микрофоныг өгье.

**А.Амартүвшин:** Өргөдлийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Нийслэлийн хэмжээнд 2025-аас 2026 оны хичээлийн жилд төрийн өмчийн 178, төрийн бус өмчийн 154 нийтдээ 332 ЕБС-д 412394 сурагч хамрагдаж байгаа бөгөөд 18096 багш сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг ингээд зохион байгуулаад ажиллаж байна нийслэлийн хэмжээнд. 2025-аас 2026 оны хичээлийн жилд төрийн өмчийн 327, төрийн бус өмчийн 312 нийт 639 цэцэрлэгт 124503 хүүхэд СӨБ-д ингээд хамрагдаад явж байна.

Өнөөдрийн байдлаар төрийн өмчийн 178 сургуулиас 158 сургууль нь үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа. Үлдсэн 20 сургууль нь дунд, ахлах ангийн бүтэцтэй тул хөтөлбөрт хамрагдахгүй байгаа. Үүнээс 116 сургууль буюу 72 хувь нь гал тогоо өөрсдөд, гал тогоогоо өөрсдийн бие дааж үйл ажиллагааг нь явуулж байгаа. 42 сургууль буюу 28 хувь нь түрээсийн хэлбэрээр үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үдийн хоол хөтөлбөрт төрийн өмчийн ЕБС-ийн 1-ээс 5 дугаар ангийн нийт 188874 сурагч, хувийн өмчийн 1-ээс 5 дугаар ангийн 33297 сурагч хамрагдаж байна.

Түрээсийн хэлбэрээр үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлж буй сургуулиудын мэдээллийг товч хүргэе. Түрээсийн хэлбэрээр үдийн хоол хөтөлбөрийг ерөнхий боловсролын 42 сургууль хэрэгжүүлж байгаа. Шалтгаанаар нь тухай хэлбэл 6 сургууль тэр дундаа Эрдмийн оргил, Боловсрол, 41 дүгээр, 4, 79, 123 дугаар сургуульд Боловсролын яам болон Койка ОУБ-ын хамтарсан ЕБС-ийн хоол

үйлдвэрлэл, үйлчилгээний орчныг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх төслийн хүрээнд хэрэгжүүлж байгаа. 3 сургууль нь бол 30, 111, 89 дүгээр сургууль, мөн 4 сургууль буюу 39, 65, 184 дүгээр сургууль бол гал тогооны тоног, төхөөрөмж байхгүй учраас ингээд үдийн цай хөтөлбөрөө хэрэгжүүлж чадахгүй, гаднаас хоол хүнсээ худалдаж авч байгаа. 29 сургууль нь хүний нөөц, цалин хөлс хүрэлцэхгүй байгаа болохоор ажиллах боломжгүйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Хүний нөөцийн асуудлаар гэвэл үдийн хоол хөтөлбөрийг бие даан хэрэгжүүлж буй төрийн болон орон нутгийн өмчийн сургуулиудад хоол зүйч 60, тогооч 238, туслах ажилтан 139 ингээд ажиллаж байгаа. ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5.2 дахь заалтад сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг мэргэжлийн бүтэц, орон тоогоор хангахад дэмжлэг үзүүлэх гэж тусгасан хэдий ч БСШУС-ын сайд болон Сангийн сайд нарын 2018 оны А/024/11 дүгээр хамтарсан тушаалаар баталсан төрийн болон орон нутгийн өмчийн ЕБС-ийн багшаас бусад захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив, хоол норматив дотор хоол зүйчийн орон тоог ингээд батлаагүй байдаг. Мөн тогоочийн орон тоог хангалттай бус ингээд баталж өгсөн байдаг. Койка ОУБ-тай хамтран хэрэгжүүлж буй Монгол Улсын ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчныг сайжруулах төслийн хүрээнд ШУТИС-ийн дэргэд Хүүхдийн хоол үйлдвэрлэл, шим тэжээлийн сургалт болон арга зүйн үндэсний төв дээр бид өнөөдрийн байдлаар 758 хоол зүйч, тогоочийг давтан сургалтад ингээд хамрагдуулаад явж байна.

Хүнсний бүтээгдэхүүний хувьд гэвэл Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 5 дугаар тогтоолд тусгасан Орон нутгийн болон үндэсний үйлдвэрлэлийг дэмжсэн аюулгүй хүнсний ханган нийлүүлэлтийг нэгдсэн тогтолцоог бий болгох, боловсролын байгууллагын хоол үйлдвэрлэлд ашиглах хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдан авах ажиллагааг ерөнхий гэрээний дагуу зохион байгуулж, ерөнхий гэрээ рүү шилжүүлж, суралцагч хүүхдүүдэд чанартай, эрүүл, аюулгүй халуун хоолоор үйлчлэх зорилгыг ингээд тавин, зорилго тавьсан. Энэ ажлын хүрээнд Монгол Улсын ЗГ-ын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн жагсаалтад багтаах тухай 466 дугаар тогтоолоор худалдан авах бараа, үйлчилгээний жагсаалт ингээд батлагдсан байгаа.

Боловсрол сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэл, нийлүүлэх хүнсний гол нэрийн түүхий эд, бүтээгдэхүүнийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд хагас боловсруулсан байдлаар ерөнхий гэрээгээр тендер шалгаруулалтын хэлбэрээр нийлүүлж, tender.gov.mn сайтаас буюу цахим дэлгүүрт 15 ААН-ийн 68 нэр төрлийн хүнсний бараа, бүтээгдэхүүн тавигдаж, ерөнхий гэрээгээр төрийн өмчийн 116 сургууль, 134 цэцэрлэг хүнс худалдан авалт хийж хамтран ажиллаж байгаа.

Нийслэлийн сургууль, нийслэлийн СӨБ-ын байгууллагуудын эрүүл аюулгүй, стандарт шаардлага хангасан, баталгаатай, чанартай хүнсний бараа, бүтээгдэхүүнээр тасралтгүй хангах зорилгоор Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал /НИТХТ/-ын 2006 оны 154 дүгээр тогтоолоор нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын статустай үүсгэн байгуулж, 2025 оны 27 дугаар тогтоолоор орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар статустай болгон өөрчилсөн. Нийслэлийн хэмжээнд цэцэрлэг, сургуулийн хүнсний хангамжийг хариуцсан Асгат, Багачууд хүнс, Өсвөр үе хүнс, Хүнс хангамжийн төв гээд 4 хариуцсан ОНӨААТҮГ ажиллаж байна. НИТХ-ын тогтоол, НЗД-ын захирамж гарснаар ерөнхий боловсролын

сургуулиудад хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлж эхэлсэн боловч хангамжийн байгууллагуудын нийт борлуулалт нийлүүлэлтийн 90-ээс дээш хувь нь буюу 286 цэцэрлэг, 31 ерөнхий боловсролын сургуулиуд л эзэлж байна.

Дээрх газрууд нь 140 гаруй нэр төрлийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг нээлттэй тендер, сонгон шалгаруулалтаар зарлан, бэлтгэн нийлүүлэгчтэй гэрээ байгуулан худалдан авах ажиллагааг хийж байгаа бөгөөд нийт худалдан авалтын 75 орчим хувийг дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнээр ханган нийлүүлдэг. Гэвч ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль нь СӨБ-ын байгууллагыг хүнсээр хангах үйл ажиллагааг зохицуулаагүй байдаг. ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсэгт сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд баяжуулсан хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэж болно гэж заасны дагуу дараах ажлуудыг хэрэгжүүлж байна.

НЗД-ын 2025 оны А/1705 дугаар захирамжаар Хүүхдийн хоолны зөвлөл байгуулагдаж, ажлын хэсгээр цэцэрлэг, сургуульд хүнс хангамж нийлүүлэх гол нэрийн бараа бүтээгдэхүүн болон мах, ногоо, гурил, будааны үнийн өсөлтийн талаар хэлэлцэж, нийслэлийн нөөцийн махнаас цэцэрлэгийн хүнсний хоолноос нийлүүлэх болон бусад судалгаануудыг хийж гаргаж, нийлүүлэлтийг ханган ажиллаж байна. НЗД-ын 2024 оны А/559 дүгээр захирамжаар 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн нийслэл, орон нутаг, эцэг эхийн оролцоотойгоор нийслэлийн ерөнхий боловсролын 13 сургууль буюу 19400 хүүхдийг хамруулж Сүү хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. НЗД-ын 2026 оны А/08 дугаар захирамжаар 8,9 тэрбум төгрөгийг батлуулж, эцэг эх, асран хамгаалагчдын дэмжлэгтэйгээр нийслэлийн төрийн өмчийн ерөнхий боловсролын 1-ээс 5 дугаар ангийн 188874 сурагчдыг сүүн дархлаа зорилтот төсөлд хамруулж, 7 хоногийн 3 өдөрт сүү өгч байна. ЕБС-ийн сурагчдын кальци, Д амин дэмийг нөхөх, дархлааг дэмжих зорилгоор шинжилгээнд хамрагдах сургуулиудыг түүврийн аргаар сонгож, сонгогдсон төрийн өмчийн 21 сургуулийн 765 сурагчдаас шинжилгээ авч, лабораторийн шинжилгээ яг одоо хийгдэж байгаа процедуртай явж байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

**О.Номинчимэг:** Амартүвшин НЗД-ын орлогчид баярлалаа. Өнөөдрийн бидний хэлэлцэж байгаа энэ хоол үйлдвэрлэл, ЕБС, цэцэрлэгийн хоол, шим тэжээлтэй холбоотой Өргөдлийн байнгын хороо дээр ирсэн өргөдлүүдийг та бүхэнд танилцуулъя. Манай Өргөдлийн байнгын хороо дахин байгуулагдсанаас хойш нийтдээ d.petition буюу нийтийн өргөдлийн цахим системээр 3 удаа энэ асуудалтай холбоотой өргөдөл бий болж байсан байна. 2025 оны 1 дүгээр сард Намсрайжавын Явуухулангаас цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоолны мөнгийг нэмэгдүүлэх petition эхлүүлж, 685 иргэний дэмжлэг авч байсан байна. Мөн 25 оны 11 сарын 7-нд ЕБС-ийн бүх сурагчдад буюу дунд, ахлах ангийн сурагчид үдийн хоол өгөх саналыг Улсын Их Хурлын гишүүн Ренчинбямбын Сэддорж гаргаж, 5193 иргэний дэмжиж санал авч байсан байна.

Мөн 2026 оны 2 сарын 5-ны өдөр хэлбэр харгалзахгүйгээр үдийн хоол хөтөлбөрт тэгш хамруулах тухай өргөдлийг Гансүхийн Отгончимэг гэдэг иргэн гаргаж, 16510 иргэн дэмжиж санал өгч байсан байна. Мөн Хүүхдийн хоол үйлдвэрлэл, шим тэжээлийн сургалт арга зүйн төвийн захирал Туяацэцэгээс Боловсролын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хүүхдийн хоол, шим тэжээлийн хоол зүйчийн энэ сургалтыг байнга тогтмол хийж байх талаар саналыг ирүүлж байсан. Ингэж байж бид зөв шим тэжээлтэй хоол хүнсийг

хүүхдүүддээ өгөх юм гэдэг энэ саналууд иргэд, Төрийн бус байгууллага /ТББ/, Улсын Их Хурлын гишүүдээс ийм саналууд гарч байсан байна.

Ингээд өнөөдөр хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя. Сая 5 танилцуулга мэдээллээ сонслоо. Та бүхэнд бичгээр бүгдэд нь нэг дэхээс авхуулаад, 1 дэх, 2 дахид бүх мэдээллүүд очсон. Боловсролын яамны ТНБД Батжаргал, Сангийн яамны ТНБД Баярмагнай, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны ТНБД Жамбалцэрэн, ЭМЯ-ны ТНБД Очирбат, НЗД-ын орлогч Амартүвшин. Боловсролын яамнаас Бадамжав Боловсролын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Түмэнжаргал Боловсролын яамны Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга, Адъяасүрэн Боловсролын яамны Санхүүгийн хэлтсийн дарга, Энхтайван Боловсролын ерөнхий газрын Хоол үйлдвэрлэлийн хэлтсийн дарга, Туяацэцэг Хүүхдийн хоол үйлдвэрлэл, шим тэжээлийн сургалт, арга зүйн үндэсний төвийн захирал, Дуламханд Боловсролын ерөнхий газрын шинжээч оролцож байна.

Сангийн яамнаас Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн бодлогын төлөвлөлтийн газрын Зарлагын хэлтсийн дарга оролцож байна.

ХХААХҮЯ-наас Батшагай ХХААХҮЯ-ны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /ХШҮДАГ/-ын дарга, Довчинсүрэн ХХААХҮЯ-ны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга нар оролцож байна.

ЭМЯ-наас Цэцэгсайхан ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн бодлого, хэрэгжилтийн газрын дарга, Янжмаа ЭМЯ-ны Салбарын ХШҮДАГ-ын дарга, Одончимэг Салбарын ХШҮДАГ-ын ахлах байцаагч, Оролзодмаа ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн оролцож байна.

НЗДТГ-аас Бямбадорж НЗДТГ-ын Нийгмийн бодлогын газрын дарга, Болормаа Нийслэлийн боловсролын газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга, Мөнхгэрэл НЭМГ-ын Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн дарга, эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч, Цэрмаа Нийслэлийн ХХААГ-ын Хяналтын хэлтсийн дарга, улсын ахлах байцаагч, Нямбаатар Нийслэлийн Мал эмнэлгийн газрын Мал эмнэлгийн хорио цээр, баталгаажуулалт, хяналтын хэлтсийн дарга, Өлзийбаяр НБГ-ын хүүхдийн хоол хүнсний асуудал хариуцсан мэргэжилтэн. Мөн 4, нийслэл чинь 4 хоолны газартай хүнсний, Асгат, Багачууд, Хүнс хангамж төв, Өсвөр үе хүнс гээд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын захирал болох Нармөнх, Мөнхнасан, Идэрзаяа, Мөнхзул гэсэн ийм бүрэлдэхүүнтэй НЗДТГ-аас оролцож байна.

Мэдээлэлтэйгээ танилцсан учраас хэлэлцэх асуудалтай холбогдуулан ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ бүртгүүлнэ үү. Нийтдээ 9 гишүүн, ирцэд Мандхай гишүүн ирцэд ороорой, орсон уу? Рэгдэл гишүүнийх орохгүй байна уу? Мандхай гишүүн орчихлоо. Рэгдэл гишүүнийх орж байна уу? Орчихлоо. Нийт 11 гишүүнээр тасаллаа. Мөнхбаясгалан гишүүн, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

**Л.Мөнхбаясгалан:** Сангийн яам, Боловсролын яамнаас асууя. Хөдөө орон нутагт тойргоор явж байхад энэ хүүхдийн үдийн хоолтой холбоотой асар их гомдол ирдэг л дээ, ялангуяа цэцэрлэг, сургуулиар явахаар. Тэгэхээр манай улс ингэдэг юм байна л даа. Цэцэрлэгийн хүүхдэдээ 4 мянган төгрөг, эндээс мянган төгрөг нь эцэг эх, ерөнхий боловсролын бага ангийн сурагчдын үдийн хоолны зардал 2500 төгрөг, тусгай хэрэгцээт хүүхдийн хоолны зардал 3400, дотуур байрны хүүхдийн хоолны зардал 6 мянгаас 6300 байдаг юм байна та бүхний өгсөн мэдээллээр.

Тэгэхээр хөдөө орон нутагт байгаа сургуулиудад ийм шаардлага яриад байдаг байхгүй юу. Энэ дотуур байрны хүүхдийн энэ хоолны зардал огт хүрэлцэхгүй байна. Бид эцэг эхийн дэмжлэгээр амьдардаг. Дээрээс нь тэр нөгөө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль гэж тендерийн хууль хамгийн их гайтай хууль. Бид энүүгээр орохоор ерөөсөө хүмүүст шалгардаггүй, энийг хүчингүй болгож өгөөч гэдэг ийм гомдол тавиад байдаг юм. Тэгээд сая та бүхний хэлж байгаагаар ингээд харахаар тэр алслагдсан сумдад хөдөө орон нутагт болохоор тэр ЕБС-ийн сурагчдын үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлэх тэр нэг үйлдвэрлэлийн газар нь байгуулагдаж болдоггүй юм уу тийм ээ? Тийм юм байхгүй учраас шууд тендерийн хуулиар зохицуулаад байна уу? Тэрийг байгуулахад тийм их мөнгө төгрөг хэрэгтэй байдаг юм уу? Яагаад алслагдсан сумдад байгуулагдаж болдоггүй юм бол 1 дүгээр асуулт нь энэ байна.

2 дугаар асуулт нь болохоор дунд болон ахлах ангийн сурагчдыг үдийн цай хөтөлбөрт хамруулах хууль нь байдаг юм байна шүү дээ, 2023-аас 2024 онд батлагдсан энэ хуулиараа байдаг юм байна. Гэтэл 2022 оны Улсын Их Хурлын 70 дугаар тогтоолоор хойшлуулчхаад байгаа юм. Тэгээд сая Сангийн яамны мэдээлэл дээр болохоор энэ бидний хамгийн нэн тэргүүний зорилт гэсэн байна. Шаардлагатай мөнгө нь 271,7 тэрбум төгрөг юм байна л даа. Тэгэхээр Сангийн яам болон та бүгд энэ дунд болон ахлах ангийн сурагчдыг үдийн цай хөтөлбөрт хамрагдуулахын тулд ямар санаачилгатай арга хэмжээ авч ажиллаж байгаа вэ? Хамгийн сүүлд Сэддорж гишүүн ийм санал гаргасан. Өнгөрсөн 26 оны улсын төсөв хэлэлцэх гэж байхад гаргасан. Тэгэхээр энэ дээр яг ямар арга хэмжээ авч ажилласан бэ?

3 дугаарт нэг асуулт байна. Энэ ЕБС-ийн хоолны хөтөлбөрийг болохоор зохицуулсан хүнсээр хангах ажиллагааг зохицуулсан хэр нь цэцэрлэгийн хүүхдийн энэ хүнсээр хангах үйл ажиллагааг зохицуулаагүй байна гээд сая хотоос мэдээлэл хийж байна. Энэ яагаад зохицуулагдаагүй юм бол, энэ талаар ямар арга хэмжээ авч байгаа юм бэ? Дээрээс нь цэцэрлэгийн хүүхдүүдийн тоглоомд манай улс хэдэн төгрөг төсөвлөдөг юм бол жилд? Хөдөө орон нутагт л явж байсан гомдлын дагуу л би асуултаа асууж байгаа. Тэгээд тодруулаад явъя даа.

**О.Номинчимэг:** Мөнхбаясгалан гишүүний асуултад 3 асуулт, эхлээд ХХААЯ, тэгээд Сангийн яам, тэгээд Боловсролын яам уу? 5 номерын микрофон Жамбалцэрэн ТНБД.

**Т.Жамбалцэрэн:** Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Салбарын хариуцаж байгаа чиг үүргийн хүрээнд энэ сургуулийн хоол үйлдвэрлэлд нийлүүлэх хүнсний түүхий эдийн аюулгүй байдал, гарал үүслийн баталгаажуулалт, мөн хяналт шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр л салбарын яам тодорхой арга хэмжээ авч ажиллаж байгаа. Тэгээд энэ дотроо ялангуяа энэ мах махан бүтээгдэхүүний хувьд мал эмнэлгийн нэгдсэн цахим бүртгэлийн системд

бүртгэлтэй, гарал үүслийн гэрчилгээтэй байх шаардлагыг мөрдүүлж ажиллаж байна. Сүү, сүүн бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо, гурил болон бусад боловсруулсан бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнгээр баталгаажуулах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байгаа. Энэ чиглэлээр оролцож байгаа 4,5 мянга гаруй иргэн, ААН-д холбогдох сургалтыг зохион байгуулаад, хяналт шалгалтын үйл ажиллагаануудыг зохион байгуулж байгаа.

Яг юу гэдэг юм тэр сургуулийн хүүхдийн үдийн хоолны хэрэгцээт үйлдвэрлэлийг тухайн сум, бүс нутагт нь байгуулах чиглэлээр салбарын яам дээр Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байгаа хувийн хэвшлийн санаачилга дээр урт хугацаатай хөнгөлөлттэй зээлийн хүрээнд л энэ шийдэгдээд явж байгаа. Тэрнээс биш яг тухайлсан бүс нутаг дээр гэдэг юм уу, зохион байгуулж байгаа арга хэмжээ байхгүй байгаа. Эргээд энэ асуудлууд маань өөрөө нэгдсэн, сая эхний танилцуулга дээр хэлсэн салбар хоорондын нэлээн тийм том уялдаатай, цогц бодлого хэрэгжүүлж, нэг талдаа хүнсний аюулгүй байдлаа хангах, нөгөө талдаа тэр хатуу, зөөлөн дэд бүтэц, хөрөнгө оруулалтуудын боломжийг нь бий болгож, тухайн бүс нутгийн хүн ам, сургууль, цэцэрлэг, хүүхдийнх нь тоо, тэрэнд тулгуурласан үйлдвэрлэлийн нөөцдөө тулгуурлаж явахгүй бол яг салбарын яаман дээр аж ахуйн чиглэлтэй энэ ажлууд руу төвлөрүүлэх чиглэл харьцангуй бага, цэвэр хувийн хэвшлийнхээ санаачилга дээр тулгуурлаж явж байгаа ийм л бодлоготой байгаад байгаа юм.

**О.Номинчимэг:** 4 номер Сангийн яам, ямар ажил ер нь нэмэгдүүлэх чиглэлээр хийв гэсэн асуулт асуусан.

**П.Бат-Эрдэнэ:** Сангийн яам Зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ. Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр дотуур байрны хүүхдийн хоолны тарифтай холбоотой асуулт асуусан. 2024 онд энэ тариф 3475 төгрөг байсныг нь 6 мянга болгож нэмэгдүүлсэн юм. Тэгээд 25 он, 26 онд харамсалтай нь энэ тарифыг нэмэгдүүлж чадаагүй. Энэ 6 мянган төгрөг яг тухайн хүүхдийн нэг өдрийн энэ хоолны материал түүхий эдийнх нь зардал байгаа. Үүнээс гадна гал тогооны зардал, гал тогооны тог цахилгаан, усны зардал, дээрээс нь тогооч, бэлтгэгч, угаагчийн зардал гээд эдгээр зардлууд маань энэнээс тусдаа явдаг байгаа. Тэгээд энэ зардлыг.../минут дуусав/

**О.Номинчимэг:** 4 номерын микрофон нэг минут нэмээд өгчихье. Тэгээд тодорхой хариулчих.

**П.Бат-Эрдэнэ:** Энэ түүхий эдийн зардал учраас зөв зарчим нь инфляцтай нэмэгдээд жил болгон нэмэгдэж байх ёстой. 2025, 2026 оны хувьд энэ төсвийн зарлагын өсөлт хязгаарлагдмал, орлого маань яг энэ санасанд хүртэл бүрэлдээгүй учраас бид зардлыг нь нэмэгдүүлж чадахгүй ингэж явсан байгаа.

Хүүхдийн сургууль дээр хоол идсэнээр энэ сурлагын ахиц дэвшил болон энэ тухайн хүүхдийн өсөлт хөгжилтөд ямар их ач холбогдолтой вэ гэдгийг энэ аягүй олон судалгаа нотолсон байдаг. Бид эдгээр судалгаануудын үр дүнтэй танилцсан. Тэгээд ахлах анги, дунд анги болон ахлах ангийн сурагчдыг ер нь яг ийшээ ингээд нэмж хамруулах энэ чиглэлээр ЗГ дээр яригдсан тохиолдолд бид энийг ингээд ажил хэрэг болгоод явах боломжтой. Яах вэ яг нөгөө түүхий эдийн зардлыг нь ингээд дан ганц

тавьснаараа яг энэ асуудал шийдэгдчихдэггүй юм. Энэ нь өөрөө эргээд сургууль.../минут дуусав/

**О.Номинчимэг:** Дахиад нэг минут, ер нь товч хариулна шүү.

**П.Бат-Эрдэнэ:** Ойлголоо. Түүхий эдийн зардлыг нь ингээд төсөвт нь тусгаад явж болно. Гэхдээ энэний цаана хоол үйлдвэрлэх чадал гал тогооны тоног төхөөрөмжийг өргөтгөх, тэр хоолны заалыг нь өргөтгөх, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх, дээрээс нь хоол зүйч, энэ тогоочийн тоог нэмэгдүүлэх гэдэг юм уу иймэрхүү ийм олон төрлийн ийм цогц ийм олон зардал шаардагддаг ийм ажил байдаг учраас энэ дээр ингээд шууд ингээд 1, 2 жилдээ шилжчих ийм боломж ЗГ дээр байхгүй байгаад байгаа гэдгийг хэлэх нь зөв байна. Баярлалаа.

**О.Номинчимэг:** Сангийн яамны ТНБД, Зарлагын дарга нь энэ асуудал их чухал, бид нэмэгдүүлэх ёстой гэдэг байр суурьтай. Боломж байвал нэмэгдүүлнэ гээд байдаг. Тэгсэн мөртөө танай Татварын бодлогын газрын дарга чинь эсрэг юм яриад байгаа шүү дээ. Би энийг дахиад хэлчихье. Тамхины хяналтын тухай хуулийн дагалдах хуулиар бид тамхины татварыг нэмээд, энэ татварынхаа 50 хувийг одоо энэ та нарын нэмж чадахгүй байгаа хоол хүнсний шим тэжээлийг нэмэгдүүлэх, дунд, ахлах ангийнхныгаа үдийн хоолонд хамрагдуулах болох энэ мөнгөнд нь зарцуулъя гээд бодлогыг нь гаргаад, дагалдах хуулийг нь оруулаад ирсэн. Ажлын хэсэг дээр Сангийн яамныхан энийг эсэргүүцээд байгаа шүү дээ, бид орсон орлогоо өөрсдөө юунд зарцуулахаа мэднэ гээд. Тэгэхээр энийг яамны хувьд Төрийн нарийн нь уг нь дэмжээд байгаа юм байна. Тэгвэл танай Татварын бодлогын газрын дарга чинь өөр юм яриад яваад байгаа юм байна л гэж ойлгохоос. 1 номер Боловсролын яамнаас цэцэрлэгийн хоолтой холбоотой Мөнхбаясгалан гишүүний хариулт.

**Х.Батжаргал:** Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Энэ өнгөрсөн жил 26 оны төсвийг хэлэлцэж байх явцад Сэддорж гишүүний санал гаргаад, тодорхой зарчмын зөрүүтэй санал гаргаад энэ хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлэх талаар санал гарсан. Тухайн үед зэрэгцээд багш, албан хаагчдын боловсрол, эрүүл мэндийн салбарын урсгал зардлыг нэмэгдүүлэх эх үүсвэрийн бусад эх үүсвэрүүдээс дайчлах гэх мэт олон асуудлууд байсан учраас энэ ороогүй юм болов уу гэж бид үзэж байгаа. Тэрнээс төсвийн эцэслэн батлах тэр процесс дээр бол 1 дүгээр ажил нь нөгөө цалин, хангамжийн тэтгэвэрт нэмэгдүүлэх чиглэлээр гол зарцуулалт явсан байх гэж бодож байна. Мэдээж зөвхөн дотуур байр гэлтгүйгээр ер нь энэ хүүхдийн хоол түүхий эдийн зардлын энэ нөхцөл байдал дутмаг байдаг. Жилд, өдөрт авах ёстой нийт илчлэгийнхээ өнгө 35 хувийг нь сургуулийн.../минут дуусав/

**О.Номинчимэг:** Сангийн яам, Боловсрол 2 хүүхдийн цэцэрлэгийн тоглоомд зориулж төсөвлөлт төсөв дээр хэд тусаж байна гэдгээ. 1 номер Батжаргал ТНБД.

**Х.Батжаргал:** Тэгэхээр цэцэрлэг болон ЕБС-д хувьсах зардлаар дамжуулж санхүүжилт нь олгогдож байгаа. Тэгэхээр хүүхдийн тоогоор орчхож байгаа хувьсах зардал дотор нөхөн хангалтын зардал гэж байдаг. Тэгэхээр үүгээр цэцэрлэгийн хэрэглэгдэхүүн буюу тоглоом наадгайд 4 тэрбум төгрөг зарцуулагдаж өнгөрсөн жилийн үзүүлэлт байна. Дээр нь нэмээд хөрөнгө оруулалтын зардал дээр тухайлбал энэ жил 800 тэрбум, 800 сая төгрөгийг тоглоом наадамд зарцуулахаар төлөвлөгдсөн байгаа.

**О.Номинчимэг:** Мөнхбаясгалан гишүүн тодруулъя.

**Л.Мөнхбаясгалан:** Хүүхдийн, цэцэрлэгийн хүүхдийн тоглоомд ерөөсөө мөнгө тавьдаггүй гээд цэцэрлэгүүдээс гомдол ирээд байгаа л даа. Наадах чинь худлаа. Тэгэхээр би нөгөө ийм юм асуугаад байгаа юм. Сургуулийн хоол хүнсний хангамжийг орон нутгийн төсөвт үйлдвэрийн газар байгуулан хангадаг гээд байгаа шүү дээ. Гэтэл алслагдсан сумдад энийг байгуулах боломжгүй учраас тендерийн хуулиараа ААН-дээ тендер зарлаад, хоол ундны нөгөө бүтээгдэхүүнээ нийлүүлдэг гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр би ийм асуулт тавиад байгаа юм. Тэр орон нутгийн төсөвт үйлдвэрийн газар байгуулах өртөг чинь хэд юм бэ? Тэрийг тухайн орон нутаг өөрсдөө байгуулаад ажиллачхаж болдоггүй юм уу, энэ дээр та ямар хоорондоо уялдаатай ажилладаг юм бэ гээд байгаа юм. Тэгээд дотуур байрны хүүхдийн хоолны зардал инфляцтай уялдаад хэдэн хувиар нэмэгдэх ёстойг одоо бид нэмж чадахгүй 2 жил болчихоод байгаа юм бэ? Дээрээс нь тэр 271,7 тэрбум төгрөг байвал.../минут дуусав/

**О.Номинчимэг:** Хэн хариулах вэ, 1 номер уу? Сангийн яамтай холбоотой асуулаа. 1 номер Батжаргал ТНБД. 1 номер нэрээ хэлээд хариулъя.

**Т.Түмэнжаргал:** Боловсролын яамны Хоол үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Түмэнжаргал. Гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт нь тэр орон нутгийн төсөвт үйлдвэрийн газар гэдэг маань өөрөө сургуулийн ЕБС-ийн хоол үйлдвэр, үйлчилгээний тухай хуульд хүнсний хангамжийг зохион байгуулах хоёрхон арга байгаа. Тэрний 1 дүгээрт нь орон нутаг өөрөө төсөвт үйлдвэрийн газар байгуулах, үгүй бол тендер. Яагаад орон нутагт төсөвт үйлдвэрийн газар байгуулахгүй байгаа вэ гэхээр энэ өөрөө орон нутгийн 100 хувь өөрийнх нь эрх мэдлийн асуудал. Иргэдийн хурлаараа орон нутгийнхаа энэ төсөвт үйлдвэрийн газраа байгуулъя гэж шийдвэрээ гаргаад байгуулах нь орон нутгийн эрхийн асуудал байгаа. Зүгээр энэ дээр төсөвт үйлдвэрийн гэхээрээ нөгөө улсын үйлдвэр гэдэгтэй холбоотойгоор төсөв санхүүжилтийн асуудал байгаа. Түүнээс хуулийн зохицуулалтаараа орон нутаг өөрөө шийдвэрээ гаргаад байгуулах ийм 100 хувийн эрх нь байж байгаа. Дотуур байрны хүүхдийн хоолны зардал дээр түрүүн асуулаа. Энэ дээр бид одоо байгаа 6 мянгаас 6300 төгрөгийг 9 мянган төгрөг буюу 9-өөс 10 мянган төгрөг болгож нэмэгдүүлэх.../минут дуусав/

**О.Номинчимэг:** Сангийн яам хариулах уу? Бодитой 271 тэрбумыг нэмж гаргаад дунд, ахлах ангийн хүүхдүүдэд үдийн хоол өгөх асуудал дээр ямар ажлууд, саналууд гарч байсан бэ гэдэг дээр. ТНБД нь түрүүн чөлөө аваад явчихлаа л даа. Зарлагын хэлтсийн дарга, харин тийм. Тэгэхээр Зарлагын хэлтсийн дарга ч биш ингээд. Тэгвэл энэ орон нутагтай холбоотой ямар механизмаар болох юм гэдгийг Боловсролын яамнаас дунд, ахлах ангийнхны хүүхдүүдийг үдийн хоолоор хангах асуудал дээр дорвитой саналууд дээр яаж ажилласан бэ гэдгийг ЗГ-ын Хэрэг эрхлэхээс ч гэсэн ер нь гаргуулъя даа. Зөвхөн Сангийн яамнаас биш. Тэгээд Мөнхбаясгалан гишүүнд бичгээр хариу өгөхөөр байна. Дараагийн гишүүн Чинбатын Ундрам гишүүн асуулт асууя.

**Ч.Ундрам:** Сая ЭМЯ-ны хийсэн мэдээллээр энэ 2023-аас 24 онд хийсэн судалгаагаар ерөнхий боловсролын сурагчдын 100 хүүхэд тутмын 20 нь илүүдэл жинтэй, 6 нь тарган, 2,5 нь өсөлт хоцролттой, 2,5 нь туранхай буюу 100 хүүхэд тутмын 21 нь ямар нэгэн өсөлтийн проблемтой байна гэсэн ийм судалгаа байна. Энэ маш аюултай үзүүлэлт гэж үзэж байна. Тэгээд энэ судалгаагаа хийхдээ юу гэдэг

юм алслагдсан сум, хотын гэр хороолол болон төвийн дүүргүүд гэдгээр нь ингэж ялгаж харьцуулж харсан юм байгаа юу? Би яагаад ингээд асуугаад байгаа вэ гэхээр тойргоороо яваад ингээд иргэдтэй уулзаж байхад алслагдсан сумдын хүүхдүүд болон гэр хорооллын хүүхдүүд ингээд өсөлт нь жижгэрээд давжаараад байна. Эсрэгээрээ аймгийн төвийн хүүхдүүд болон хотын төвийн хүүхдүүд илүүдэл жинтэй болоод байна гэсэн ийм ажиглалтыг манай ахмадууд хэлээд байгаа юм. Тэгэхээр яг ингэж харьцуулсан ийм судалгаа байгаа юу тэгээд яах вэ?

Энэ асуудал дээр бид ер нь хүүхдүүдийнхээ эрүүл ахуйд анхаарахдаа мэдээж 1 дүгээрт шим тэжээлийн асуудал байх ёстой, тэгээд 2020-оос 24 онд ажиллаж байсан Улсын Их Хурлын эмэгтэй гишүүд үдийн цай хөтөлбөрийг үдийн хоол болгоод, төсвийг нь нэмээд ямар ч байсан бага ангиуддаа бүрэн өгдөг ийм боломжийг бүрдүүлж байсан. Тэгээд энэ дээрээ мэдээж хоол нь сая энэ судалгааг харахад шим тэжээл нь зөвлөж байгаа хэмжээнээсээ зарим нь бага сүүнээс авхуулаад гээд ингээд харагдаж л байна л даа. Ямар ч байсан ийм дэвшил хийж байсан. Гэхдээ бид энэ 22 оны тогтоолын хэрэгжилт хангалтгүй байна гээд Боловсролын яамнаас хийсэн мэдээллийг хараад би бодож л сууна л даа. 22 онд бид чинь бөөн юм болоод яриад л ийм тогтоол гаргаж байсан чинь өнөөдрийг хүртэл энийг хэрэгжүүлэх гээд санал аваад л явж байгаа юм байна гэж байгаа юм 4 жил тийм ээ. Тэгэхээр энийг удаан байна гэж бодож байна.

Үүнээс гадна хөдөлгөөний асуудлыг би Боловсролын яам, Боловсролын сайдад байнга тавьж ирсэн. Шим тэжээлээс гадна биеийн тамир, дасгал хөдөлгөөн хэрэгтэй байна. Үдээс өмнө ядаж нэг ээлжийн сургуулиуд чинь энэ сумдаар дүүрэн байгаа шүү дээ. Үдээс өмнө танхимын цаг, үдээс хойш биеийн тамир, спорт, урлаг гээд дасгал хөдөлгөөний цаг болгоодхооч. Ядаж хүүхдүүд чинь 3 цаг 30 минут хүртэл энэ нэг ээлжийн сургуулиуд гар утаснаас хол тэгээд биеийн дасгал хөдөлгөөн хийгээд ингээд байж байхад тэнчээ бэлэн багш нь байна. Бэлэн спорт заал, талбай юу байдаг юм болохгүй бол гадаа гараад хичээл хийлгэж болно шүү дээ. Ялангуяа энэ дулаан болсон үед, өвөл ч гэсэн гулгуулаад ингээд байж болно. Яагаад энийг хийчихдэггүй юм бэ, энэ ерөөсөө маш хурдан хийх ажил шүү дээ. Дараа нь тодруулья.

**О.Номинчимэг:** Судалгааны асуудлаар ЭМЯ 3 номер Очирбат дарга.

**Д.Очирбат:** Бид судалгаагаа 4 жил тутамдаа нэг хийж тодруулдаг. Тэгэхдээ өнөөдрийн гаргасан судалгааны үр дүн тооцоолол бол бид ялгаж салгаагүй. Ерөнхий улс орны хэмжээнд тавигдсан судалгаа нийт гарсан үр дүнгээр л танилцуулгыг хийсэн. Тэгээд гишүүний ярьж байгаатай яг адилхан ер нь бол манай хүүхдүүдийн хоол хүнсэнд хэрэглэж байгаа бүтээгдэхүүн хэтэрхий их нэг тал, нэг нүүрс ус руу чиглэсэн ийм бүтэцтэй байгаа. Тэгээд түрүүний жимс жимсгэнэ болон амин дэм, тэжээлтэй бүтцүүд нь их бага байдаг. Тэгээд хөдөө орон нутагт гэхэд бүр гурилын хэрэглээ, нүүрс усны хэрэглээ бүр давамгайлчихсан. Хоолныхоо бүтцийн бүр 75 хувьд нь хүртэл бин, тэгээд нөгөө талх, хүнсний бүтээгдэхүүн, гурилан бүтээгдэхүүн, тэгээд хоолных нь төрлүүд ч гэсэн болох энэ цуйван, бууз гээд л. Энэ орон нутаг хөдөөгөөрөө ялгаатай байна, хүртээмжээрээ ялгаатай байгаа.

**О.Номинчимэг:** Боловсролын яам. Хүртээмж, дугуйлан секц ажиллуулж эрүүл мэндэд анхаарах талаар, нэг номер уу? Батжаргал дарга нэг номер.

**Х.Батжаргал:** Ундрам гишүүний хэлсэн саналтай бүрэн санал нэг байгаа. Хөдөлгөөн дутагдал, илүү цаг. Энэ асуудал ганцхан үүсэж байгаа бэрхшээл хүртээмж, орчинтой шууд холбоотой. 2 ээлжээр хичээллэж байгаа энэ тохиолдолд дунд хугацаандаа хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр нэг ээлж рүү шилжүүлэх, түүний дотор нэг ээлжтэй болсон тохиолдолд одоо ч нэг ээлжээр явагдаж байгаа сургууль ерөнхий боловсролын сургалтын үйл ажиллагаанд хөтөлбөр дээр биеийн тамирын цаг, бусад хамгийн том сорилт болоод байгаа энэ дэлгэцийн хамаарлыг багасгах энэ хөтөлбөрүүд ороод явж байгаа. Гагцхүү сургалтын орчин, ялангуяа нийслэл хотод нэг ээлжтэй сургууль төдийлөн хангалттай биш байгаа нөхцөлд энэ хичээлээс гадуурх сургалт үйл ажиллагааг бид илүү нэмэгдүүлэхийн тулд эхний ээлжид энэ хүртээмжээ нэмэгдүүлэх асуудалд тэргүүн ээлжид анхаарч байж шийдвэрлэхээр байгаа. Тогтоолын хэрэгжилт хангагдахгүй хойшлоод байна гэдэг маань бид.../минут дуусав/

**О.Номинчимэг:** 1 номер нэмэлт нэг минут.

**Х.Батжаргал:** Мэдээж шууд гол хязгаарлагдмал нөөц болох төсөв, эдийн засгийн нөхцөл байдалтай шууд холбоотой. Тухайлбал дунд ангид үдийн хоол өгч эхлэхэд зөвхөн дунд ангид нь 167 тэрбум төгрөг, зөвхөн ахлах ангид нь салгаж байгаад 104,5 тэрбум гээд ингээд бага ангитайгаа нийлбэл жилд 478 тэрбум төгрөгийн хэрэгцээ шаардлага үүсдэг. Энийг бид үе шаттайгаар гээд анги болгоноор нь тооцоогоо салгаад дунджаар 40 орчим тэрбум төгрөг, 6 дугаар анги, 7 дугаар анги гэх мэт анги болгоноор гаргасан байдаг. Мэдээж шууд энэ эдийн засгийн нөхцөл байдалтай, эх үүсвэртэй шууд холбоотой байдаг учраас Боловсролын яамны тухайд дангаар шийдвэрлэх боломжгүй нөхцөл байдлын үүднээс эдийн засагтайгаа уялдуулж хойшлуулах тогтоолын хэрэгжилтийг хангах тухайлсан заалтыг хойшлуулах ийм шийдвэр УИХ дээр холбогдох Байнгын хороон дээр гарсан байдаг.

**О.Номинчимэг:** Чинбатын Ундрам гишүүн тодруулъя.

**Ч.Ундрам:** ЭМЯ та хэд цуглуулсан датагаа ингээд алслагдсан сумыг нь ялгаад, аймгийн төвтэй ч юм уу ингээд харьцуулах ийм боломж байхгүй юу? Хэрвээ ийм боломжгүйгээр энэ судалгаа хийсэн бол та хэд маш муу чанаргүй судалгаа хийсэн байна. Өнөөдөр чинь 2026 он шүү дээ. Өчнөөн мундаг судалгаа хийдэг хүмүүс энэ их сургуулиудаар дүүрэн байна. Болохгүй бол би хийгээд өгье. Ийм нийт Монгол орноороо тэд нь ингээд жин дээр зогсоож байгаад илүү жинтэй байна гээд энэ чинь маш амархан судалгаа шүү дээ. Энийгээ ядаж газар нутгаар нь, байршлаар нь ингээд ялгачихаар дата цуглуулаагүй юу? Хэрвээ тэгж чадаагүй би бол үнэхээр харамсаж байна. Хайран мөнгө, би хийгээд өгье.

2 дугаарт Батжаргал дарга та ингээд миний асуултыг жоохон бөөрөнхийлж хариулаад байна. Одоо яг нэг ээлжийн сургуулиудаа л үдээс өмнө танхим, үдээс хойш биеийн тамирын цаг болгочих гэж байна шүү дээ.

**О.Номинчимэг:** Чинбатын Ундрам гишүүнд нэг минутыг нь тодруулга.

**Ч.Ундрам:** Тэгэхээр байна шүү дээ жишээлбэл Сэлэнгэ аймгийн Түшиг сумын сургууль нэг ээлж, тэнд байгаа хүүхдүүдийг үдээс өмнө танхимын цаг ор, үдээс хойш дасгал хөдөлгөөн биеийн тамирын цаг ор гээд та бүхэн ийм нэг ээлжийн Монгол орон даяар байгаа сумдад байгаа ялангуяа алслагдсан сумдад байгаа сургуулиудад удирдамж өглөө болоо, ингээд л хийчих ажил байхгүй юу. Тэгэхээр

энийг хийгээд өгөөч гээд би бүүр шаардаж байна, гуйж байна, сэтгэл гаргаач, тэр хүүхдүүдийн эрүүл мэндийг бодооч гэж хэлж байгаа.

2 дугаарт энэ худалдан авах ажиллагаа гэж энэ хуулийг өөрчлөхдөө бид анхаарах хэрэгтэй байна. Сургууль тухайн орон нутгийнхаа малчнаас илүү хямд, магадгүй хүүхэд нь явдаг сургуульдаа ээж аав нь мал махаа хямд, сүүгээ хямд нийлүүлэх боломжтой байхгүй байхгүй юу. Тэгэхээр энэ асуудал дээр бид анхаарч эрх зүйн орчныг нь сайжруулах ёстой, энэ дээр хийсэн юм байгаа юу?

**О.Номинчимэг:** ЭМЯ хариулах уу? 3 номер Очирбат дарга.

**Д.Очирбат:** Манай дээр судалгаа бол түрүүний хэлсэнчлэн аймаг орон нутгуудаар бүс бүсүүдээр судалгаа нарийвчилж байгаа. Тэрийг би та бүхэнд танд гаргаж нэмэлтээр хүргүүлье. Тэгээд жишээлбэл хөдөө орон нутагт хоцрогдолд, нөгөө хэрэглэж байгаа хүнсний бүтээгдэхүүний хомсдолоор нэг төрлийн мах, гурилын хэрэгцээ их өндөр байдагтай холбогдуулаад нөгөө жингийн хоцрогдолд их байгаа юм. Суурин газар хотын суурин газруудаа жингийн илүүдэл, таргалалт илүү байдалтай судалгаан дээр гарсан байдаг нь харагдсан.

**О.Номинчимэг:** 1 номер Боловсролын яам Батжаргал дарга.

**Х.Батжаргал:** Сургалтын хөтөлбөр төлөвлөгөөний тухайд яг таны хэлсэнчлэн нэг ээлжийн сургалттай үйл ажиллагаа явуулж байгаа сургуулиудын хөтөлбөрт нэг ээлжийнхээ хүрээнд хичээлийн бус цагаар явагдах энэ төлөвлөгөө хөтөлбөр энэ шинэ хичээлийн цагаас яг таны хэлсний дагуу бэлэн болно. Зөвхөн биеийн тамир биш, 1 ээлжийн сургалттай сургуулийн үдээс хойших хөтөлбөрийг зөвхөн биеийн тамир болгох төдийгүй бусад ур чадварыг эзэмшүүлэх, хичээл дээрээ үзсэн ур чадвараа илүү бататгахын тулд секц дугуйлан хичээллүүлэх энэ төлөвлөгөөг шинэ хөтөлбөрийн хүрээнд гарч байгаа, бэлэн болж байгаа, туршилтууд хийгдэж байгаа. Тусгайлсан хуулиар зохицуулагддаг учраас сургалтын хөтөлбөрт өөрчлөлт орох, шинэчлэх, өөрчлөгдөхөд бид туршилт хийгдэх тодорхой хугацааны судалгаа, үр дүн, үндэслэл дээр тулгуурлаж байж өөрчлөлт хийж байгаа. Сургуулиуд бие даагаад одоо нэг ээлжийн сургалт үйл ажиллагаа явуулж байгаа сургуулиуд өөрөө ямарваа нэгэн биеийн тамирын үйл ажиллагаа явуулахад татгалзах хориглочихсон зүйл байхгүй байгаа.

**О.Номинчимэг:** Хаана туршиж байгаа вэ саяынхаа тэр хөтөлбөрийг? 1 номер.

**Х.Батжаргал:** Боловсролын яамны Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн дээр энэ хөтөлбөрийн өөрчлөлт, шинэчлэлтүүдийг хийгээд, холбогдох судалгаагаа хийгээд, туршилтын үйл ажиллагаа явуулаад, одоо үр дүнгээ 6 сард Боловсролын яаманд ирүүлээд ингээд хэрэгжилт хангагдах юм шинэ хичээлийн жилээс нэг ээлжтэй сургуулийн хувьд.

**О.Номинчимэг:** Түрүүн энэ Ундрам гишүүний ярьж байгаатай санал нэг байна. Энэ 2019 оны энэ хууль гараад энэ бол бид үр хүүхдүүддээ хөрөнгө оруулах маш том дэвшил хийж чадсан. Тэгээд уг нь тэр хуулиараа энэ чинь 23-аас 24 онд аль хэдийн ахлах ангийнхан хамрагдчих ёстой байсан тийм үү? Гэтэл 2022 оны энэ Улсын Их Хурлын тогтоол дээрээ дулдуйдаад ерөөсөө энэ хэрэгжилтээ хангах талаар дорвитой ерөөсөө ахиц харагдахгүй байгаа. Тэгээд энэ дээр ЗГ, ялангуяа

Сангийн яам маш энэ дээр анхаарах ёстой шүү. Та нар энэ тогтоол гарсанд дулдуйдаад дунд анги, ахлах ангийнхныгаа үдийн хоол хөтөлбөрт хамрагдах ажил дээр ийм цааргалж ерөөсөө хандаж болохгүй гэдгийг нэмээд хэлчихмээр байна. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууя.

**С.Эрдэнэбат:** Өнөөдөр маш чухал асуудал байгаа. Эдийн засаг, төсөв хүнд байгаа ч гэсэн бид нэг хүүхдэдээ өсөж торниж байхад нь уураг тархи нь өсөж хөгжиж байгаа энэ өөрөө нийгмийн эрүүл мэндтэй ч маш чухал холбоотой асуудал л даа. Тийм учраас энэ хүүхдүүдэд олгож байгаа хоолны асуудал 48 хувь нь түрүүн хангалтгүй гэх шиг боллоо. Тийм учраас хүүхдэд олгож байгаа энэ калорийн асуудал дээр бид маш их анхаарал хандуулах ёстой байна. Би сая хөдөөгүүр яваад нэг сумын хоолны газар ороод хүүхдийн хоолных нь байдалтай танилцаж үзсэн. Мах 27, 28, 30 мянга хүрч байгаа үед бид тендерээ зарлаж чадахгүй, орох хүн байхгүй тэгээд махаа яах нь мэдэгдэхгүй гэдэг ийм юм ярьж байна лээ. Тэгээд энэ үнийн индексийг яаж боддог юм бэ, эсхүл порцыг нь хасаж байна уу, яаж байна вэ гэдэг тал дээр асуумаар байна? Яг сургуулийн хүүхдүүдийн махны мэдээж тендер зарлаж байгаа. Тэрийг хэдэн төгрөгөөр бодож байна вэ?

2 дугаарт түрүүн гишүүд хэлж байх шиг байна. Тухайн орон нутгаас нь иргэд өөрсдөө уламжлалт аргаараа бид малаа бэлдээд л ирсэн, заавал нэг компанийг авчирч цех дээр бэлдсэн гээд нэг тийм хөдөө орон нутгийн нөхцөлд таарахгүй юмнуудыг шаардаад байдаг юм байна лээ. Тийм учраас энэ тал дээр нэн яаралтай шууд худалдан авалт гээд л бид янз бүрийн юм хийгээд байдаг. Сумын сургуулийг тэр малчдаас нь шууд худалдаад хямдхан, арай чанартайг нь худалдаад авчих боломжийг нь тэр эрхийг нь олгооч гэдэг зүйлийг, энэ дээр яг юу нь болохгүй байгаад байгаа юм бэ гэдэг дээр асуумаар байна?

2 дугаарт хүний нөөцийн асуудал байгаа юм. Тогооч яах вэ дээ тэгээд хаанаас ч олдчихно гэдэг бодлоор ингээд гэнэн хандаж ирсэн, хувийн хэвшил гүйцэтгүүлнэ гэдэг нэг талаар нөгөө манай боловсрол чинь үйлчилгээнийхээ ажилчдаа хувийн хэвшлээр гүйцэтгүүлнэ гээд. Тэгээд 900 мянган төгрөг дээр ямар тогооч ирэх юм бэ дээ. Яг зах зээл дээр тогооч хамгийн бага цалин нь бараг 1 сая 500 дээр ирэхгүй байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр бид энэ тал дээр хүний нөөц дээр яг ний нуугүй хэлэхэд маш их дутагдалтай. Хоолыг хэн ч хийчхэж болно гэдэг бодлоор хандаж ерөөсөө болохгүй. Тэгэхээр энэ тал дээр тодорхой саналуудыг түрүүн ярьж байна. Тэгэхээр хэчнээн тогооч, мэргэжлийн тогооч дутуу байгаа юм бэ? Хоол зүйч гэдэг орон тоог нь яагаад хасаад хаячихсан юм бэ? Ядаж тэр хоол зүйч гэдэг юун дээр тэр тухайн аймагт гэдэг юм уу, сургуулийн дунд нь гэдэг юм уу тийм орон тоонуудыг байлгахгүй бол бид зүгээр нэг бүдүүн аргаар, бүдүүлэг аргаар нэг гурил, будаа, төмс гурав л голцуу тийм хоол өгөөд байхаар хүүхдүүд чинь ямар ч калори илчлэг байхгүй тийм л нэг юм үзнэ шүү дээ.

Нөгөө талаар хараад үзэхээр хүүхдийн хоолны сургуулийн тендер, цэцэрлэгийн хоолны юман дээр нэг бөөн наана цаана юм болдог юм шиг байна лээ. Нэг талаараа харахад ашигтай учраас хүмүүс орох гээд байдаг юм уу. Тийм учраас энэ тал дээр нөгөө талд нь аваад үзэхээр яг тухайн сургууль өөрсдөө хоол үйлдвэрлэсэн нь дээр байна уу, хувийн байгууллагуудаар хийлгэсэн нь дээр байна уу гэдэг дээр харьцуулсан судалгаа байна уу? Миний зүгээр харж байхад яг сургууль нь өөрсдөө хүмүүсээ ажиллуулаад хийсэн нь хамаагүй илүү чанартай, хамаагүй илүү тэнд нөгөө ашиг хардаггүй учраас байгаад байх шиг байгаа юм. Тэгэхээр энэ тал дээр нэг тодруулга хийж өгөөч гэдгийг хэлмээр байна?

**О.Номинчимэг:** Хэн хариулах вэ? 1 номер Батжаргал дарга, нэг номерын микрофон.

**Х.Батжаргал:** Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Энэ тулгамдаад байгаа асуудлын нэг нь тендер хоолны түүхий эдийн худалдан авалт яах аргагүй мөнөөс мөн. Ялангуяа аймаг, сум орон нутагт. Гэсэн хэдий ч гэсэн бид яах аргагүй төрийн болон орон нутгийн өмчөөр худалдан авах ажиллагааны бараа, үйлчилгээ худалдан авах энэ хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулахаас өөр аргагүй. Нэгэнт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа, шууд худалдан авалтын дүнгээс энэ дүн нь өөрөө давчихдаг. Тэгэхээр энэ Тендерийн хуулиар явахаас өөр аргагүй нөхцөл байдалтай байгаа.

Хоол үйлдвэрлэлийн энэ чиглэлээр энэ түүхий эдийн нөхцөл байдал дээр бид тухайлбал махан дээр жишээ татаад аваад үзэхэд мах намар тодорхой хэмжээнд хаврыгаа бодвол хямдхан байдаг, хавар үнэд ордог. Тэгэхээр энэ үнийн индексийг бид судалж байгаад дунджаар намар, илүү үнэтэй байх боломжийг нь ААН-үүдэд олгож, үнэд орсон үед нь, илүү хэт үнэд орохгүй бол боломжийн зах зээлийн үнэд дөхүүлсэн энэ итгэлцүүрээр тооцож төсөвт суулгаж өгдөг. Хамгийн гол тулгамдаад байгаа асуудал нь юу вэ гэхээр улсын төсвийг намар баталдаг, энэ тооцоолол хийгдээд ингээд явж байгаа. Гэтэл жишээлбэл энэ онд энэ жил огцом махны үнэ зах зээл дээр ингээд нэмэгдэж байгаа. Энэ огцом үнийн энэ өөрчлөлт төсөв батлагдсаны дараа нэгэнт явагдаж байгаа учраас энэ бас нэлээн томоохон сорилттой тулгарч байгаа.

Бид тэгэхээр энэ дээр ямар бодлогын арга хэмжээ авч, эрсдэлийг бууруулж байгаа вэ гэхээр зэрэг тухайн улиралдаа, сардаа худалдан авалт хийнэ гэхээс илүүтэйгээр нэгдсэн том худалдан авалтаа бүтэн жилийнхээ дүнгээр хийх тэр боломжийг ААН-үүдэд олгож, ААН өөрөө эрсдэлээ багасгаж, нөөцөлж хадгалж хаврын үнэд орсон улиралд боломжийн үнээрээ хадгалж байгаад нөөцөлсөн махаа нийлүүлэх энэ боломжийг хангах бодлогыг ирэх жилд хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа. Энэ ч утгаараа бас энд сая танилцуулгад дурдагдсан хуулийн өөрчлөлтөөрөө бид тусгаж оруулж байгаа.

Нөгөөтээгүүр энэ хоолны түүхий эдийн зардал мөнгө улсын төсөв, эдийн засгаас шууд хамаарч байгаа учраас нэмэгдүүлэхэд төдийлөн бэрхшээлүүд гардаг учраас энэ шинэ хууль дээр Боловсролын хөгжлийн сан гэж сангийн Боловсролын зээлийн сангийн хуулийн өөрчлөлтийг томоохон концепцын өөрчлөлт хийгээд, бусад эх үүсвэр зөвхөн улсын төсөв, орон нутгийн төсөв гэлтгүйгээр орон нутгаас гадна төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон нөөц бололцоо, эх үүсвэрүүдийг нэмэгдүүлэх чиглэлээр бол хууль, эрх зүйн боломжуудыг нээж байгаа. Боломж байгаа. Тухайлбал нэг хувийн татварын хөнгөлөлтийг хүүхдийн хоолон дээр нийлүүлэх гэхээр нөгөө хувьсах зардал дотор хоолны зардал маань явж байдаг учраас энэ маань эрх зүйн хувьд илүү тодорхой болгох боломжийг нь нээх шаардлага байгаа. Хоол зүйчийн.../минут дуусав/

**О.Номинчимэг:** 1 номер нэг минут.

**Х.Батжаргал:** Хоол зүйчийн орон тоог хасаагүй. Харамсалтай нь энэ ер нь хүний нөөцийн асуудал ер нь нэг зорилт л болоод байгаа. Ялангуяа орон нутагт маань хоол зүйч, мэргэжлийн тогооч, тогоочийн эрэлт зөвхөн хүүхдийн хоолон дээр

төдийгүй ер нь нийтийн үйлчилгээний энэ салбарт тогоочийн эрэлт маш өндөр байдаг. Маш өндөр цалин 4, 5, тэрнээс ч илүү өндөр цалин амлаад ААН-үүд ресторан, нийтийн хоолонд ажиллуулдаг учраас энэ бол бас нэг томоохон сорилт бэрхшээл болж байгаа.

Хоол зүйчийн тухайд дутагдал байгаа, 8 зуугаад хоол зүйчийн орон тоо, 5 зуугаад орон тоо байгаа боловч бид батлагдсан орон тоогоороо бүрэн ажиллуулж чадахгүй 300 гаруй хоол зүйчийг ажиллуулж байгаа. Орон тоо байгаа, зардал нь байгаа. Мэдээж сая өнгөрсөн жилийн, энэ жилийн төсвийг батлахад үндсэн цалинг 50 хувиар нэмэгдүүлэх боловсролын салбарын энэ арга хэмжээн дээр энэ хоол зүйчид болон бусад албан хаагчдын үндсэн цалинг 50 хувиар нэмэгдүүлсэн байгаа.

**О.Номинчимэг:** Эрдэнэбат гишүүн тодруулъя.

**О.Номинчимэг:** Та 2 зэрэгцэн сууж байгаа нэг нь дутуу орон тоотой гээд түрүүн манай Амартүвшин орлогч хэлэх шиг болсон шүү дээ тийм үү? Тогооч, хоол зүйч дутуу байна гээд байдаг. Нөгөөдөх нь болохоор дутуу биш хүн нь олдохгүй байна гээд яриад байна. Тэгээд энэ тал дээр та нар маань төрийн байгууллагууд мэдээллээ нэгтгээд, Их Хурлын гишүүд нөгөө та хэдийг нийлээд нэг яг энэ тулгамдаад байгаа асуудал нь энэ, энэ байна гэдгийг гарч ирэхийг л хүсээд байгаа юм.

Дээрээс нь нэг зүйлийг хэлэхэд заавал сургууль, цэцэрлэгүүд болгон дээр хоол зүйч байх албагүй шүү дээ. Бүгдэд нь цахимаар онлайнаар хэлж өгөөд заагаад, өнөөдөр миний хүүхэд юу идэж байна вэ гэдгийг эцэг эхчүүд нь хардаг байх хэрэгтэй байна. Мэдээллийг нь нээлттэй байлгаад, зарим хувийн сургуулиуд гэдэг юм уу, хүмүүс чинь өдөр болгон идэж байгаа хоолных нь калори илчлэг юмыг чинь гаргаад ирээд тавиад байдаг. Тийм учраас нөгөө цахим үндэстэн гэж байгаа юм чинь энэ юмаа бид хардаг баймаар байна гэдгийг хэлмээр байна.

Тэгээд түрүүн Номинчимэг гишүүн хэллээ. Тамхины хуулиар бид яг ийм саналыг хэлж байгаа. Хүүхдүүдийнхээ хоолонд зарцуулъя нэмж орж ирэх орлогыг орлогыг нь. Тэгэхээр энэ дээр Сангийн яам, бусад газрууд нь ярьж байгаад энэ гарц гаргалгааг гаргаад ирвэл.../минут дуусав/

**О.Номинчимэг:** 1 номер Батжаргал дарга.

**Х.Батжаргал:** Батжаргал Боловсролын яам нэмж тодруулга мэдээлэл өгье. Яг гишүүний хэлсэнчлэн цахим системийг ашиглах, технологийн дэвшлийг ашиглах энэ үйл явц бол энэ хүүхдийн хоолны тогтолцоо дээр амжилттай хэрэгжээд явж байгаа. Тухайлбал бид сая танилцуулгад гарсан эцэг эхчүүдээс хамтын ажиллагааны хүрээнд мянган төгрөгийг хүүхдийн хоолон дээр хамтарч авч байгаагийн хүрээнд энийгээ хяналтын системээ хоол үйлдвэрлэлийн хүүхдийн цэцэрлэгийн хоолон дээр эцэг эхчүүдтэйгээ хамтраад цахим систем ажиллуулж байгаа. Хувийн хэвшлүүд төр, хувийн хэвшлийн түншлэлээр оролцоод хяналтын цахим систем ажиллуулаад, ямар хоол тухайн өдөр идэж байна, ямар орц найрлагатай байна энэ бүхнийг бүрэн хянаад явах бололцоотой болсон гэсэн үг.

**О.Номинчимэг:** Эрдэнэбат гишүүн нэмэлт тодруулга.

**С.Эрдэнэбат:** Хэзээ эцэг эхчүүд миний хүүхэд өнөөдөр юу идэх вэ, маргааш юу идэх гэж байна вэ гэдгээ харж болдог гэдэг юмыг л хурдан хийчихмээр байна л даа 1 дүгээрт.

2 дугаарт энэ багш цэцэрлэг, сургуулийн энэ багш нарт нэг хоолны мөнгө өгөөд эхэлсэн чинь одоо эргээд хасчихсан. Тэгээд нөгөө хуучин нөгөө ерөнхий юугаар хүүхдүүдийнхээ хоолноос тэгээд аргална биз гэдэг байдлаар явах юм уу, яах юм бэ? Энэ багш нарын, ажилчдын хоолны мөнгийг яг яаж байна өгч байна уу, өгөхгүй байна уу?

**О.Номинчимэг:** 1 номер Батжаргал дарга.

**Х.Батжаргал:** Хоолны мөнгийг хасаагүй байгаа даа.

**О.Номинчимэг:** Хасаагүй гэж байна. Болсон уу? Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя.

**Х.Баасанжаргал:** Би нийслэлээс 1, 2 зүйл тодруулъя Боловсролын яам, ЭМЯ-наас тодруулна. Нийслэлээс энэ нийслэлээс ирсэн энэ мэдээлэл дотор 2 зүйл анхаарал татаад байна. 1 дүгээрт нөөцийн махаар хангахаар ярилцаж байгаа гэж байгаа юм уу, эсвэл нөөцийн махаар хангаад байгаа юм уу? Энэ чинь жоохон анхаарал татаад байна. Энэ яг эрүүл ахуй, шим тэжээл тэр талаасаа болж байгаа юм уу? Тэгээд махны үнэ өссөн гээд хүүхдүүддээ нөөцийн махаар энэ хоол хүнсийг нь хангах гээд байна уу л гэж харагдаад байна 1 дүгээрт энийг нэг тодруулаад өгөөч?

2 дугаарт нийслэлд дотуур байр гэж байгаа. Нийслэлийн мэдээн дээр ерөөсөө нийслэлийн хэмжээнд байгаа дотуур байрны хүүхдийн хоол, шим тэжээлийн талаар мэдээлэл ерөөсөө огт тусгаагүй байна. Энийгээ нэг тодруулж өгөөч гэсэн ийм 2 асуулт байна.

Түрүүн ЭМЯ тэгсэн орон нутагт ялангуяа ханган нийлүүлэлттэй холбоотойгоор 75 хувь нь бараг гурил, будаагаар илүү дүүргэх маягаар шимт хоолны маань бүтэц өөрөө тэгж явж байгаа гээд. Энэ яг бодит байдал, газар дээр очиход ялгаа байхгүй ийм байсан л даа. Увс аймаг, Өмнөговь, Дорноговь гээд хөдөө орон нутгуудаар ажиллахаар орон нутаг болгон харилцан адилгүй хоол тэжээлийнх нь бүтэц харилцан адилгүй. Тэгээд тэр болгон шинэ ногоо, жимс жимсгэнээр хангаад байх боломжгүй ийм аймаг орон нутаг сумд маш их байгаад байна. Тэрийг нь арай нэг ХХААЯ-наас бүтцийн хувьд, зохион байгуулалтын хувьд хийгээд, тээврийн хувьд зохион байгуулалтыг нь ингээд зохион байгуулаад, яг энэ орон нутгийн алслагдмал байгаа энэ сум, аймаг орон нутгийн хүүхдүүдийн хоол, шим тэжээлийн бүтцийг нэг өөрчлөх тал дээр ажил хийж байгаа болов уу, тийм санаачилга байна уу, судалгаа шинжилгээ хийгдэж байна уу гэдэг дээр маш тодорхой хариулаад өгөөрэй?

3 дугаарт яг энэ ирж байгаа тоон мэдээлэл, судалгаанууд дотор дотуур байрны хүүхдийн асуудал тун бага байгаад байна. Хүүхдүүдийн шим тэжээлийн дутагдлын шинжилгээ ч гэдэг юм уу, ийм янз бүрийн шинжилгээнүүд хийхээрээ нийтэд нь хийчхээд байна. Дотуур байрны хүүхдийнхийг та хэд маань нэг ялгаад, ангилаад нэг тусдаа ангилал үүсгээд, тусдаа бүртгэл үүсгээд, өгч байгаа хоол, шим тэжээл нь өөрөө тэр хүүхдүүдийн бие бялдарт хэрхэн тохирч байна, ямар өөрчлөлт гарч байна гэдгийг нь хэмжих тал дээр нэг ажлыг нэг зохион байгуулах тал дээр

санаачилга ажил зохион байгуулалт байгаа юу? Ялангуяа дотуур байрны хүүхдэд бид маш их анхаарал тавих ёстой. Гэрээсээ 200 гаруй хоног гэрээсээ хол суралцаж байгаа ийм хүүхдүүд. Үндсэндээ төр өөрөө бүрэн энэ хүүхдүүдийн эрүүл мэнд, бие бялдрын хөгжлийг нь төр өөрөө хариуцаж авна гээд дотуур байранд байлгаж байгаа хүүхдүүд байхгүй юу. Тэгэхээр зөвхөн хоолоор хязгаарлалтгүй, өөр бусад шим тэжээлийн асуудлыг ч гэсэндээ бид дотуур байрны хүүхдүүдийг анхаарах ёстой гэж хараад байгаа юм. Тэгээд нөгөө ирж байгаа мэдээлэл дотор ерөөсөө дотуур байрны хүүхдийн мэдээлэл тусдаа ангилагдаж ерөөсөө гарахгүй байна. Энэ дээр холбогдох албан тушаалтнууд нь хариулаад өгөөч? Боловсролын яам энэ дотуур байран дээр хариулт өгөөрэй гэж хүсье.

**О.Номинчимэг:** Нийслэлээс 2 номер Амартүвшин дарга.

**А.Амартүвшин:** Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Манай Улаанбаатар хот дээр Хүүхдийн зөвлөл ингээд байгуулагдаад, тэр дундаа энэ хүнсний асуудал дээр онцгой анхаараад зөвлөл дээр асуудлууд шат болгон дээр анхаарагдаад явж байгаа. Нэг дэх том асуудлууд энэ аж ахуйн тооцоот үйлдвэрүүдийн газруудаар дамжуулахгүйгээр энийг хувийн хэвшил рүү хэрхэн, яаж шилжүүлэх вэ, хувийн хэвшилтэйгээ хэрхэн, яаж хамтрах вэ? Бүх газарт, бүх шатанд ингээд төрийн оролцоог ингээд байхгүй болгох, хувийн хэвшилтэйгээ хамтарч ажиллах, төр нь өөрөө стандартаа хангуулдаг, эрүүл ахуйн стандарт, хяналтаа тавьдаг энэ чиглэлээр энэ зөвлөл маань ажиллаад явж байгаа. Энэ зөвлөл дээр гарсан нэг санал нь энэ нөөцийн махны үнэ нэмэгдэлтэйгээр холбогдуулаад энэ нөөцийн махыг хэрвээ ашиглавал яг нөгөө өнөөдөр ашиглаж байгаа бид махтай яахад хэдий хэмжээний калори, эрдэс, энэ тэр дутагдал байх нь уу, байхгүй нь уу гэдэг бол судалгааг зөвлөлийн өмнөөс гаргаад явж байгаа.

Судалгааны дүнг бид авч үзээд ямар ч байсан хүүхдийн цэцэрлэг болон сургуулиуд дээр одоогийн байдлаар зөвлөл дээр танилцуулагдаагүй байгаа. Зөвлөл дээр танилцуулагдсаны дараагаар бид энэ нөөцийн махыг сургууль, цэцэрлэг дээр ашиглах уу, ашиглахгүй юу гэдэг дүгнэлтийг гаргах гээд явж байгаа. Ямар ч байсан бид бүх талын нөгөө судалгаагаа хийгээд явж байгаа. Энэ судалгаа нь яагаад хийгдсэн бэ гэвэл та бүхэн харж байгаа бол 2012 онд хүүхдийн хоол 1650 төгрөг байгаад, мах бол 5 мянган төгрөг байсан. Одоо яг энэ 3 сарын байдлаар бол махны үнэ 28 мянган төгрөг болоод хүүхдийнх нь эцэг эхийн мянган төгрөг нь ороод, ороод 4 мянган төгрөг чүү айтай хүрч байгаа болохоор. Нөгөө нэг энэ дээр юу яаж байна гэхээр нөгөө хүүхэд нэг будаатай шөл дээрээ 10 мах хийдэг байсан бол тэр нь яг энүүгээр хасагдаад 6, 7 хэрчим мах болж хувираад байгаа байхгүй юу. Яг энэ хүнд нөхцөл байдал хаана үүсэж байна гэхээр яг хүүхэд дээр ирж байгаа.

**О.Номинчимэг:** Нэмэлт нэг минут уу? 2 номер нэмэлт нэг минут, гүйцээгээд хариулъя.

**А.Амартүвшин:** Яг энэ нэг энэ махны үнэ, гурилын үнэ, тэгээд ногооны үнэ нэмэгдэхээр хаана энэ дээр тусаад байна гэвэл яг нөгөө цэцэрлэгийн, сургуулийн хүүхдийн хоолон дээр тавигдаж байгаа ширхэг будаа, ширхэг мах, шөлний их, бага хэмжээ, ширхэг төмсний, ширхэг луувангийн тоон дээр л шууд яригдаад явчхаж байгаа. Ийм болохоор ингээд нийслэлээс яг энэ их тоо хэмжээг нь бууруулахгүйгээр ямар арга хэмжээ байна гэдэг бол энэ нөөц дээр судлаад явсан. Тэгээд шинжилгээ, дүгнэлт дээр нөөцийн мах ашигласан нь хэрэггүй гэдэг дүгнэлт гарсан байгаа.

**О.Номинчимэг:** Боловсролын яам нэг номер.

**Т.Түмэнжаргал:** Хоол үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Түмэнжаргал хариулъя. Яах аргагүй гишүүний хэлж байгаа үнэн. Яг дотуур байрны хүүхдийн хоолны шим тэжээлийн асуудал дээр бид онцгойлон анхаарах ёстой. Яагаад гэвэл 24 цаг тэндээ амьдарч байгаа 6-аас 18 насны 35 мянга гаруй хүүхдүүд байж байгаа. Энэ дээр Боловсролын яамны зүгээс ямар арга хэмжээ авч байгаа вэ гэхээр 1 дүгээрт түрүүн би хэлсэн хоолны зардлыг нэмэгдүүлэх асуудлыг бид улсын жил болгоны төсөвт яамны зүгээс саналаа хүргүүлдэг байгаа. 2 дугаарт яг энэ ЭМЯ-наас хийсэн тэр хоол, шим тэжээлийн 6 дугаар судалгаанд бид хамгийн сүүлд 24 онд яг энэ сургуулийн насны, тэр дундаа дотуур байранд амьдарч байгаа өсвөр насны хүүхдүүдийн хоол, шим тэжээлийн байдлын судалгааны үзүүлэлтүүдийг оруулж өгсөн байгаа. Энэ судалгааны дүнгээр яг энэ өсвөр насны хүүхдүүдийн хоол, шим тэжээлийн байдал нь илүү бүүр бага насны, бага ангийн хүүхдүүдээсээ илүү дутагдалтай байна гэсэн ийм дүн гарсан. Ийм учраас бид яаралтай энэ дунд, ахлах ангийн хүүхдүүдийн хоолны асуудлыг шийдвэрлээч гэдэг энэ саналыг удаа дараа ингээд тавиад явж байгаа. 3 дугаарт бид төслийн хүрээнд яг.../минут дуусав/

**О.Номинчимэг:** 1 номер, нэмэлт нэг минут.

**Т.Түмэнжаргал:** 3 дугаарт бид түрүүн хэлсэн, ОУБ-тай хийж байгаа төслийн хүрээнд дотуур байрны хүүхдүүдэд зориулсан яг дотуур байрандаа амьдарч байх үедээ хоол, шим тэжээлийн боловсрол олгох тусгай хөтөлбөрийг бид боловсруулаад 11 аймагт яваад туршаад үзчихсэн байж байгаа. Тэгэхээр энэ хөтөлбөрийг яг сургууль хүүхэд өөрөө дотуур байрандаа амьдарч байхдаа зөвхөн шим тэжээлтэй хоолоор хангагдаад зогсохгүй, эрүүл мэнд яг хоол тэжээлийн боловсролоо яаж авах вэ гэдэг энэ хөтөлбөрийг бид боловсруулаад чиглэсэн ажлыг хийгээд явж байгаа.

**О.Номинчимэг:** ХХААЯ Баасанжаргал гишүүний асуултад 5 номер.

**Т.Жамбалцэрэн:** Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Тэгээд 1 ийм ойлголт байгаад байгаа тэгээд энийг бид аль, аль талдаа зөв ойлгох нь хэрэгтэй байх. Нөгөө нөөцийн мах юу гэдэг юм чанар багатай, муу гэхээсээ илүүтэйгээр бид нөгөө улирлын чанартай энэ ХАА-н салбар маань нийлүүлэлт хийж байгаа, махны салбар мөн ялгаагүй, төмс, хүнсний ногооны салбар мөн ялгаагүй улирлын чанартай байгаад байгаа. Тэгэхээр Хүнсний тухай хуулиараа аймаг, нийслэл, бүх шатны Засаг дарга нар хүнсний хангамж, нөөцөө бүрдүүлэх ийм хуулийн заалттай. Дээр нь орон нутгийн өмчит компани гэдэг юм уу, тухайн орон нутгийнхаа хүнсний хэрэгцээт агуулах зоорь, тэр бусад хатуу, зөөлөн дэд бүтцүүдийг орон нутаг маань өөрөө бий болгомоор байгаа юм.

Тэгээд аймаг орон нутаг болгон өөрөө харилцан адилгүй. Зарим нь МАА дээр суурилсан эдийн засагтай, зарим нь уул уурхай, газар тариалангийн бүс, газар тариалангийн бүс биш гэдэг юм уу, мах, сүүний нийлүүлэлт нь харилцан адилгүй байгаад байгаа юм. Тэгэхээр аймаг орон нутаг байна. Зөвхөн энэ удирдлага менежментийн зохион байгуулалтаас хамааралтай л аймаг орон нутагтаа зохион байгуулалтыг хийх бололцоо, тооцоо, судалгаанууд байж болохоор байгаад байгаа байхгүй юу. Энэ дээр тухайн аймаг орон нутгууд нь ямар бүтээгдэхүүн дээр бид хомсдолтой байна, ямар бүтээгдэхүүн.../минут дуусав/

**О.Номинчимэг:** 5 номер нэмэлт нэг минут.

**Т.Жамбалцэрэн:** Ямар бүтээгдэхүүн дээр зохицуулалт хийж болмоор байна, ямар бүтээгдэхүүн дээр бид хангамжуудыг нэмэгдүүлж болмоор байна гээд. Одоо гурилын шийдвэр гаргаад, бид гурил дээр тодорхой арга хэмжээ авч болж байна шүү дээ баруун бүсүүд дээр. Яг энэнтэй адилхан төмс, хүнсний ногоон дээр намар ургац хураалтын үед нь говийн бүс, тариалангийн бус аймгууд нь тариалан бүхий аймгуудтайгаа гэрээ хэлцлээ хийгээд, холбогдох агуулах зоориныхоо нөөцийг бүрдүүлээд, ногоогоо татан авалтыг хийгээд явчихад үнийн өсөлтөөс хамгаалчих бололцоотой байгаа юм. Махан дээр ч гэсэн бид өрхийн дундаж хэрэглээ намар идэшний цагаар мах шөлөө бэлдээд л хавар болтол, зун болтол хэрэглээд л явж байгаа шүү дээ. Яг энэ хэлбэртэй, махны үнэ хамгийн хямд байдаг 7, 8 сар дээр нь бид агуулах нөөцийнхөө тэр бүрдүүлбэрийг бүрдүүлээд, үе шаттай нь нийлүүлээд явбал бид үнийн хөөргөдөл, инфляц энэ зүйлүүдээс хамгаалах боломж байгаа шүү дээ.

Яг зүгээр ингээд шим тэжээл гээд ярихаар нөгөө нэг хүүхдэд байх илчлэг, шим тэжээл гээд энэ норм норматив маань шинэчлэгдээд гараад ирэхэд, улсын хэмжээнд аймаг, сумаараа хангамж нөөц нь ийм байна, дутагдалтай нь тэд байна, дутагдалгүй нь тэд байна, хоорондоо энийг нь ингэж шилжүүлж болохоор байна гэвэл.../минут дуусав/

**О.Номинчимэг:** Тодруулах уу Баасанжаргал гишүүн? Баасанжаргал гишүүн тодруулъя.

**Х.Баасанжаргал:** Энд нэмээд нэг зүйл тодруулаадахъя. Алслагдмал аймаг орон нутгуудын хэмжээнд байгаа энэ хоол хүнсний дутагдалтай байгаа зарим асуудлуудыг орон нутаг өөрөө менеж шийдэх боломжтой гэдэг утгаар нь хариулж байна уу тийм ээ? Тэрнээс ямарваа нэг байдлаар нэгдсэн бодлого шаардлагагүй гэсэн ийм хариулт өгч байна гэж ойлголоо, зөв үү? Тэгэхээр чинь нөгөө тээвэр, янз бүрийн асуудлууд дээр энэ зардал, нэг хүүхдийн хоолны мөнгө 6 мянга энэ тэр гээд байгаа чинь хэр багтаамжтай байх юм бол? Дээрээс нь манай 21 аймгийн 6 аймаг нь өөрийн орлого, өөрийн төсвөөрөө орлогоо бүрдүүлж байгаа, бусад нь дандаа татаастай байгаа шүү дээ. Тэгэхээр нөгөө бусад аймгуудын нөгөө татаастай байгаа аймгийн хүүхдүүдийн асуудал яах вэ гэхлээр би энэ дээр ийм нэгдсэн ийм нэгдсэн бодлого байж болохгүй юу, ямар нэгэн энэ алслагдмал аймаг орон нутгийн хүүхдүүдийн шим тэжээлийн асуудлыг нэг анхаарсан ийм бүтэц, бодлогын юу байж болохгүй юу л гэж тодруулаад байгаа юм.

Тодруулах нэг зүйл маань энэ эцэг эхчүүдээс мянган төгрөг аваад явж байгаа. Тэгэхээр үүнтэй холбоотой цэцэрлэгийн хүүхдүүдийн хамрагдалтад нөлөөлж байгаа юу гэсэн ийм.../минут дуусав/

**О.Номинчимэг:** Жишээ нь Өмнөговь аймаг, Орхон аймаг эд нар өөрсдөө орлого олдог аймгууд. Энэ аймгууд өөрсдийнхөө бараг орон нутгийн төсвөөрөө энэ хүүхдүүддээ шим тэжээлтэй хоолоор хангах асуудлыг шийдчихээд байгаа байхгүй юу. Тэгтэл татаасгүй, юу татаас авдаг тэр аймгууд чинь ерөөсөө ингээд орхигдчихоод байна. Тэн дээр чинь хүүхдүүд хаана амьдарч байгаагаасаа болоод шим тэжээл нь дутуу хөтүү, янз бүр болоод байна шүү дээ. Хүүхдүүдийн өсөлт ч гэсэн өөр байна гээд энэ дээр бодлого гаргаж байгаа юм байна уу, харж байгаа шийдлүүд байна уу гэдэг маш чухал асуулт байна. Хэн хариулах вэ? Бодлогын

уялдаа холбоо иймэрхүү асуудал дээр ЗГ дотроо ярилцаж байгаа асуудлууд байна уу? Одоо сайдууд нь байхгүй болохоор. Дараагийн асуулт нь юу байлаа? Тийм цэцэрлэгийн хамрагдалт эцэг эхчүүдээс авч байгаа мөнгөнөөс хамаараад хэр яаж байна вэ? Нэг номер Боловсролын яам. 1 номерын микрофон.

**Т.Түмэнжаргал:** Энэ дээр бид нийслэл Улаанбаатар хотод хэрэгжүүлээд эхэлсэн байгаа. Энэ дээр түрүүн ТНБД-ын мэдээлэлд дурдсан бид 10 хүүхдийн 4-ийг нь зорилтот буюу Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу улс 100 хувь бүрэн санхүүжүүлж байгаа. 6-аас нь эцэг эх, 6 хүүхдийн эцэг эхээс мянган төгрөг буюу сард 22 мянган төгрөгийг аваад явж байгаа. Энэ дээр бид түрүүн судалгаа хийсэн талаар та бүхний мэдээлэлд товчхон дурдсан байгаа. Энэ дээр ямар нэгэн цэцэрлэгийн хамрагдалтад сөрөг нөлөө үзүүлсэн юм байхгүй. Харин ч эсрэгээрээ эцэг эхийн оролцоо, хяналт сайжирснаараа хүүхдийн хоолны шим тэжээлийн байдал сайжирсан 1 дүгээрт. 2 дугаарт бид цэцэрлэгийн хүүхдийн хоолны мөнгийг эцэг эхээс авах, хяналт тавих, буцаагаад түрүүн таны хэлдэг нөгөө эцэг эхэд мэдээлэл хүргэж байна уу гээд энэ байдлыг бүгдийг нь хувийн хэвшлийн цахим системтэй хамт хийж байгаа болохоор ил тод, хяналтын байдал сайжирснаар хүүхдийн хоолны шим тэжээлийн байдалд ахиц гарсан, сайн байгаа. Тийм учраас бид энийг улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр ЗГ-ын тогтоолын төсөл.../минут дуусав/

**О.Номинчимэг:** Бид Өргөдлийн байнгын хороо удахгүй хуулийн өөрчлөлт орвол ЗГ чиглэл өгдөг Байнгын хороо болно. Тэгэхээр яг ийм салбар дунд хаягдаад байгаа, өнөөдөр асууж байна шүү дээ хүүхдийн хоолны шим тэжээл чинь бүс нутгаасаа хамаараад өөр байна, тухайн орон нутгийнхаа орлогоос хамаараад өөр байна энэ дээрээ бид тэгвэл алслагдмал эсвэл тэр татаастай байгаад байгаа аймгууд дээр ямар бодлого байх юм бэ гэхээр ХХААЯ ч хариулж чадахгүй, Боловсролын яам нь ч хариулж чадахгүй, ЭМЯ нь ч хариулж чадахгүй. Тэгэхээр нөгөө салбар хоорондын уялдаа холбоо гэдэг юм бодлого гарах үед ингээд уялдаагүй байгаагийн л шинж. Ийм асуудлуудыг бид Өргөдлийн байнгын хороон дээр авчирч байгаад шийдэж байгаа. Тэгэхээр ийшээ чиглэсэн ЗГ-т чиглэл өгсөн ийм арга хэмжээнүүдийг бид Өргөдлийн байнгын хорооноосоо хийх ёстой юм байна гээд харж байна.

Дараагийнх нь Лувсанжамц гишүүн өөрийнхөө байрыг дарааллыг Бейсен гишүүнд хүндэтгээд, ажилд яарч байгаа учраас гээд өгч байгаа. Тэгэхээр Лувсанжамц гишүүн Бейсен гишүүний байрыг, асуух дарааллын байрыг манайхан өөрчлөөрэй. Бейсен гишүүний микрофоныг өгье.

**Б.Бейсен:** Энэ цэцэрлэг, сургуулийн хүүхдүүдийн хоол үйлдвэрлэлийн үйлчилгээний талаар яамнуудаас ирсэн дүгнэлт, саналтай танилцлаа. Ерөнхийлөгчийн хүнсний хувьсгалын хүрээнд хүнсний аюулгүй байдалтай холбоотой нэлээн асуудал байгаа. Хавдрын ихсэлтийн 80 хувь нь хүнсний аюулгүй байдал алдагдсантай холбоотой, хавдар залуужиж байгаа. Ялангуяа цэцэрлэг, сургуулийн насны хүүхдүүд дээр байгаа. Энэ талаар ер нь аль заалтыг нь баримталж байна вэ та нар хяналт тавьж байна ЭМЯ, ХХААЯ? Энэ дээр чинь нэг заалт байгаа, эх орны хөрсөнд ургасан эрүүл хүнсний ногоогоор хангах гээд нэг асуудал байгаа. ЗГ-аас сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн хоолны төсвийг хангалттай тавьж байгаа. Гэтэл урд хөршөөс орж ирсэн хүнсний ногоог аваад зах зээл дээр шахдаг асуудал нууц биш байж байгаа.

Хөдөөгийн сургуулиудаар явж үзэхэд хоолны газар дотуур байр бараг гоймон хэрэглэдэг, төмс байвал төмс л хийнэ, өөр юм байхгүй, сонгино хийдэг, ийм дотор байрны 150-аас 250 хүүхэдтэй дотор байруудаар бид орж үзсэн. Энэ тал дээр ер нь хяналт, хоолны илчлэг, чанар дээр хяналт хийж үзсэн үү? Хэчнээн төрлийн ногоо, хүнс хэрэглэж байна вэ?

Дараа нь энэ хүнсний хангалт, худалдан авалтын асуудал дээр тендерийн асуудал байж байгаа. Мөн тендер авч байгаа байгууллагууд мөн адилхан тийм хүнсийг өндөр үнээр зах зээлийн үнээр шахдаг асуудал байгаа. Дараа нь энэ хоол үйлдвэрлэл орчныг сайжруулах гээд байгаа. 77 сургуулийн хоолны газрын 479 стандарт шаардлага хангасан, 248 стандарт шаардлага хангахгүй байна. Энэ байр юм уу, хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж байхгүй байгаа юм уу? Энэ дээр шалгалт хийж үзсэн үү?

Хүний нөөц бэлдэх асуудал дээр Боловсролын яамнаас асууя. Хэчнээн сургууль энэ хоол зүйч, тогооч бэлдэж байна вэ? Хөдөөд ер нь 45 хоногийн курс төгссөн улсууд тогооч хийж байгаа шүү дээ. Энэ дээр анхаарч байна уу?

Дараа нь энэ сургууль, цэцэрлэгийн хүнсний худалдан авалт дээр 444,9 сая төгрөгийн хэмнэлт гарсан гэсэн байна. Гол нь энэ юун дээр гарсан юм бол энийг асууя?

Дараагийн асуудал ЭМЯ-наас эрүүл ахуйн шаардлага хангасан төрөлжсөн агуулахтай, түүхий эд болон хүнсний тус тусад нь хаяглаж, зохих хэмд хадгалах хяналт тавьдаг.../минут дуусав/

**О.Номинчимэг:** Бейсен гишүүн нэмэлт нэг минут авъя.

**Б.Бейсен:** Энэ дээр 25 хувь гэсэн байна. Тэгэхээр чинь энийг чинь яаж гарсан, үзсэн 75 хувь нь шаардлага хангасан тийм агуулах түүхий эд, хүнсний ногоо хадгалах юм байхгүй байгаа юм уу? Энэ талаар асууя.

**О.Номинчимэг:** Хэн хариулах вэ? 5 номер Жамбалцэрэн ТНБД.

**Т.Жамбалцэрэн:** Бейсен гишүүний асуултад хариулъя. Зөвхөн 2025 онд хичээлийн жилийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд улсын хэмжээнд 593 боловсролын байгууллагад хяналт шалгалт хийсэн. Энэ дотор орон нутгийн 452, нийслэлийн 141 сургууль урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад хамрагдсан. Нийт шалгалтаар 1787 зөрчил илэрсэн, үүний 41,9 хувийг газар дээр нь арилгуулж, үлдэж байгаа хувийг нь гүйцэтгэлийн хяналт хийж, дахин зөрчлийг дутагдлыг арилгуулах чиглэлээр ажилласан. Энэ чиглэлээр улсын байцаагчийн 176 албан шаардлага, 688 заалт бүхий 108 зөвлөмжийг тухайн байгууллагуудад хүргүүлж, үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авсан. Илэрч байгаа зөрчил дутагдлыг задлаад үзвал 33,7 хувь нь хүнсний бүтээгдэхүүний төрөлжсөн агуулах, зориулалтын нөөцийн сав байхгүй, 25 хувь нь хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангалтгүй, 21,9 хувь нь технологийн карт, шим тэжээлийн үзүүлэлтээ бүрэн баталгаажуулаагүй ийм нөхцөл байдалтай, 17,9 хувь нь хэрэглэж байгаа энэ хүнсний нэмэлт амтлагч бусад бүтээгдэхүүн нь бүртгэлгүй, баталгаажилтгүй байсан ийм асуудал хяналт шалгалтын явцад илэрсэн.

Тэгэхээр цаашид энэ аюулгүй байдлын энэ үзүүлэлтүүдийг нягталж шалгах энэ лабораторийнх нь тогтолцоо, энэ мэргэжилтэн ажилтных нь боловсон хүчнийг сургах, чадавхжуулах ажлууд зайлшгүй хийх шаардлага байгаад байгаа юм. Яг ингээд орон нутагт энэ орон нутгийн сургуулийн хүүхдийн хүнсний хангамжийг тогтвортой нийлүүлнэ гээд ингээд явахаар орон нутаг дээр юу гэдэг юм анхан шатны цехээс авхуулаад хадгалалтын тийм сав суулгууд байхгүй байгаад байгаа юм. Түрүүн яагаад тэр орон нутгууд дээр бид тооцоо судалгаагаа маш сайн хийх ёстой, удирдлага зохион байгуулалт менежментээ сайжруулах ёстой гээд байгаа нь орон нутаг өөрөө энэ дээрээ тооцоо судалгаагаа маш сайн гаргаад, манай бүс нутаг, манай аймаг ийм, ийм нөхцөл байдлуудтай байна, энэ хүнсний бүтээгдэхүүний хангамж нь дутуу байна, ийм зорь сав нь дутмаг байна. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар бид энийг нь шийдэх бололцоотой. Дотоодын ААН-үүдээ зохион байгуулаад жижиг, дунд үйлдвэрлэл бусад энэ хүнсний хөтөлбөрүүдэд ингээд, ингээд хамрагдах бололцоотой гэдэг агуулгуудаа гаргаад ирвэл энэ чиглэлээр нь салбарын яам ажиллах бололцоотой байгаа юм гэдгийг хэлээд байгаа юм.

Хүнсний хөтөлбөрийн хүрээнд 44 ААН Ерөнхийлөгчийн санаачилсан хөтөлбөрийн хүрээнд ААН-үүдээс хөнгөлөлттэй зээл авсан. Нийтдээ 73 тэрбум төгрөгийн. Энэ дотроо анхан шатны боловсруулалт хийсэн болон бэлэн боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор авсан байгаа. Мах, сүү, жимс жимсгэнэ, бусад хүнсний бүтээгдэхүүнийг сургууль, цэцэрлэгийн хэрэгцээнд нийлүүлэх зориулалтаар энэ зээлүүдийг авсан. Эдгээр зээл авсан 44 ААН-ээс 6 ААН нь нэмэгдэж энэ сургууль, цэцэрлэгийн хоол нийлүүлэх энэ.../минут дуусав/

**О.Номинчимэг:** ЭМЯ-наас асуусан 3 номер Очирбат дарга.

**Д.Очирбат:** Хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналтыг манай салбарын хяналтын байгууллага эрүүл мэндийн хяналтын байгууллагууд хянадаг. Хөдөө орон нутагт, ялангуяа орон нутгууд, аймгуудын түвшинд энэ ундны усны асуудал их хөндөгддөг. Тэгээд ундны усны хэрэглээ, ундны усны хэрэглэж байгаа агуулах сав, нөгөө нэг цэнхэр сав, хяналтгүй будаг, хүнсний биш бүтээгдэхүүн агуулдаг саванд маш их ус, усны нийлүүлэлт, усны хангамжийг хангадаг. Мөн дээрээс нь орон нутгийн холбогдолтой болон орон нутгийн онцлогтой холбогдолтой давс, давсны хэрэглээ, шүлт, шүлтлэг бодисын хэрэглээ, дээрээс нь дахиад түрүүний би нөгөө тоон баримт дээр хэлж байсан хэтэрхий их олон нүүрс усны хэрэглээтэй газруудаас. Хөдөө орон нутаг дахь жишээлбэл хүнсний бүтээгдэхүүн, хүнсний хүүхэд.../минут дуусав/

**О.Номинчимэг:** Боловсролын яам нэг номер.

**Т.Түмэнжаргал:** Гишүүний асуултад хариулъя. Түрүүн тэр 446 сая төгрөгийн үр ашиг гарсан гээд. Энэ нь өөрөө хүнсний худалдан авалтыг цахим дэлгүүрт шилжүүлсэн буюу ААН-ээс шууд сургууль, цэцэрлэг захиалга хийгээд авахлаар ийм хэмнэлт гарч байна гэсэн үг. Өөрөөр хэлбэл бид мах махан бүтээгдэхүүн жишээлбэл гэхэд маш олон дамжлага дамжсан ийм өртөг шингэчихсэн ийм бүтээгдэхүүн сургуулиуд дээр ирж байгаа. Энэний оронд бид цахим дэлгүүр буюу ерөнхий гэрээгээр шууд ААН-тэй хагас боловсруулсан байдлаар бүтээгдэхүүнийг авахад ийм мөнгөний зөрөө буюу хэмнэлт үүсэж байна. Тийм учраас цаашдаа ер нь сургууль, цэцэрлэгийн хүнсний худалдан авалтыг ААН-ээс баталгаатай хүнсний бүтээгдэхүүнээс шууд худалдан авах энэ бодлого руу Боловсролын яам явж байгаа. Ер нь энэ дээр тодруулаад хэлчихэд сургууль, цэцэрлэгийн зөвхөн хүнсний хоол,

хүнсний хангамж гээд тусдаа аваад үзэх биш, энэ өөрөө хүнсний хүн амын хүнсний хангамжийн нэг хэсэг байхгүй юу. Тийм учраас энийг ерөөсөө хүнсний.../минут дуусав/

**О.Номинчимэг:** Бейсен гишүүн тодруулъя.

**Б.Бейсен:** ХААЯ-ныхан, Боловсролын яам хоорондын салбар хоорондын ажиллагаа муу байна л даа. Эх орны хүнсний ногоо тариалагчдын ногоог авдаггүй өнгөрсөн жил гадагшаа их гаргасан. Тийм учраас ХААЯ-тай ярьж байгаад эх орны хөрсөнд ургасан, эрүүл хүнсний ногоогоор хангах боломж бий юу? Төсвийг нь Засгаас тавьж өгч байгаа шүү дээ. ХААЯ-ныхан надад санал тавиад яадаг, Боловсролын яамныхан гэтэл ингээд тендерийн асуудал гээд ингээд алга болдог. Нөгөө талаар өдрийн хоол дээр тахианы мах гээд гормон их хэрэглэдэг таргалуулах гээд, тэрийг нь дутуу боловсруулаад хүүхдүүд иддэг, гурилан бүтээгдэхүүн. Энэ дээр судалгаа хийсэн үү, гол нь юутай холбоотой байна вэ?

**О.Номинчимэг:** 5 номер ХХААЯ-ны ТНБД. 5 номер хариулъя микрофон нээсэн байна.

**О.Номинчимэг:** ХХААХҮЯ-ан дээр нь тахианы махны энэ чиглэлээр судалгаа байхгүй шүү дээ. Энэ Эрүүл мэндийн яам.../минут дуусав/

**О.Номинчимэг:** Эхний асуулт нь танайх руу байх. Хүнсний бүтээгдэхүүнээр хангах тэр юу, тариаланчдыг дэмжээд, тэрийгээ шууд нийлүүлдэг тийм юм хийж болохгүй юу гэж хүүхдийн хүнс. 5 номер хариулъя.

**Т.Жамбалцэрэн:** Тодорхой орон нутгууд маань захиалгаа ирүүлчихвэл бид захиалгын дагуу нийлүүлэлтийг хийх бололцоотой байгаад байгаа юм. Яагаад түрүүн улирлын хамаарал их байна гээд намар бид ургац хураалтын үед хүнсний ногоо хамгийн үнэ бол хамгийн доод цэгтээ хүрдэг. Газар дээрх үнэ маш хямдхан байдаг. Энэ үед нь орон нутгууд хоорондоо тухайн аймаг, сум хэрэгцээгээ тооцоод, хоорондоо захиалгат тариалалтыг хавар нь тариалалтыг хийгээд, намар нь захиалгат тариалалтынхаа хүрээнд ургацаа хурааж аваад, тэрийгээ хадгалж нөөцлөөд, тухайн орон нутгийнхаа хүнсний хангамж, тэр сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийнхээ хоолонд нийлүүлэх боломж нь бүрэн байгаа. Тэгэхээр бид яг энэ нөгөө захиалгатай тариалалт, захиалгатай энэ улирлын хамааралгүй энэ салбарыг л хөгжүүлэх чиглэлд салбарын яам хүнсний бүтээгдэхүүнийхээ нийлүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэл дээр илүү төвлөрч ажиллаад байгаа юм. Тэгээд энэ чиглэл дээр нөгөө орон нутгийн менежмент нь нэлээн чухал байна гэдэг нь яг энэ ажлуудыг салбарын яамнаас зохион байгуулах бүрэн бололцоотой байгаа л гэдгийг хэлэх гэсэн юм.

**О.Номинчимэг:** 2 номер нийслэл Амартүвшин дарга.

**А.Амартүвшин:** Бейсен гишүүний асуултууд гялс би нийслэлийн зүгээс товч хариултуудыг өгөөд явчихъя гэж бодлоо. Хавдрын түвшин гэвэл хоол боловсруулах эрхтний хавдар бол манай Монгол Улсын хэмжээнд 2-т орж байгаа. Нэгд элэг байгаа, 3-д умайн хүзүү байгаа. 2-т 2024 онд гэхэд 2115 хүн хоол боловсруулах эрхтний хавдартай гээд оношлогдсон, 2025 онд 2130. Ерөнхийдөө хоол боловсруулах эрхтний хавдар бууж байгаа ямар нэгэн тоо статистик байхгүй, бараг есөх магадлалтай байгаа. Энэ юутай холбоотой гэвэл шууд хоол хүнстэй их

холбоотой. Шууд хоол хүнс нь юутай холбоотой байна гэхээр бид хоол боловсруулах эрхтний хавдар нь өөрөө шууд 1, 2 өдрийн дотор үүсдэггүй. Цэцэрлэгтээ ямар хоол хүнс хэрэглэж байсан, сургуульдаа ямар хоол хүнс хэрэглэж байсан гэдэг нь явсаар байгаад яг нөгөө их сургуульд ороод, ажиллах хүчин болоод гарч ирэхээр ажлын хаалганы үүд биш, эмнэлгийн хаалганы үүд татдаг ийм нөхцөл байдал үүсчхээд байгаа. ЗГ-аас та ЗГ-аас баталж өгсөн.../минут дуусав/

**О.Номинчимэг:** 2 номер нэг минут.

**А.Амартүвшин:** Засгийн газар дээр баталж өгсөн төсөв нь хангалттай гэсэн, түүн дээр би тантай бол нэг санал нийлэхгүй байгаа. Яагаад гэвэл 3 мянган төгрөг бол яаж ч хангалттай биш байгаа. Судалгаагаар бид авч үзэхэд цэцэрлэгийн бага ангийн хүүхдийн өдрийн бид калори болон юуг хангахад 4800 төгрөг хэрэгтэй. Цэцэрлэгийн дунд ангийн хүүхдийг харахад 5500, цэцэрлэгийн ахлах ангийн хүүхдийг хангахад 8600 төгрөг хэрэгтэй байна. Тэгээд дунд, бага анги руу ороод ирвэл 9200, 2 дугаар ангийн хүүхэд дээр болохоор 13 мянга төгрөг рүү ороод байна. Яагаад гэвэл хүүхдийн хөдөлгөөн, хүүхдийн өсөлт, шаардлагатай байгаа витамин гэдэг зүйлүүд нь өөрсдөө ийшээ орж ирж байгаа юм. Тэгээд үнэ нь яагаад нэмэгдээд байна гэхээр өнөөдрийг хүртэл бид чигжигч хоолоор хүүхдүүдээ хангаж байгаа. Будаа, төмс гээд дандаа тийм чигжигч цатгагч, идээд цадсан тийм мэдрэмж төрүүлдэг ийм хоолоор л хүүхдүүдээ хангаж байгаа. Нөгөө нэг витамин, нөгөө нэг эрдэс дэм гэдэг зүйлүүд маань ерөнхийдөө энэ мөнгөндөө багтаад байхгүй болчихоод байгаа. Яагаад тэд нар нь дандаа үнэтэй учраас нөгөө тараг сүү гээд.

**О.Номинчимэг:** ЭМЯ 3 номер.

**Д.Очирбат:** Хоол тэжээлийн тухай 6 дугаар судалгаан дээр зарим нэг дүгнэлтүүд гарсан байдаг. Судалгаагаар хүүхэд залуучуудын дунд тахианы хэрэглээ, тахианы махны хэрэглээ, ялангуяа түргэн хоол, хагас боловсруулсан бүтээгдэхүүн их огцом хэрэглээтэй болсон тэмдэглэсэн байдаг. Илүүдэл жингийн талаар тахианы мах өөрийн уургийн эх үүсвэр боловч түүнийгээ маш их бохирдолтой юм уу, эсвэл халуун тосонд боловсруулсан, шарж боловсруулсан, өндөр илчлэгтэй соустай хамт хэрэглэх нь хүүхдийн таргалалтын болон энэ дотоод бүтцийн асуудлуудад их нөлөөлдөг. Дээрээс нь дахиад эрүүл мэндийн салбар, салбарын хяналтаас энэ саяын хэрэглээнийхээ зэрэгцээгээ пестицид буюу энэ нэмэлт бүтээгдэхүүн энэ удаашруулж хадгалах зориулалттай химийн боловсруулалт зэргийг судалгаандаа гаргаж тавьсан байдаг. Сүүлийн.../минут дуусав/

**О.Номинчимэг:** Дүгэрийн Рэгдэл гишүүн асуулт асууя.

**Д.Рэгдэл:** Баярлалаа. Энэ 5 газрын мэдээлэл сонслоо. Тэгэхдээ зэрэг энэ хуулийн хэрэгжилтийг хариуцдаг их олон яам, тэгээд нутгийн захиргааны бүх байгууллагууд гээд олон газар байдаг юм байна. Энийгээ нэг нэгтгээд, дүгнээд мониторинг хийж байгаад авах арга хэмжээнийхээ талаар нэгдсэн санал боловсруулаад ирэх нь ямар боломж байдаг юм бол? Энэ талаар та бүхэнд нэг хариулж өгөөч.

Энэ 19 онд батлагдсан хууль маань энэ чинь 2008 оноос үндсэндээ эхэлсэн шүү дээ энэ сургуулийн хүүхдийн үдийн хоолны асуудал чинь, 2008 оноос ярьж явсаар байгаад ингээд 10 гаруй жилийн дараа хууль гараад, тэгээд одоогийн

байдлаар бас ч яах вэ 350-аад мянган хүүхэд энэ үдийн хоолонд хамрагддаг юм байна гэсэн ийм мэдээлэл байна. Тэгэхдээ энэ чинь энэ хууль гараад ингээд 5 жил, 6 жил ч болж байгаа юм уу даа энэний дараа, дараа нь 22 онд нөгөө Улсын Их Хурлын тогтоол гарсан 36 дугаар тогтоол. Тэгээд тэн дээр энэ хуулийг шинэчлэх талаар тодорхой заачихсан байхад одоо ер нь хуульд нэмэлт, өөрчлөлтийн асуудлаар санал боловсруулж байгаа төдий байгаа чинь тун хариуцлагагүй удаан ажиллаж байна гэсэн үг. Яагаад гэвэл шинэ хууль гараад ирсэн, хэрэгжилтийн явцыг нь харж байгаад энд хурдан өөрчлөлт оруулж явахгүй бол энд их дутагдал гарахаар байгаа юм. Нэг ийм юм байна.

2 дугаарт энэ хэний Боловсролын яамны мэдээллээс харахад нэг аймшигтай тоо харагдаад байгаа юм. Энэ дотуур байрны хүүхдийн хоол нь илчлэг шим тэжээлийн 60-аас 70 хувийг хангаж байна гээд байгаа юм. Энэ чинь аймшигтай тоо шүү дээ. Зүв зүгээр хэлээд явчих юм. Энэ чинь 24 цагаар амьдарч байгаа тэр хүүхэд дандаа ийм маягаар хооллоод байвал тэр чинь ер нь юу болж хувирах вэ, энэ үнэн тоо юу, худлаа тоо юу? Энэ дээрээ нэг сайхан тайлбар хэлж өгмөөр байна.

ЭМЯ-ны мэдээлэл дээр бас л жаахан эргэлзээтэй тоо яваад байх юм. Энэ үдийн хоолны нийт илчлэг нь 394 калори юм байна. Зүгээр миний бодож байгаагаар энэ насны хүүхдүүд 1-ээс 5 дугаар ангийн хүүхдүүд ер нь хамгийн багаар бодоход өдөрт 2 мянган калориос л доошгүй илчлэгтэй хоол авч байх ёстой 1 дүгээрт. 2 дугаарт тэр хоолон дотор энэ чинь 17,5 гр уураг авдаг юм байна. Ер нь ингээд бодоход энэ өсвөр насны хүүхдүүд 50 гр-аас доошгүй уураг хоногт авахгүй бол өсөлтийн хэрэгцээ хангахгүй. Тэгэхдээ зэрэг үнэхээр энэ хоолны мөнгөөр чинь энэ дайны хоол өгсөн болоод ингээд яваад байдаг юм бол энийгээ тэр хэрэгцээ энэ тэрд нь үржүүлж барьж байгаад Сангийн яамандаа, ЗГ-таа яг бодитойгоор энэ хүүхдүүдийн үдийн хоолонд ийм мөнгө хэрэгтэй байна гэдгээ нэг танилцуулаад ингээд явж болдоггүй юм уу? 394 калори үдийн хоолонд өгнө гэдэг үнэхээр дэндүү бага. Энийг Очирбат дарга бүр сайн мэдэж байгаа байх. Тэгээд манай хүн амын чинь 1/3 нь бараг.../минут дуусав/

**О.Номинчимэг:** Боловсролын яам эхлээд тэр дотуур байрны хүүхдүүдийн шим тэжээл дээр та хэд дорвитой, энэ маш сэтгэл эмзэглүүлэм тоонууд гараад байх юм. 1 номер.

**Т.Түмэнжаргал:** Дотуур байрны хүүхдийн хоолны зардал бид 24 онд 6-аас 6300 төгрөгөөр мөрдөж явж байгаа гэсэн. Түрүүн би хэлсэн. Энийг яг 100 хувь хангуулахад 9-өөс 11 мянган төгрөг болох шаардлагатай байгаад байгаа байхгүй юу. Тийм учраас бид энэ мэдээлэл дээр энэ хүүхдийн хоол, шим тэжээлийн дутуу байна 60-аас 70 хувийг л аваад байна, 24 цаг буюу 2400 калори авах ёстой 100 хувь. Гэтэл энэнийхээ 60-аас 70 хувийг дотуур байрны хүүхдүүд аваад байгаа учраас энэ дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байна гэдэг асуудлыг л хөндөж тавиад байгаа юм.

**О.Номинчимэг:** Та хэд 60-аас, юу энэ дотуур байрны хүүхдийн зардлыг 6300-аас одоогийн хэлээд байгаа 9-өөс 10000 нэг хүүхэд дээр болгоход жилийн төсөв дээр нэмэлт хэдэн тэрбум хэрэгтэй байгаа юм бэ, тэр тоогоо тооцоолсон уу?

**Т.Түмэнжаргал:** Тооцоолсон байгаа энэ дээр.

**О.Номинчимэг:** 1 номер хариулъя.

**Т.Түмэнжаргал:** Дотуур байран дээр чинь хэд байгаа билээ? Би тэрийг юу яаж байгаад хараадахъя, тооцоо нь гарчихсан байгаа.

**О.Номинчимэг:** Тэрийг яаж байх зуур 3 номер Очирбат дарга ЭМЯ-наас Рэгдэл гишүүний асуултад хариулъя.

**Д.Очирбат:** Рэгдэл гишүүний асуултад хариулъя. Манай яаман дээр гарсан судалгаанаас яг тийм байгаа юм. Энэ 394,7 килокалорийг л дунджилж авч байна гэж. Хамгийн багадаа хүүхэд 1200 килокалорийг авч байх ёстой. Тэгээд энэ хоолных нь бүтцэд түрүүн гарсан уураг 17,5-хан хувийг нь эзэлж байгаа юм. Тэгээд нүүрс ус, өөх бол ерөөсөө 12-хон грамм. Тэгээд түрүүний энэ 394-өөсөө 54 буюу бүр илүү 2, 3 дахин илүүг нь нүүрс ус нөгөө гурилан бүтээгдэхүүн бүтцэд нь ороод байгаа юм.

**О.Номинчимэг:** Дүгэрийн Рэгдэл гишүүн нэмэлт асуулт тодруулга.

**Д.Рэгдэл:** Тэр тоог харж байгаа, би бас энд хараад байгаа юм. Ер нь энэ чинь онолоороо яах вэ илчлэгийнхээ 50 хувийг нүүрс уснаас, 30 хувийг нь уургаасаа, 20 хувийг нь өөх тосноос авч байхад ер нь хэвийн гэж үзэж болно. Хэвийн гэж үзэж болно. Тэгэхдээ зэрэг энэ пропорц бол их нэлээн алдагдчихсан. Нүүрс ус нь нэлээн давамгайлаад явчихсан байгаа гэдэг гарт мэдэгдэж байгаа юм. Зүгээр энэ дээрээ тооцоод, хэвийн байдлаар үдийн хоолонд яг энэ өсвөр насны хүүхдэд үдийн хоолонд хэдэн килокалори 50 хувиар бодоход арай 600 гэвэл арай багадмаар юм шиг л бодогдоод байна, шаардлагатай байдаг юм бэ? Энэ үдийн хоолны энэ илчлэгийн хэмжээг хангахад, уургийн чанарыг хангахад ямар зардал шаардагдах юм бэ, энэ талаар тодорхой тоо баримт гаргаад, Сангийн яамандаа танилцуулаад, ингээд явж байсан тохиолдол ер нь байна уу? Энэ төсөв дээр энэ анхаарч үзэхгүй бол энэ хүүхдийн үдийн.../минут дуусав/

**О.Номинчимэг:** ЭМЯ 3 номер Рэгдэл гишүүний асуултад хариулъя.

**Д.Очирбат:** Тийм, ер нь манай ингээд хоолны, үдийн хоолны дундаж илчлэгийг 397 байна л гэж хараад байгаа юм. Тэгэхлээр оройны хоолон дээрээ тодорхой хэмжээгээр арай бага хэмжээтэйгээр л илчлэг авах нь. Тэгээд дунджаар 600, 700 илчлэг килокалоритой байна гэж. Ер нь хүүхэд сургуулийн өмнөх насны хүүхдийн үдийн хоолны килокалорийн авах хамгийн доод талын илчлэг 1200 л байх ёстой. Энэнээсээ доош орвол нөгөө тураал буюу жин буурна. Дээшээ 2400-аасаа дээш килокалоритой илчлэгтэй хоол идвэл жин нэмэгдээд жингийн илүүдэл үүсээд байна л гэж харж байгаа юм.

**О.Номинчимэг:** 1 номер дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг яг тулсан хэмжээнд нь нэмэхэд нэмэлт хэдэн тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай байна гэж байгаа тооцоолол нь. 1 номер Боловсролын яам.

**Т.Түмэнжаргал:** Одоо байгаа нормативаар 60 тэрбум гэсэн улсын төсөв дээр суусан байгаа. Саяын миний хэлдэг 9-өөс 10 мянган төгрөгөөр нэмэгдүүлэхэд нэмэлтээр 32 тэрбум төгрөг шаардлагатай зөвхөн дотуур байрны хүүхдийн 35 мянган хүүхдийн хоолны зардал гэсэн үг.

**О.Номинчимэг:** Монгол Улсын төсөв нэг их тийм чамлахааргүй төсөв шүү дээ. Тэгээд нэг хэдхэн тэрбум 32 тэрбум гарчихвал Монгол Улс дампуурчих гээд

байгаа юм байхгүй. Инфляцтай холбогдоод бүх юмаа нэмээд явдаг, яахаараа хүүхдүүддээ өгч байгаа хоолон дээрээ мөнгө харамлаад байгааг би ерөөсөө ойлгохгүй байгаад байгаа. Отгоны Саранчулуун гишүүн асуулт асууя.

**О.Саранчулуун:** Сайн байцгаана уу. ЭМЯ-наас эхлээд тодруулъя. ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4-ийн заалтад юу гэж заасан байдаг юм бэ? Тэгээд үүний хариулт дээр яахлаараа нярай хүүхдийн мэдээлэл явж байдаг юм бэ гэдгийг тодруулах гэсэн юм. Ямар хамааралтайг нь ойлгосонгүй. Сувилалд ингээд нярай хүүхдүүд 6-аас 9 сартай, 9-өөс 11 сартай, 12-оос 23 сартай хүүхдийн хоолны зөвлөмжийг биччихсэн байгаа байхгүй юу. Тэгээд нярай хүүхдүүд чинь ЕБС-ийн хоолны асуудалтай яаж холбогдоод байгааг би ойлгосонгүй. Тайланг л хараад тодруулж байгаа шүү.

2 дугаарт нь ЭМЯ-наас хүүхдийн өсөлт, хөгжил болон эрүүл мэндээрээ аль аймаг, дүүрэгт анхаарууштай байна гэдэг үзүүлэлтийг сүүлийн 5 жил юм уу, 10 жилээр гаргасан тоо судалгаа юу байна вэ гэдгийг яг тодорхой гаргамаар байна. Яагаад гэвэл нутгийн удирдлага болон энэ ЗГ-ын төлөвлөгөөнд орон нутагт чиглэсэн онцгой ийм төлөвлөгөөнүүдээрээ тэр тоогоо харж ярих ёстой, төлөвлөх ёстой учраас.

3 дугаарт нь ЭМЯ-наас ирүүлсэн мэдээлэл дээр сурагчийн гар угаах нөхцөлийг хангасан гэсэн ийм үзүүлэлт байна. Гар угаах нөхцөлөө хангасан гэдгээ юугаар хэмждэг юм бэ? Нэг ширхэг крант байхыг хэлдэг юм уу, хүүхдийн тоо угаах цагийг нь гаргаж тоотой ярьдаг юм уу, эсвэл юугаар хэмждэг гэдэг үзүүлэлтийг нь тодруулмаар байна?

Мөн ЭМЯ-наас ирүүлсэн мэдээллийн дагуу явахлаар хоолны хордлого халдвараар 25 онд Төв аймгийн Цонжин кибер болон Спорт цогцолбор сургууль, нийслэлийн Гэгээн сургууль, Канад сургууль, Өнөр бүл асрамж, Булган аймгийн Хангал сум гээд энэ сургуулиудад хоолны хордлого хүүхдүүд авсан байгаа байхгүй юу. Тэгээд энэ вирусүүд нь дандаа энэ salmonella болон shigella гээд ийм вирусүүдээр халдварлчихсан. Энэ эргээд ямар арга хэмжээ авдагтай холбоотой асуудал байгаа. Яагаад гэхлээр энэ хоолны хордлого бий болсны дараа тэр гэрээлэгч компанид ямар хариуцлага хүлээдэг юм, гал тогоог түрээсэлж байгаа газар ямар хариуцлага хүлээдэг вэ гэдгийг тодруулах гэсэн юм.

Боловсролын яамнаас болохоор зуны амралтаар маш олон хүүхдийн зуслангууд болон өдөр өнжүүлэх дэмжих үйлчилгээнүүд зун бол зуслангууд, өдөр өнжүүлэхүүд болон хөгжлийн бэрхшээлтэй маш олон хүүхдүүд дэмжих үйлчилгээ гэдэг төвөөр ингэж явдаг. Сургуульд сурч чаддаггүй хүүхдүүд их байдаг учраас. Энэ сургалтын байгууллагууддаа орох уу, ямар статустай байдаг юм эд нар, тэгээд энэ дээр жишээлбэл хоол хүнсний асуудал ямар бодлого, журмаар зохицуулагддаг юм, ямар хяналт шалгалт хийдэг вэ гэдгийг тодруулмаар байна?

Дээрээс нь би өнгөрсөн жил асууж байсан сургуулиуд үдийн хоолны бодлоготой болох хэрэгтэй гэж би ярьж байсан. Тэрийг хэрэгжүүлсэн ажил байна уу гэдгийг тодруулъя.

**О.Номинчимэг:** Саранчулуун гишүүний асуултад эхлээд судалгаанаас асуусан тайлангаас 3 номер уу? ЭМЯ 3 номер Очирбат дарга.

**Д.Очирбат:** Түрүүний сүүлийнх нь асуултаас хариулъя. Мэдээж ЕБС-ийн тавьж байгаа эрүүл ахуй, аюулгүй байдал, хөдөлмөрийн орчны нөхцөлийн үнэлгээгээр бид гар угаах орчинтой байх, тэгээд нийтийн ариун цэврийн нийтийн шаардлага хангасан энэ усныхаа ариун цэврийн нөөцтэй байх, гар угаах орчин бүрдүүлсэн байх л гэдэг шаардлагыг тавьдаг. Ялангуяа энэ хоолны хордлого чиглэлийн авч байгаа энэ халдварууд *escherichia holi* гээд энэ вирусээр үүсгэгддэг. Энэ нь бол бохир гарын, бохир нөхцөлийн ариун цэвэр нөгөө дотоод, гадна нөгөө юу, нийтийн бие засах газаргүй байх, ойрхон тэр нь нөгөө нийтийн бие засах газар нь нийтийн биш, гадна талдаа юм уу, эсвэл угаах орчин муу энэ бохирдол үүссэн. Өөрөөр хэлбэл *escherichia holi* гэдэг үүсгэгч маань ерөөсөө л энэ хүний бохиросоо үүдэлтэй л, ялгадаснаас үүдэлтэй л ийм вирусээр үүсчихдэг энэ өвчлөлийг үүсгэдэг. Манай Бодлогын газрын дарга Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын дарга эхний асуултад нь хариулъя.

**О.Номинчимэг:** 4 номер Цэцэгсайхан дарга.

**Б.Цэцэгсайхан:** Саранчулуун гишүүний асуултад хариулъя. ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Цэцэгсайхан. Тэгэхээр хуулийн 10.4.4-д тусгай хоолны дэглэмтэй хүүхдэд зориулсан хүнсний түүхий эд бүтээгдэхүүн болон хоолны жишиг зөвлөмж гаргана гэсэн байгаа. Энийг яг Эрүүл мэндийн сайдын гаргасан тушаал байхгүй. Энэ чиглэлээр гарсан гарын авлагууд байдаг. Энэ жил бид Боловсролын яамтай хамтарч энэ жишиг цэс, зөвлөмжийг гаргах ажлыг хийгээд явж байгаа. Яг тайлан дээр туссаны дагуу Хүүхдийн төв сувилал дээр тусгай хоолны дэглэмтэй хүүхдүүдэд зориулсан хоолны цэс зөвлөмжүүд байдаг. Тэрний талаар дурдсан байгаа.

**О.Номинчимэг:** Боловсролын яам 1 номер.

**Х.Батжаргал:** Боловсролын яам гишүүний асуултад хариулъя. Таны асуусанчлан хүүхдийн зуслан, өдөр өнжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн энэ дэмжих төвийн асуудал холбогдох зардал төсөв Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад сууж явдаг. Харин боловсролын үйлчилгээ үзүүлэхэд нь зориулж сургууль сургалтын байгууллагууд дээр буюу сургууль дээр яг сургалтын үйл ажиллагаа үйлчилгээгээ авч чадахгүй байгаа энэ хүүхдүүдийн дэмжих төв дээр үзүүлж байгаа тэр сургалтын үйл ажиллагааны зардлыг бол хувьсах зардлаар дамжуулж Боловсролын сайдын багцаас гаргах ийм зохицуулалт буюу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан нэг ийм зохицуулалт дүрэм баталсан байдаг. Энэ хүрээндээ зохицуулалт хийгдэж явж байгаа.

**О.Номинчимэг:** Отгоны Саранчулуун гишүүн тодруулъя.

**О.Саранчулуун:** Тийм, тэрийг ойлгож байна. Миний асуугаад байгаа зүйл болохоор хүүхдийн зуслангууд ямар статустай байдаг юм бэ? Гэр бүлийн яам байна уу, Боловсролын яам байна уу тэд нар ямар статустай байгаад тэнд маш их хоолны хордлого асуудлууд байдаг байхгүй юу. Тэгэхээр тэрийг ер нь хаана хариуцдаг юм бэ? Бодлогын хувьд хэн, тэнд хоол идэж байгаа хүүхдүүдийн эрүүл ахуйн асуудлыг ямар бодлого, дүрэм журам зохицуулдаг тухай асууж байна. Энийг тодруулмаар байна.

Дахиад ЭМЯ-наас тодруулах гээд байна шүү дээ. ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай асуудал дээр яагаад нярай хүүхдийн хоолны асуудлыг хариу бичээд байдаг тайланг чинь л асуугаад байгаа юм. Хэрвээ энэ байхгүй бол байхгүй л гээд биччихгүй ингээд нэг ийм ямар ч хамаагүй хариулт бэлдэж явуулж байгаа юм шиг юм хийхгүй л баймаар байгаа байхгүй юу. Зусланг асууж байна, өдөр өнжүүлэхүүдийг асууж байна. Тэд нарын хоолны асуудлыг хэн хариуцдаг юм бэ, аюулгүй байдлыг нь хаана хариуцах юм бэ? Монгол Улсад хэн хариуцдаг вэ л гэдгийг асуугаад байна шүү дээ. Тэрийг хэн хариулах вэ?

**О.Номинчимэг:** Хоол хүнсний аюулгүй байдлын асуудал, хяналтыг хэн хийж байна гээд нөгөө одоо Мэргэжлийн хяналт татан буугдсан чинь хэдэн эрүүл мэндийн байцаагчдыг энд тэнд Эрүүл мэндийн газар хаана хаана билээ, Хүнсний газар гээд хуваагдаад энэ чинь хяналт шалгалтаа ч хийж чадахгүй болчихоод байгаа шүү дээ. Нийслэл дээр байхад бол угаасаа энэ асуудал байсан. Энэ дээр хяналтаа хэн хийж байгаа талаар яах юм бэ? Хүнснийхэн хариулах уу, ЭМЯ хариулах уу? Хяналтын ингээд яг хүний ам руу ордог эрүүл мэндийн хүнсний хяналт л ингээд л байхаар таг дуугүй ийм болчихоод байгаа юм л даа. Байхгүй. Хэн хариулах вэ? 3 номер юм уу? 3 номер ЭМЯ Очирбат дарга.

**Д.Очирбат:** Салбарын хяналт яамнууддаа хүрч ирсэнтэй холбогдуулаад манай ЭМЯ дээр салбарын хяналтын байцаагч ирсэн байдаг. Тэгээд манай яаман дээр бүх л хоолны энэ аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдлын салбарын хяналтууд байцаагчид байдаг. Орон нутагт ч гэсэн харьяалал харьяаллаараа энэ салбарын хяналтын байцаагчид ажилладаг.

**О.Номинчимэг:** Отгоны Саранчулуун гишүүн тодруулъя.

**О.Саранчулуун:** Хүүхдийн зуслан дээр сургалтын хөтөлбөр боловсруулаад хүүхдийн зуслан, сургалтын төвүүд байгаад байна. Тэд ямар статустай юм бэ? Боловсролын үйлчилгээ явуулдаг юм бол тэнд хүүхдүүд өдөржингөө сургаж байгаад хоолны хордлого болбол хаана хариуцах вэ, ямар арга хэмжээ, ямар дүрэм журмаар зохицуулах юм бэ л гэдгийг би та хэдээс асуугаад байгаа байхгүй юу? Манай боловсрол, эрүүл мэнд, энэ хүнсний салбараас хариулах хүмүүс байна уу? Энэ чинь ээж аавуудын асуулт шүү дээ. Зун хүүхдүүд бас л нэг сургалт гээд л явдаг шүү дээ. Тэр хоол адилхан л хүүхдүүд байгаа сурч байгаа, тэр ямар салбарын асуудал байх ёстой юм бэ, тэн дээр юу яригдах вэ гэдгийг хариулах хүн байна уу?

**О.Номинчимэг:** Энэ чинь зөндөө бодит кейсүүд гараад байгаа шүү дээ Найрамдал зуслан дээр хүүхдийн хоолны хордлого гарлаа л гэнэ, энэ зуслан дээр гарлаа л гэнэ, хүүхдүүд хамтдаа явж байгаад. Энэ дээр хэн очиж хяналт тавьдаг юм бэ, хэн хариуцаж энэ дээр нь асуудал ярьдаг юм бэ гэж? 5 номер Жамбалцэрэн дарга.

**Т.Жамбалцэрэн:** Саранчулуун гишүүний асуултад тодруулж хариулъя. Аймаг, орон нутгуудад байгаа улсын чанартай зуслан гээд ингээд аваад үзэхээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр үндсэн үйл ажиллагаа чиглэлүүд нь хариуцагдаад явж байгаа байх гэж бодож байгаа. Тэнд хүнсний аюулгүй байдалтай, нийтийг хамарсан хоолны хордлоготой асуудал гарахад тухайн шатны аймаг, нийслэлийн салбарын хяналтын нэгжүүд нь очиж хяналт шалгалт хийж байгаа. Хяналт шалгалт хийхдээ хамтарсан удирдамжтай буюу мэргэжлийн хяналтын нэгдсэн бүтэц салбарууддаа шилжиж очсонтой холбоотой эрүүл мэндийн салбарын

хяналтын нэгж, ХХААХҮ-ийн салбар дээр ирсэн салбарын хяналтын нэгжүүд хамтарсан хяналт шалгалтыг хийх ажлыг зохион байгуулж байгаа. Урьдчилсан хяналтыг ч гэсэн энэ хүрээндээ зохион байгуулж байгаа. Төлөвлөгөөт шалгалтыг нэгдсэн байдлаар саналаа нэгтгэж, жилийн төлөвлөгөөт шалгалтын удирдамжийг баталдаг. Энэ хүрээнд хяналт шалгалтыг зохион байгуулж байгаа. Иргэн, ААН-ээс ирсэн өргөдөл гомдолтой холбоотой төлөвлөгөөт бус хяналтын шалгалт.../минут дуусав/

**О.Номинчимэг:** Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Манай ТНБД нар маань ажлаа мэдэж байгаа байх л гэж би бодож байгаа. Ямар ч олуулаа ирдэг юм. Энэ зааланд яг энэ асуудлаар 25 хүн ирсэн байна. Эсвэл нэг дарга нь ажлаа мэдэхгүй болоод 2 хүнээ дагуулаад ирдэг юм уу, мэргэжилтнээ дагуулаад ирдэг юм уу яадаг юм ойлгохгүй байна. Ер нь хөдөө орон нутаг сумдад маш хэцүү байгаа шүү дээ. Улаанбаатар хотод ч энэ байдал байгаа. Бид яах вэ нэг хүүхэд авах калори энэ тэр гээд олон юм яриад байна л даа. Тэр ямар, тэр хоолыг хийхдээ ямар тогоонд хийгээд байна, ямар саванд хийгээд байна, ямар тоног төхөөрөмж хэрэглэгдээд байна, тэр хоолыг идэж ууж байгаа анги танхим чинь өөрөө ямар байна вэ гэдэг дээр хэн ч анхаарахгүй байна. Энэ эрүүл ахуйн асуудал.

Би Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын даргаар ажиллаж байсан. Тэр үед над дээр байсан тоо бол 18 хүртэлх насны жил тутам 100 мянган хүүхэд хоол боловсруулах тогтолцооны өвчлөлөөр өвддөг гэсэн тоо байсан. Энэ тоо одоо өсчихсөн юм шиг байна лээ. Тэгээд бид энэ ирээдүйн 100 мянган хавдрыг бэлдээд байх ёстой юм уу гэдгийг би ерөөсөө ойлгохгүй байгаа. Энэ дээр гарсан зөрчлүүд байна л даа ХХААХҮЯ-ны хяналтын газрынхан л хийсэн юм шиг байна. Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын 33,7 хувь нь хүнсний бүтээгдэхүүний төрөлжсөн агуулахгүй. Энэ бол хадгалалт болохгүй байна гэсэн үг. Хадгалалт болохгүй байна гэдэг бол хүүхдүүддээ бид стандартын бус хадгалагдсан бараа, бүтээгдэхүүн, түүхий эдээр хоол хийж өгч байна гэсэн үг нэг.

25 хувь нь хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангалтгүй гэж байгаа юм. 4 сургууль тутмын 1 нь хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж байхгүй байна гэсэн үг. 2 дугаар асуудал нь энд байна. Энэ дотроо дахиад стандартын шаардлага хангаж байгаа, хангахгүй байгаа асуудал хөндөгдөж байгаа шүү.

3 дугаарт 21,9 хувь нь технологийн карт шим тэжээлийн үзүүлэлтээ бүрэн баталгаажуулаагүй байгаа. Тэгээд яаж та нар шим тэжээл хэдэн хувьтай өгч байна гэж яриад байгааг би ерөөсөө ойлгохгүй байна. Баталгаажсан хэсгээс нь л өгөөд байгаа юм байлгүй.

Дараагийн төгсгөлийнх нь 17,9 хувь нь хэрэглэж байгаа амтлагч хүнсний нэмэлтийн бүртгэл баталгаажуагүй. БНСУ ходоодны хорт хавдраараа дэлхийд нэгд ордог байсан. Гол үндсэн суурь шалтгаанаа судлаад үзсэн хүнсний нэмэлт амтлагч байсан. Манай ЭМЯ-ныхан хэлэх байх. Тэгээд ийм л байна. Тэгээд ингээд хэрэгжилтийн тайлан орж ирж байгаа. Одоо хэдүүлээ яг яах вэ? Энэ стандартын бус саванд хийгдэж байгаа хоолноос улбаатай эрүүл ахуйн бус өвчлөлийн асуудлыг хэдүүлээ яаж шийдвэрлэх вэ? Энэ дээр та хэд маань нэг хариулт өгөөч гэж хүсэж байна.

**О.Номинчимэг:** Хэн хариулах вэ? 3 номер Очирбат дарга.

**Д.Очирбат:** Манай салбарын хяналтынхан түрүүний хэлсэн Бат-Эрдэнэ гишүүний хэлсэн сургууль, цэцэрлэгүүдийн гал тогоон дээр салбарын дагаж мөрдөх журам, Монгол Улсад мөрдөгдөж буй сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага стандарт сав суулга тавих энэ стандартуудыг хянаж ажилладаг. Хүнсний зориулалтын бус хуванцар, хөнгөн цагаан сав ашиглахыг хориглодог. Зөвхөн биднүүсийн тавьж байгаа шаардлага бол ган сав, зэвэрдэггүй паалан савтай сав суулгатай байх ийм шаардлагыг үздэг. Мөн түүхий мах, ногоо, хүнс, мах болон ногоон хүнс ойр зуурын талх хэрэглэх энэ хэрэглэгдэхүүнүүдийг нь тус тусад нь ялгаж хяналтыг тавьдаг байгаа. Энэ хангамжийн асуудал гол нь Боловсролын яамнаас хөрөнгө оруулалтаар шийдэгддэг.

**О.Номинчимэг:** Бат-Эрдэнэ гишүүн нэмэлт тодруулга.

**Б.Бат-Эрдэнэ:** Очирбат даргын хэлж байгаа үнэн л дээ. Манай Боловсролын яам маш хүнд нөхцөл байдалд байгаа. Боловсролыг Боловсролын яамнаас аваръя гэдэг хөдөлгөөн хүртэл өрнүүлье гэж би ярьж байсан. Шинэ сургууль барьчихсан, доторх тоног төхөөрөмж нь байхгүй, зардал нь суугаагүй, төсөв нь суугаагүй. Энэ Боловсролын яамны маш том гажуудал. Өнөөдөр та хэд маань манай Хөвсгөл аймагт албан ёсоор очоорой, би урьж байна. Тэр сургуулиудаар нэг надтай цуг яваад үзээрэй болохгүй бол, би зардлыг чинь даая. Тэнд нөхцөл байдал ямар хүнд байна гэж бодож байна та нар. Булган аймагт ямар асуудлууд байна гэж бодож байна? Яг суман дээр байгаа сургуулийн дотуур байрны эрүүл ахуй, хоол хүнсний хангамж, хийж байгаа тоног төхөөрөмжүүд ямар байна гэж бодож байна. Та хэд маань сайхан стандарт л уншаад байгаа тэгээд төсөвгүй юм чинь ч тоног төхөөрөмжөө авч чаддаггүй, тоног төхөөрөмж байхгүй болохоор хоол хийхгүй гэдэг ойлголт байхгүй.

**О.Номинчимэг:** Боловсролын яам хариулах уу? 1 номер Батжаргал дарга.

**Х.Батжаргал:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад нэмэлт мэдээлэл тодруулга өгье. Гишүүний хэлж байгаа бодит байдал зарим тохиолдолд үнэн. Хөрөнгө оруулалтын зардал батлагдсан төсөв тухайн жилийнхээ шинээр ашиглалтад орж байгаа сургууль, цэцэрлэгийн барилгын тоног төхөөрөмжийг ханган нийлүүлэхэд зарцуулагдаад л таардаг. Харин өнгөрсөн бараг гучаад жилийн хугацаанд баригдчихсан байгаа үйл ажиллагаа явуулж байгаа сургууль, цэцэрлэгийн тоног төхөөрөмж нөхөн хангалтын зардал тухайн жилийн төсөвт үнэхээр хүрэлцэх нөөц бололцоо туйлын дутагдалтай байсаар ирсэн. Үүнийг мэдээж гадаад хөгжлийн түншүүд, гадаадын зээл, тусламжаар зохион байгуулалт хийж, ямар ч байсан улсын төсвөөр шинээр барьж байгаагаа шийдэгдээд, цаана нь зардал мөнгө хүрдэггүй тэр бусад зардлыг гадаадын зээл, тусламжаар нийлүүлж, энэ хүрээнд 90 сургалтын байгууллагад тоног төхөөрөмжийг орчин үеийн тоног төхөөрөмжөөр сургалт, ялангуяа хоол хүнсний тоног төхөөрөмж.../минут дуусав/

**О.Номинчимэг:** 1 номер гүйцээж хариулъя, нэг минут.

**Х.Батжаргал:** Энэ жилийн хувьд улсын төсөв дээр 4,6 тэрбум сургууль, цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмжид нийлүүлэхээр туссан байгаа. Хэрэгжилт мэдээж шинээр ашиглалтад орж байгаа сургууль, цэцэрлэгийн тоног

төхөөрөмжийг нийлүүлээд энэ ингээд таарч байгаа. Стандартын тухайд мэдээж Төрийн болон орон нутгийн өмчөөр худалдан авах тухай хуулийн дагуу тендерийн материалд шаардлага дээрээ бол стандартынхаа шаардлагыг тавьж байгаа учраас стандартын шаардлага хангахуйц тоног төхөөрөмж нийлүүлэгдээд ингээд явж байгаа. Шинээр ашиглалтад орчхоод байхад тоног төхөөрөмж нийлүүлэгдэж чадахгүй байгаа гэдэг асуудал цаг хугацааны асуудал байдаг. Тухайн манай боловсролын салбарын хичээлийн жил 2 төсвийн жил дамжиж хэрэгждэг. Тэгэхээр тухайлбал 25 оны төгсгөлд 4 дүгээр улиралд 3 дугаар улирлын сүүлээр ашиглалтад орсон сургууль, цэцэрлэг дараа жилийнхээ төсвийн жилийн гүйцэтгэлийг хүлээхээс өөр аргагүй. Тендер зохион байгуулалт нь.../минут дуусав/

**О.Номинчимэг:** Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

**Б.Бат-Эрдэнэ:** Би сая хэлсэн эрхэм дарга нар хөдөө явж үз, бодит амьдрал дээр нь очиж үз шал өөр байгаа. Ажил хийгээд гүйгээд байгаа залуучууд байгаа шүү дээ одоо таны хажууд сууж байна. Нийслэлийнхэн мөнгө байдаггүй, сэтгэгдэл нь байгаад байдаг, мөнгө байдаггүй. Өдөр тутам ажил дээр нь очиж ажиллаад байдаг, асуудалтай тулгараад байдаг. Танайх дээр мөнгө нь байгаад байдаг, хийж өгдөггүй ний нуугүй хэлэхэд. Танайх Монгол Улсын хамгийн том төсөвтэй яам. Өөрөөр хэлбэл танайх ерөөсөө байгаа онохгүй байгаа даргаа, ерөөсөө байгаа онохгүй байгаа. Энэ жил Боловсролын жил шүү дээ. Тэгээд Боловсролын жилдээ зориулаад ядаж наад сургууль, цэцэрлэгийнхээ сандал ширээнээс авхуулаад наад хоолныхоо тоног төхөөрөмжийг шийдээд өгчих л дөө. Энэ дээр үзүүлэлт нь байна шүү дээ энэ шалгалт дээр. 25 хувь нь хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хүрэлцээгүй гээд биччихсэн. Тэгээд хоол боловсруулах тогтолцооны өвчлөл үүнээс улбаатай шүү, 100 мянган хавдрыг бид бэлдэж байна шүү.

**О.Номинчимэг:** Үг хэлсэн үү, асуулт асуусан уу, аль яамнаас вэ? Боловсролын яамнаас уу? Боловсролын яам нэг номер.

**Х.Батжаргал:** Нэмэлт мэдээлэл тодруулга өгье. Боловсролын салбарын төсөв 80 гаруй хувь, 90 орчим хувь нь цалин 93 мянган албан хаагчдын цалинд зарцуулагддаг. Таны хэлсэнчлэн Боловсролыг дэмжих жилийн хүрээнд хөрөнгө оруулалтын төсөв 2 дахин нэмэгдсэн. Энэхүү хүрээнд сургууль, цэцэрлэгийнхээ хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр, хүртээмжээ дагаад барьсан барилга, түүнийг хангахуйц хэмжээний сургалтын үйл ажиллагаа хэвийн явуулах тоног төхөөрөмжийн зардал төсвийг тооцоод судлаад ороод явж байгаа. Харин сургалтын үйл ажиллагаа хэдийн явагдаад эхэлчихсэн байгаа эдгээр тоног төхөөрөмжийг нийлүүлэхэд тооцоо судалгаагаар бүрэн шинэчлэхэд 1,9 их наядын тооцоо судалгаа гарсан байдаг. Энийг нэг жилийн төсвөөр нэг дор шийдэх боломж бололцоо байдаггүй юм байна лээ. Харин энэ Боловсролыг дэмжих жилийн хүрээнд гол суурь тавигдаж байгаа. Боловсрол.../минут дуусав/

**О.Номинчимэг:** Даваасамбуугийн Ганмаа гишүүн асуулт асууя.

**Д.Ганмаа:** ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ энэтэй холбоотой миний бие 2004 оноос хойш Монголд сургуулийн насны хүүхдүүдийн дунд хоол, шим тэжээлийн талаар судалгаануудыг хийсэн юм. 2004 он гэдэг чинь хэчнээн жилийн өмнө байгаа биз. Тэгээд яг энэ судалгааныхаа хүрээнд сургуулийн насны хүүхдүүдийн өндөр, жин, биеийн жингийн индекс, ингээд хоол, шим тэжээлийн асуумж, тэгээд юу гэдэг юм наад захын хэмжилтүүд, тэгээд лабораторийн

шинжилгээ энэ тэрийг бүгдийг нь дэлгэрэнгүй хийгээд, хамгийн сүүлд 2020 онд дууссан судалгаагаар бараг 21 аймгийн 170 гаруй сургууль хот, хөдөөгийн сурагчдын дунд хоол шим тэжээл, хүүхдийн өсөлт, хооллолтын хэв маяг зэргийг судалсан. Тэр судалгаанд оролцоод явж байсан үеийн Туяацэцэг захирал энэ тэр гээд наана нь энд манайхаас хүмүүс сууж байна. Мэдээлэл сайтай байх ёстой. Бид энэ дээр ингээд ярьж байхдаа сая асуулт нь ч тэр, хариулт нь ч тэр үнэхээр мэргэжлийн биш, маш буруу зөрүү ойлголт төрүүлэхээр наад захын ойлголтгүй юмнууд яриад байна. Би бүүр алианаас нь эхэлж засаад явахдаа ч мэдэхээ байтлаа бүүр юу яачих юм.

1 дүгээрт хот хөдөөгийн дунд судалгаа хийсэн ялгаанууд байгаа. Сургуулийн насны хүүхдүүдэд хийсэн нь байгаа. Өвөл, зуны улирлаар хийснээрээ ч байгаа. Тус тусад нь нас насны бүлэгт нь шим тэжээлээрээ оруулж ирээд танилцуулгаа хийгээд, Улсын Их Хурлын гишүүдэд шийдвэр гаргагчид мөнгө төгрөг шийдэх гэж байгаа хүмүүстээ үнэн зөв бодитой мэдээллийг нь өгдөг болмоор байна. Тэгэхгүй бол энэ чинь хаашаа юм бэ, хэдэн оны хэддүгээр зууныхаа юм яриад байгаа юм бэ? Дөнгөж л нэг тэдэн шим тэжээлийн тэдэн хувь нь байгаа л гээд байх юм. Калори л яриад байх юм, уураг, өөх тос, нүүрс уснаасаа ерөөсөө цаашаа бүүр гарахаа байчихсан юм уу хаашаа юм бэ?

Энэний чинь цаана чинь зайлшгүй шаардлагатай өөхлөг тослог, тэгээд fatty acid гэж ярьдаг шүү дээ, эсвэл энэ юунууд fiber antioxidants, тэгээд маш олон зайлшгүй шаардлагатай хоол хүнс, шим тэжээлээр, ялангуяа сургуулийн өсөж бойжиж байгаа хүүхдүүдэд хэрэгтэй юмнуудаа яриад, тэрнийхээ хувь, тэрний тархалт, тэрний өвөл, зун, тэрнийхээ хот, хөдөөгийн ялгаатай, нас насны бүлгээр нь ярьж, тайлбарлаж тайлбарлаж ойлгуулаач гэж бүүр хүсмээр байна. Энийг тэгэхдээ би ингээд ярьсаар байгаад залхаж байна. Би 20 хэдэн жил яг энийг ярьж байна. ЭМЯ, ХАА, Боловсрол ер нь хаана хаана л сургуульд ер нь намайг сонсох хүн байвал бүгдэд нь л ярьдаг байсан. Одоо яг энэ юмыгаа дахиад яг тэр нэг хуучны системээрээ яриад л. Одоо яг үнэндээ малын тэжээлийг ч ингэж ярихаа больчихсон байгаа шүү дээ. Бүүр нарийвчилсан шинжлэх ухаан буюу science дээр тулгуурлаж ярьдаг байгаа шүү дээ. Тэгсэн чинь одоо юу ярьж байгаа юм бэ бид хоол, хүнс шим тэжээлээс болоод хавдар үүсдэг үү гэсэн чинь тийм ээ үүсдэг гээд шууд яриад явчих юм уу бид? Хаана, ямар судалгаан дээр, юун дээр тулгуурлаж энийг яриад ийм мэдээлэл өгөөд энд суугаад байгаа билээ? Тэр ... хэлж өгөхгүй бол ингэж буруу зөрүү мэдээллээ тарааснаас болоод яг зөв интервенц, зөв юмаа ярьж чадахгүй байгааг ойлгож байгаа тийм үү? Минутаа нэмээд авчихъя. Хүн ярихад ингээд хурдан авчхаад, намайг. Хэдэн асуулт.../минут дуусав/

**О.Номинчимэг:** Ганмаа гишүүн нэмэлт нэг минут.

**Д.Ганмаа:** 3 асуултад 1 дүгээрт энэ хоол, шим тэжээл буюу school үдийн цай гэж хөтөлбөр байсан тийм үү? Яг би тэрний өмнөх судалгаануудыг нь бүгдийг нь гаргаж өгч, үдийн цай хөтөлбөр Энхбаяр Ерөнхийлөгч байх үед байх Н.Энхбаяр гуайг хэлж байсан, дараа нь тэр чинь 2020 онд үдийн хоол болсон. Үдийн хоол хөтөлбөрт хамрагдахын өмнө, хамрагдсаны дараа саяын миний нэрлэсэн юмнуудыг зөвхөн шим тэжээлээр нь биш ингээд задалж судалсан судалгаа юм уу мэдээлэл report. Master, PhD-гийн түвшний ч юм уу юмнууд байна уу? Энэтэй холбоотой өвчлөлтийн тархалт буурсан уу? Жишээлбэл тураал ч юм уу, эсвэл дутагдлууд ч юм уу, эсвэл ясны сийрэгжилт ч юм уу, эсвэл таргалалт, эсвэл илүүдэл жин, эсвэл шим тэжээлийн дутагдлуудыг үдийн цайны өмнө, үдийн хоолны өмнө юм уу дараа

гэснийг. Илрүүлэлт хяналтынхаа тогтолцоог яаж хийж байгаа вэ? Тохиолдлуудыг сургууль, өрхийн эмнэлэг, салбар хооронд яаж холбож, яаж шийдвэрлэж байгаа юм бэ? Энийгээ олон нийтэд ил гаргаж ирж чадаж байгаа юу?

**О.Номинчимэг:** Ганмаа гишүүний асуултад тэр өмнө, хойно үдийн цай, өмнө, хойно хоолны өмнө, хойно судалгаануудаа нарийвчилж хийж чадаж байна уу, хяналтаа яаж хийж байна гэдэг дээр хэн хариулах вэ? Мэргэжлийн байгууллагуудаас байна уу, ЭМЯ хариулах уу, Боловсрол хариулах уу? Тэр судалгаануудыг хийсэн юм байна уу? Дүн шинжилгээ. Эрүүл мэнд дээр байгаа юу тэр судалгаанууд үдийн хоолны? Болохгүй тэр мэргэжилтнүүд нь наашаагаа суугаад хариулж болно шүү дээ, юмаа мэдэж байгаа, ийм мэдээлэлтэй байгаа хүмүүс нь. 3 номер Очирбат дарга.

**Д.Очирбат:** Яг үдийн цай хөтөлбөр, үдийн хоолны хөтөлбөрөөс өмнөх болон хойно нь яг харьцуулсан тийм судалгаа, дүгнэлтүүд их ховор юм шиг байна. Яг энэ тал дээр дахин судалж хариулъя. Тэгэхдээ НҮБ-ын ЮНЕСКО-ийн ЮНИСЕФ-ийн Дэлхийн эрүүл мэндийн хүнсний хөтөлбөр сум дунд, сургууль дээр бүтэн өдрийн хоол, баяжуулсан үдийн хоол туршиж үр дүнг нэг судалсан судалгаа байдаг юм байна. Тэгээд бие махбодын өөрчлөлт, хоолны чанарыг сайжруулснаараа 6-аас 12 сарын дараа хүүхдийн цусны гемоглобины түвшин, цус багадалт буурсан, өсөлт нь нэмэгдсэн, жингийн харьцаа өөрчилсөн, жингийн харьцаа нэмэгдсэн, өсөлт бойжилтод нь тодорхой хэмжээгээр нөлөөлж байсан ийм судалгаа байна гэж. Бусад судалгааны чиглэлээр Боловсролын яам түрүүнд хариулъя гээд тэгж байх шиг байна.

**О.Номинчимэг:** Тэгье, 1 номер Боловсролын яам тэгвэл нэмэлтээр хариулт өгье.

**Т.Түмэнжаргал:** Яг энэ сургуулийн үдийн хоолны хөтөлбөр хэрэгжсэнтэй холбоотой хууль дээр байгаа яг ЭМЯ 5 жил тутамдаа судалгаа хийнэ гэсэн хоол тэжээлийн судалгаа хийнэ гэсэн заалт байгаа. Энэ хүрээндээ бид сая 24 оны хүн амын хоол тэжээлийн судалгаанд яг энэ сургуулийн насны буюу 6-аас 18 насны хүүхэд гэж бүүр ангилж тусгай үзүүлэлтүүдийг оруулж өгсөн. Өмнө нь тийм үзүүлэлт байгаагүй. Тэр үзүүлэлтээрээ 2024 оны судалгааны тайланд яг 6-аас 18 насны хүүхдийн хоол тэжээлийн байдлын судалгаа 1 дүгээрт гарсан. 2 дугаарт манай Боловсролын яамны зүгээс олон улсын төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд хэд хэдэн судалгаануудыг хийсэн байгаа. Хийсний үндсэн дээр бид түрүүний нөгөө дунд ангийн буюу өсвөр насны хүүхдүүдийн хоол тэжээлийн байдал, шим тэжээл, шим тэжээлийн байдлын судалгааг бид хийсэн судалгаанууд байгаа. Хамгийн сүүлд бид Жайка ОУБ-аар хийсэн судалгааны дүнгээр 2 аймгийн түвшинд хийхэд 10 хүүхдийн 9 нь Д амин дэмийн дутагдалтай гэсэн ийм дүн гарсан байгаа. Үүнийхээ хүрээнд бид Сүү хөтөлбөрийг хэрэгжүүлээд ингээд явж байгаа.

**О.Номинчимэг:** Даваасамбуугийн Ганмаа гишүүн тодруулъя.

**Д.Ганмаа:** Наад судалгаа байгаа, байхгүйг чинь би та нараас хамгийн их мэдэх байх. Тэгж асуусангүй. Та хэдийн хариулаад байгаа юм чинь нэг аймар учир дутагдалтай байна гэдгийг хэлээд байна шүү дээ. Би fiber ямар байгаа юм сургуулийн насны хүүхдүүд, антиоксидантууд ямар байгаа юм, B9 ямар байгаа юм, витамин Д-г сая ярилаа, С ямар байгаа юм, Е байгаа юм, кальци, magnesium. Хамгийн дутагдалтай гарч байгаа нь саяын миний нэрлэсэн витаминууд байхгүй юу.

Тэн дотроос амин хүчлүүд байгаа зайлшгүй өөрсдөө авах ёстой. Тэр амин хүчлүүдийг ямар байдлаар оруулж ирсэн юм бэ? Ер нь цөмөөрөө энэ дээр яг нэг өнөөдөр ийм тогтвортой ийм тогтоол ч юм уу Өргөдлийн байнгын хорооноосоо гаргая гэсэн надад санал байна. Энэ дээрээ юу юуг яаж хянаж байж энэ мэдээллийг ярих вэ гэхгүй бол үнэхээр энэ 20 хэдэн жил бид энийг л ингээд урагшлахгүй байгаа юм шиг сэтгэгдэл төрөөд. Ялангуяа энэ хоол, шим тэжээлтэй холбоотой нөгөө хоолны зориулалтын өвчлөлийн мэдээллүүдийг.../минут дуусав/

**О.Номинчимэг:** Тийм, энэ өнөөдрийн хэлэлцүүлгийн гол зорилго ч гэсэн хуулийн хэрэгжилт ямар түвшинд байна, бидний тулгамдаж байгаа асуудал юу байна гэдгээ бид тодорхойлоод, энэ дээр арга хэмжээ авъя гэж байгаа юм. Тэгээд яах вэ энэ дээр бид бас одоо бүр нарийн түвшинд мэдээлэл нь байхгүй ч гэсэн ямартай ч энэ 2019 онд хууль батлагдсан нь дэвшил болсон алдаатай, оноотой байгаа тийм үү? Тэр үед 21, 22 онд тогтоосон тариф чинь бол үнэхээр хүүхдүүдийнхээ шим тэжээлийг 1 дүгээрт авахад дутуу байна гэдэг нь ойлгомжтой байна. Энэ дээрээ тэр төсөв санхүүгийн бололцоог нь гаргаж, шийдэл хайж оруулъя. Бид өнөөдөр нэг хэдэн тэрбум төгрөг хүүхдүүдээсээ харамлаж сэтгэл гаргахгүй байгаа чинь ирээдүй хойч үеэ хорлож байгаагийн л нэг шинж шүү дээ. Энийг 32 тэрбум төгрөг дотуур байранд сууж байгаа хүүхдүүдэд гаргаад өгчихөд юу нь болохгүй байгаа юм. Дунд, ахлах ангийнхандаа нийтдээ 270 тэрбум гаргаад үдийн хоолонд хамруулчихад Монгол Улсын төсөв тэгээд дампуурчих гээд байгаа юм уу. Би үгүй гэж бодож байна.

Энэ дээр энэ асуудлыг хэр чухлыг ойлгуулах ажил болон энд анхаарал хандуулах асуудал дутагдаад байгаа байх гэж бодож байгаа. Үе үеийн ер нь парламентад эмэгтэй гишүүд л энэ асуудлыг ярьж, энэ хоол үйлдвэрлэлийн хуулийг батлуулж, тарифыг нь нэмэгдүүлэх асуудал дээр дуугарч байсан. Энэ удаагийн парламент бол эрэгтэй, эмэгтэй гэлтгүй энэ дээр анхаарч байгаа. Энэ момент дээр бол энэ яам, тамгын газар ажиллаж байгаа хүмүүс, бодлого дээр ажиллаж байгаа, тогтвортой ажиллаж байгаа энэ хүмүүс маань энэ дата мэдээллүүдээ нэгтгээд, эхний ээлжид авах алхмуудаа хийх тал дээр та бүхэн санаачилгатай ажилламаар байна.

Монгол хүүхдүүдийн ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа хүүхдүүдийн 47 хувь нь л үдийн хоол идэж байна шүү дээ, 53 хувь нь идэж чадахгүй байна. Тэгээд энэний чинь үр дагавар нь тэр 24 оны судалгаагаар шим тэжээл нь дутагдалтай, хөдөө орон нутагт илүү nutrition дутагдалтай, шим тэжээлийн дутагдалтай, өсөлт нь бага байна гээд олон ийм ойлгомжтой үр дагаврууд гарчихсан байхад бид наад захын арга хэмжээг авахгүй байна гэдэг 1 дүгээрт эмгэнэлтэй, заавал авах ёстой.

2 дугаарт яах вэ мэдээж төсөв мөнгөний асуудал хязгаартай гэдгийг ойлгож байгаа. Байгаа төсөв дээрээ бид яаж шим тэжээлийг нь хамгийн optimally болгох вэ гээд Ганмаа гишүүний хэлж байгаа нарийн судалгаанууд дээр үндэслэсэн юун дээр анхаарах ёстой гэдэг юм байгаа. Тэгээд энэ дээр манай энд өнөөдөр хүрэлцэн ирсэн Туяацэцэг даргаас өргөдөл ирсэн Өргөдлийн байнгын хороон дээр. Энийг ч бид тэр Боловсролын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдэх ёстой гэж харж байгаа. Шим тэжээлээ бид яаж хийж байгаа, энийгээ боловсролыг нь хаана хаана тэр хоол зүйчид нь эцэг эхэд нь, хүүхдүүддээ өгөхгүй бол баахан төсөв нэмээд шим тэжээл нь сайжрахгүй бол дахиад учир дутагдалтай үр дүн гарна гэж харж байгаа. Тэгэхээр Ганмаа гишүүнийг энэ санаачилгыг гаргаж байгаад талархаж байна.

Бид өнөөдрийн хэлэлцүүлгийн дараа Өргөдлийн байнгын хороогоороо гаргаад, нэг санал дүгнэлт гаргаад, цаашид 27 оны төсөв дээр ямар арга хэмжээ авах вэ, бодлогын түвшинд ямар арга хэмжээ авах вэ гэдэг дээр нэг нэгдсэн санал, дүгнэлт гаргаад явъя гэж бодож байна бусад Байнгын хороо, ЗГ-т үүрэг чиглэл өгсөн. Тэгээд энэ дээр Ганмаа гишүүнийг хамтарч ажиллаж, мэргэжлийн хүний хувьд энэ асуудал дээр маш хамгийн удаан жил судалгааг нь хийж, нарийн мэдэж байгаа хүний хувьд энэ дээр манлайлж ажиллана гэдгийг мэдэж байгаа. Ганмаа гишүүний хувьд МАН-ын бүлэг дээр ч гэсэн энэ асуудлаар танилцуулга хийж, санаачилга гаргаж явж байгаа ийм гишүүн байгаа. Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуулт асууя.

**Г.Лувсанжамц:** Өдрийн мэнд хүргэе. ЭМЯ, Боловсролын яам, Нийслэлээс асуулт байна. 1 дүгээрт, 26 оны улсын төсөвт цэцэрлэг, бага сургууль, дотуур байран дээр бид 324 орчим тэрбум төгрөгийн төсвийг энэ хөтөлбөр дээр тавьсан байгаа. Шалгуур үзүүлэлтийг яаж тогтоож байгаа вэ? Энэ 324 тэрбум төгрөгийг зарцуулснаараа бид ямар үр дүнд хүрч байна вэ гэдгийг яаж хэмжиж байгаа вэ? Багагүй мөнгө шүү дээ.

2 дугаарт, хүүхдүүдийн дунд амьсгалын замын өвчлөл их хэвээрээ байгаа, өнгөрсөн хугацаанд ч гэсэн их байсан. Гэхдээ сүүлийн 3 жилийн хугацаанд ходоод гэдэсний өвчлөл эрс ихсэж байгаа судалгаа гарсан Манай ЭМЯ-ныхан мэдэж байгаа байх. Сургуулиудад, эсвэл сургуулиудад хоол нийлүүлж байгаа ААН-үүд дээр автомат аяга таваг угаагчтай байх, ялангуяа хеликобактериас бүрэн цэвэрлэдэг байх ийм стандарт байна уу, энэний хэрэгжилтийг яаж хангаж байгаа вэ?

3 дугаарт, нийслэлд 4 мянган төгрөг, орон нутагт 3 мянган төгрөг гээд хуваарилалт нь ингээд анхнаасаа шог байгаа. Хотын хүүхэд илүү их мөнгөөр хоол иднэ, хөдөөгийн хүүхдүүд бага мөнгөөр хоол иднэ гэж байгаа юм шиг л бодлого харагддаг. Тэгэхлээр олон гишүүд хэлж байгаа, би санал нэг байна. Нэгэнт хэдүүлээ энэ арга хэмжээ хэрэгжүүлж байгаа бол хот, хөдөөгөөр нь ядаж битгий ялгаач гэж хэлмээр байна. Дээрээс нь эцэг эх, асран хамгаалагч нараас мянган төгрөг авч байгаа. Энэ дээр бид хоолныхоо сонгон шалгаруулалт ч байдаг юм уу, чанарын шалгалт ч байдаг юм уу эцэг эхийн зөвлөлийн оролцоо хэр байгаа вэ? Журам ч байдаг юм уу, худалдан авах үйл ажиллагаа дээр нь тухайн сургуулийнх нь эцэг эхийн зөвлөл яаж оролцох вэ гэдэг энэ оролцоог хангаж өгвөл бид илүү үр дүнтэйгээр энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломжтой болов уу гэсэн бодолтой байна.

Нийслэлээс сүү хөтөлбөрийг хэрэгжүүлээд явж байгаад баяртай байгаа. Түүнийгээ баяжуулаад Д витаминээр баяжуулаад олон хүүхдүүдэд өгөөд явж байгаа гэдэг маш зөв. Үндэсний ААН-үүдээ ч гэсэн дэмжиж байгаа гэж бодож байна. Боловсролын яамны танилцуулга дээр нийслэлийн Асгат, Багачууд хүнс, Өсвөр үе хүнс, Хүнс хангамж төв гэсэн орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд нь орон нутгийн төсөвт ноогдол ашиг төвлөрүүлж байгаа учраас хүүхдийн хоолны чанар хүртээмжийг бууруулахад нөлөөлж байна гэж байна. Энэ дээр нийслэл маань хэдий хэмжээний ноогдол ашиг төвлөрүүлээд, хүүхдийн хоолноос ашиг хийгээд яваад байгаа юм уу, буцаагаад энийгээ зарцуулж байгаа юм уу гэсэн энэ эргэлзээг тодорхой болгож өгөхийг хүсэж байна.

Дээрээс нь ЕБС-ийн сурагчдын кальци, Д амин дэмийг нөхөх 21 сургуулийн 765 суралцагчаас шинжилгээ авсан гэж байна. Энэ шинжилгээний хариу хэзээ гарах вэ?

Иргэнээс ирсэн нэг асуулт байна, БЗД-ийн 26 дугаар хорооны 183 дугаар сургууль энэ жил ашиглалтад орсон боловч гал тогооны заалтай, тоног төхөөрөмжтэй мөртөө бэлэн хоол идээд байна, хэзээ халуун чанар.../минут дуусав/

**О.Номинчимэг:** Эхний асуулт 3 номер ЭМЯ Очирбат дарга.

**Д.Очирбат:** Гишүүний асуултад хариулъя. Амьсгалын замын өвчлөл сүүлийн үзүүлэлтүүдээр гарч байгаа үзүүлэлтүүд вакцинжуулалтын, энэ жил бид вакцинжуулалтаар 99,99 хувиар товлогоот болон нөхөн вакцинжуулалтуудыг хийж чадсан. Тэрний хүчинд энэ жил коридорт хэвтэх, яг энэ амьсгалын замын өвчлөлөөр нас баралтын түвшнийг тодорхой хэмжээнд ихсэхгүйгээр барьж чадсан. Тэгэхдээ энэ цаг улирлын хүндрэлүүд, улаан бурхантай холбогдсон хүндрэлүүд өвчлөл бол эхэлсэн.

Хоол тэжээлтэй хүүхдүүдийн, ялангуяа ЕБС нийтийн хоолны салбарт энэ хеликобактери энэ сав суулганы ариутгал, түрүүн бас гишүүн ярьж байна. Энэ аяга таваг ариутгах, энэ нөгөө хоол хүнсний тэр хийдэг саван дахь нөгөө ариутгал их дутагдалтайгаа өгсүүлээд хеликобактери маш их өсөж байгаа. Хеликобактери нь өөрөө цаашаа энэ элэгний өвчлөл, хорт хавдрын өвчлөлийн эх үүсвэр болоод явчихдаг. Хуучин нөгөө олон дамжлагатайгаар угааж хэрэглэдэг, хеликобактерийг устгадаг янз бүрийн бактерийн нөлөөллүүдийг арилгадаг байсан. Тэгээд энэ нь бол цаг тухайн үед хоцрогдолтой, шүүмжлэлтэй байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй байх гэж бодож байна.

**О.Номинчимэг:** Нийслэлтэй холбоотой асуудлыг 2 номер Амартүвшин дарга.

**А.Амартүвшин:** Лувсанжамц гишүүний асуултад хариулъя. Энэ хеликобактеритай асуудлаар нийслэл цогц арга хэмжээ аваад явж байгаа. Нэгд нийслэлийн төсөв хөрөнгө дээр 8,9 тэрбум төгрөг тавигдаад, худалдан ажиллах зарлагдаад нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явж байгаа бүх сургууль, цэцэрлэгүүд бол ариутгах техник хэрэгслээр энэ жил бүрэн 100 хувь хангагдаад явна.

2-т нь бол бид хеликобактерийг нийслэлийн бүх сургууль, цэцэрлэгийн хэмжээнд байхгүй болгохын тулд 3 шатлалтай арга хэмжээг хэрэгжүүлээд явж байгаа. Нэг нь бүх сургууль, цэцэрлэгүүдийн ариутгалыг хангах, 2 дахь нь НҮБ-ын Хүүхдийн хөгжлийн сантай хамтраад сургуулиудын болон цэцэрлэгүүдийн түүвэрчилсэн аргаар бид хеликобактерийн шинжилгээг авч, суурь судалгаагаар бол гаргаж ирээд, энэ бүх арга хэмжээнүүдээ хэрэгжүүлээд явна. 2 дахь нь гэвэл бид ахуйн хеликобактерийг байхгүй болгох чиглэлээр явж байгаа. Тэгвэл хүүхдүүдийн.../минут дуусав/

**О.Номинчимэг:** 2 номер нэмэлтээр, тэгээд тэр 4 хоол үйлдвэрлэлийн орон нутгийн өмчтэй холбоотой асуулт асуусан.

**А.Амартүвшин:** Ахуйн ахуйн хэрэглээнд хеликобактери аав ээж, ах дүү, хамаатан садан нь халбага сэрээгээ тусад нь хэрэглэх, гэрийн ахуйн хэрэглээнд ариутгах ажил явна.

3 дахь нь 9 сараас эхлээд бид үйл ажиллагаа явуулж байгаа ресторан, паб, хоолны газар, цайны газруудыг стандартчилаад бүх эдгээр газрууд нь аяга, таваг, халбага, сэрээтэй ариутгах ийм чиглэлийг ингээд хамтраад ЮНИСЕФ-тай гарч байгаа. Анхан шатны шинжилгээнд нийслэлээс тэрбум төгрөгийг шинжилгээнд гаргаад явж байгаа.

4 орон нутгийн өмчид байгаа. Орон нутгийн өмчид бол ашиг бол олдоггүй. Нийтдээ өнгөрсөн жил 27,4 тэрбум төгрөгийн борлуулалт хийгээд, 2,1 тэрбум төгрөгийн татварыг төлсөн. Үүнээсээ 200 сая төгрөгийн ашиг ч гэж гэхэд хэцүү. Тэрийг бол тэр нь юундаа явах юм бэ гэвэл цалин хөлс, нөгөө унааны зардал, бензин, засвар үйлчилгээ гээд л тэрэнд нь явж байгаа.

**О.Номинчимэг:** 1 номер Боловсролын яамнаас энэ асуултад хариулъя. 1 номер.

**Т.Түмэнжаргал:** Хоол үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Түмэнжаргал. Гишүүний асуултад хариулъя. Эхний ээлжид цэцэрлэг дээр орон нутагт 3 мянган төгрөгөөр, нийслэл дээр 4 мянган төгрөг буюу эцэг эхээс ингээд аваад явж байгаа. Тэгэхээр энэ дээр бид түрүүн хэлсэн цахим системийг нэвтрүүлээд яг эцэг эхэд яг тухайн хүүхэд өдөртөө ямар хоол идсэн, илчлэг, шим тэжээл, нүүрс ус, өөх тос нь ямар байсан гэдэг мэдээллүүдийг эцэг эхэд өгөөд, буцаагаад эргэх хяналт, хөндлөнгийн хяналттай ийм үйл ажиллагаа явуулж байгаа.

Төсөв дээр бид мөнгө тавьж өгөхдөө энэ ер нь энэ яриад байгаа сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоолны шим тэжээлийн байдлын агууламжийг 3 сайдын тушаалаараа баталсан байдаг Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайд, Сангийн сайд. Энэ тушаал дээр цэцэрлэг, сургуулийн хүүхэд хэдэн хувийг авах юм, тэн дотроо түрүүний гишүүний ярьдаг уураг, нүүрс ус, өөх тос ямар хэмжээтэй байх юм, үүнийг хангахын тулд 5 бүлгийн хүнс маань хэдэн граммаар орох ёстой юм гээд батлаад өгчихсөн байдаг.

**О.Номинчимэг:** Лувсанжамц гишүүн тодруулъя.

**Г.Лувсанжамц:** Баярлалаа. Шалгуур үзүүлэлтээ хэдүүлээ тодорхой болгоё. 5 жилийн үндсэн чиглэл дээр маш олон саналуудыг оруулж өгсөн. Хүүхдүүдийн амин дэм хэмжих юм уу, хоол тэжээлийн дутагдлаар хэмжих юм уу, эсвэл 2, 3 шалгуур үзүүлэлтээр хэмжих юм уу гэдэг энэ зүйлээ тодорхой болгосон нь зүгээр болов уу гэж бодож байна. Төсвийн гүйцэтгэлийг удахгүй хэлэлцэнэ. Энийг би тодруулж асуух учраас бэлэн байгаарай гэж.

2 дугаарт эцэг эхийн зөвлөлийн оролцоог нэмэх хэрэгтэй байгаа. Энэ санал шүү. Эцэг эхчүүд нь өөрсдөө хоолоо идэж үзээд, ямар байгууллага, ямар хоол хүнс, тэжээл манай хүүхдэд идүүлээд байгаа юм бэ гэдэг дээр нь оролцвол харьцангуй ил тод, нээлттэй, үр бүтээмжтэй хөтөлбөр болно гэж боддог юм шүү. БЗД-ийн 26 дугаар хорооны 183 дугаар сургуулийн үдийн цайны хөтөлбөр дээр хариулт авч чадаагүй байгаа. Түүн дээр нэмэлт авъя. Мөн Д амин дэмийн шинжилгээний хариу хэзээ гарах вэ гэсэн.

Дахиад нэг санал байна. Бүх сургуулиуд дээр хоол зүйчтэй болгоно гэсэн зүйл дээр манай бусад гишүүд маань хэлж байна. Энэ боломжгүй, тийм урсгал зардлыг дийлэхгүй. Тэгэхлээр дүүрэгтээ нэг ч юм уу, аймагтаа нэг.../минут дуусав/

**О.Номинчимэг:** 2 номер Амартүвшин дарга.

**А.Амартүвшин:** Амин дэмийн судалгаанууд хийгдээд, өнөөдөр албан ёсоор ингээд дуусаад, маргааш статистик судалгаан дээрээ манай багийнхан ажиллана, ажиллаад явна. Энэ дээр ерөнхийдөө Д витамин, кальци, С витамин бүх судалгаанууд ингээд гараад ирнэ. Сая Ганмаа гишүүний хэлдгээр бид яг суурь судалгаа өөрөө байхгүй байдаг хеликобактери ч бай, витамин ч бай. Тэгээд үнийн дүнгийн өсөлт, бууралттай холбоотойгоор ямар нөлөө үзүүлж байгаа гэдэг энэ суурь судалгаанууд байхгүй болохоор нийслэлийн хэмжээнд ч гэсэн суурь судалгаануудыг хийгээд явж байгаа.

183 дугаар сургууль дээр гэвэл гал тогооны тоног төхөөрөмж хэрэгсэл нь ирчихсэн байгаа. Тэгэхдээ сарын 1 сая 100 төгрөгөөр ажиллах яг үнэндээ тогооч, туслах тогооч ажилтан одоог хүртэл байхгүй байгаа. Зарлаад бид бараг 2 сар гаруй болж байна. Энэ дээр бол ажиллах хүн байхгүй байгаа.

**О.Номинчимэг:** Лувсанжамц гишүүн нэмэлт тодруулга.

**Г.Лувсанжамц:** Баярлалаа. Зөв үйл ажиллагаа хийж байна гэж бодож байна. Кальцийн шинжилгээг нь цусаар авч байна уу, эсвэл өөр аргачлалаар шинжилгээ авч байна уу гэдэг асуултыг Ганмаа гишүүн, доктор дамжуулж асуулаа. Тэгэхлээр нийслэл, дүүрэг, орон нутагт байгаа нь ч гэсэн адилхан ийм 1,1 сая төгрөгийн цалингаар тогооч олдохгүй байна гэж байгаа. Уг нь ААН-д хариуцуулах ч байдаг юм уу тийм байдлаар явбал их бүтээмжтэй болох юм байна гэсэн тийм саналтай байна.

Тэгэхлээр аль болох л эцэг эхийн оролцоог оруулж өгөхгүй бол төр нь хүүхдүүдийг нь бүгдийг нь хариуцаж даагаад хоолыг нь идүүлэх гээд байгаа юм шиг хандлагаар хандаж болохгүй шүү. Эцэг эхийн оролцоо хариуцлага маш чухал шүү гэдгийг манай хариуцаж байгаа 3 яамнууд маань үзээрэй. Тэгээд төсвийн гүйцэтгэл дээр асуултууд асуух учраас та бүхэн маань шалгуур үзүүлэлтийн суурь түвшин, зорилтот түвшнээ яаж биелснийг нь бэлдэж ирээрэй гэж хүсэж байна.

**О.Номинчимэг:** 2 номер Амартүвшин дарга.

**А.Амартүвшин:** Шинжилгээг бол цусаар авч байгаа, хеликобактерийг бол үлээж, мөн өтгөнөөр авч байгаа.

**О.Номинчимэг:** Мэндбаярын Мандхай гишүүн асуулт асууя.

**М.Мандхай:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд энэ их чухал асуудлыг хэдүүлээ ярьж байгаа учраас ер нь нэг биш, нэлээн хэдэн удаа нэлээн ярилцаж байж гаргалгаа шийдэл эндээсээ хамтдаа яг энэ хүүхдүүдийнхээ хоол хүнс болон шим тэжээлийн асуудлыг энэ эрүүл мэндийн асуудлыг шийдэх ёстой байх гэж бодож байгаа. Тэгээд энэ их чухал хурлыг зохион байгуулж өгч байгаа Номинчимэг даргадаа баярлалаа.

Ер нь энэ өгсөн материалууд мэдээж тодорхой түвшинд их товч тайлан танилцуулга байгаа. Энэний цаана маш өргөн судалгаа байгаа гэдэгт итгэж байна. Энэ өгсөн материалуудыг ерөнхийд нь ингээд харахад ерөнхий боловсролын сургуулийн энэ хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэрэгжилтийн гол асуудал нь ер нь шинэ бодлого дутсандаа биш эсрэгээрээ ер нь байгаа энэ одоо байгаа энэ хэрэгжиж байгаа шаардлага, стандарт, санхүүжилтийн асуудал, энэ худалдан авалт, хангамжтай холбоотой, дээрээс нь энэ хяналтын механизмын ийм цогц нэг байгууллага хоорондын уялдаа холбоо, эдгээр саяын хэлсэн асуудлууд нэг систем болж ерөөсөө ажиллаж чадахгүй байгаа дээрээ ер нь хамгийн том асуудал байгаа юм байна гэж харж байна. Тэгээд эндээс ингээд байгууллага байгууллагаас нэг хэдэн асуулт асууя гэж бодож байна.

Үдийн хоол энэ 141,3 тэрбум төгрөг 26 оны байдлаар төсөвт тусгагдсан байгаа гэж байгаа юм. Тэгээд Сангийн яамнаас асуумаар байгаа юм. Энэ нь өөрөө зардал дээр хүний нөөцийн нөгөө тогтвортой зардал, шаардлага дэд бүтэц, тоног төхөөрөмж ч гэдэг юм уу, энэ тогооч туслах, туслахын цалин, нийгмийн даатгал гэх мэтчилэн энэ зардлууд тусгагдсан төсөв үү гэдгийг 1 дүгээрт асуумаар байна. Тэгэхгүй бол хэдүүлээ зөвхөн хоолны зардлыг яриад энд нь бусад зардлууд ороогүй байвал дахиад энэ төсөв дээр ачаалал орж ирэхээр харагдаж байна. Тэгээд нэг ийм дутуу ийм шийдэл яваад байгаа юм биш биз дээ гэдэг дээр тодруулга авмаар байна.

Мөн 2018 оны энэ хамтарсан тушаалын энэ орон тооны жишиг нормативд хоол зүйчийн орон тоо байхгүй гээд нийслэлийн энэ тайлан дээр тайлагначихсан байгаа. Тэгэхээр энэ норматив шинэчлэх ажлыг бид хийх ёстой байх. Тэгэхээр энэ шаардлагатай тэр тоо тооцоо, төсвийн нөлөөллийн үнэлгээ ч гэдэг юм уу энийг хэзээ ер нь гаргаж өгөх боломжтой вэ? Мэргэжлийн яг энэ хоол зүйн энэ эрдэм шинжилгээ энэ Шинжлэх ухаан техникийн их сургуулийн энэ дэргэдэх хүрээлэнгийн гаргасан судалгаа, тайлан дээр бол хоол зүйчгүйгээр ерөөсөө энэ бид энэ яригдаад байгаа гол энэ хүүхдүүдийн шим тэжээл илчлэг, норм нормативыг нэвтрүүлэх боломж байхгүй гэдгийг гаргаж ирсэн байдаг. Тэгэхлээр энийг хэзээ бид энэ тоот судалгааг гаргах вэ?

**О.Номинчимэг:** Тэгье. Эхний асуултад Сангийн яам 4 номер.

**П.Бат-Эрдэнэ:** Сангийн яам, Зарлагын хэлтэс, Бат-Эрдэнэ. Мандхай гишүүний асуултад хариулъя. Хүүхдийн хоолны тэр 141 тэрбум гэдэг зөвхөн түүхий эдийн зардал байгаа. Үүнээс гадна тухайн хоол үйлдвэрлэлийг явуулахтай холбоотой тогооч, бэлтгэгч, угаагчийн цалин, дээрээс нь сургуулийн гал тогооны ашиглалтын зардал гэх мэт зардлууд энэ боловсролын хувьсах зардал болон бусад энэ орон нутгаас боловсролын байгууллагын тогтмол зардлыг төлж байгаа энэ зардлуудаар дамжаад энэ тусдаа санхүүжүүлээд явж байгаа. Яг энэ, эдгээр энэ бусад орцуудыг нийлүүлсэн дүнгээр энэ хоолны зардал маань яг 2500 биш арай өндөр дүн гардаг юм яг тооцоод үзвэл 5500 орчим ийм төгрөг. Тэгээд тогооч, бэлтгэгч, угаагч, энэ бусад энэ үйлчилгээнд ажиллаж байгаа хүмүүс маань өөрөө яг төрийн албан хаагчийн ийм статустай цалингаа авна, дээрээс нь төрөөс энэ эдийн засаг, нийгмийн баталгааг нь бүгдийг нь хангаж байгаа, 36 сарын тэтгэмж гэх мэтийн тэтгэмжүүдийг энэ тэр аваад ажиллаад явж байгаа гэсэн мэдээлэл өгөх байна. Баярлалаа.

**О.Номинчимэг:** Хоол зүйч дээр нийслэлээс 2 номер, хоол зүйчтэй холбоотой асуудал.

**А.Амартүвшин:** Энэ дээр 2 асуудал байгаа юм. Хоол зүйчийн асуудал гэж байгаа, дээрээс нь мужааны асуудал гэж байгаа. Тэгээд манайхан чинь нөгөө мужаан гэдэг хүнээ байхгүй, орон тоог нь байхгүй халаад явуулчихсан. Одоо бүх сургуулиудын сандал ширээг нөгөө эцэг эх, багш нар нь засаж янзалдаг болсон. Ингээд сургуулиуд нь мужаангүй, хоол зүйчгүй гээд ерөнхийдөө ийм нөхцөл рүү бол шилжээд орж ирж байгаа. Одоо ямар арга руу орж байна гэвэл дунд нь өндөр цалинтай хоол зүйчийг тавиад, тухайн хороонд нь үйл ажиллагаа явуулж байгаа 5, 6 сургуульд нь ч юм уу, 2, 3 сургууль дунд нь л тавих ийм л арга руу орж байгаа. Тэгэхээр нөгөө дахиад нөгөө цалингийн систем рүүгээ ороод сургууль болгоноос нь нэг хүнийг цалинжуулж байж болохгүй болчихно. Тэгэхээр тэр хүнийг ямар төрийн алба гэх үү, гэрээт гэх үү гээд яг энэ цалингийн асуудал дээр очоод л дахиад уначхаж байгаа юм. Яг нөгөө тогоочтойгоо адилхан энэ хоол зүйч нь гээд л орчхож байгаа юм. Хоол зүйч байхгүй болохоор нөгөө хоолны аюулгүй байдал, хоолны калори гээд л байхгүй.../минут дуусав/

**О.Номинчимэг:** Мандхай гишүүн тодруулъя.

**М.Мандхай:** Санхүүжилт бол эцсийн яах вэ мэдээж хамтдаа шийдэл гарах, шийдвэр гарах байх. Гэхдээ та хэд нийслэл энэ нормативаа шинэчлэх ажил руу орох шаардлагатай байх гэж бодож байна. Тэгээд шаардагдах тэр тооцоо гаргаад ир гэхэд бэлэн бүх юмнууд нь бэлдчихсэн, норматив нь шинэчлэгдчихсэн, орон тооны асуудал яг нийт тэдэн төгрөгийн, тийм зардал, төсөв шаардлагатай байна гэдгийг гаргаж ирэх нь зүйтэй байх. Нэгэнт бид энэ асуудлыг хөндөж ярьж байгаа учраас гэж бодож байна.

Боловсролын яамнаас энэ эрүүл мэндийн биш ээ, боловсролын салбараас Эрүүл мэндийн яамны энэ эрсдэлийн үнэлгээгээр их эрсдэлтэй гарсан сургуулиудын нэрсийг энэ Боловсролын ерөнхий газарт албан ёсоор шилжүүлсэн үү гэдгийг асуумаар байна. Яагаад гэхлээр энэ бид ингээд нөгөө нэг сургуулиудын бэлэн байдалд энэ аудитын ийм шинжилгээ энэ багийн бүрэлдэхүүн байгаа эсэхийг мэдмээр байгаа байхгүй юу. Ийм хуваарь байгаа юу сургуулиуд дээр хийх, дээрээс нь багийн бүрэлдэхүүн байгаа юу? Мөн түрээсээр.../минут дуусав/

**О.Номинчимэг:** Мандхай гишүүн дахиад нэмэлт 1 минут.

**М.Мандхай:** Энэ түрээсийн хэлбэрээр ажиллаж байгаа 42 сургуулийн үйлчилгээний гэрээнд нөгөө комплайнс гэдэг юм байх ёстой шүү дээ тийм ээ. Энэ комплайнс заалтууд ер нь жишээлбэл энэ температурын log, технологийн карт ч гэдэг юм уу, гомдол шийдвэрлэл ч гэдэг юм уу энэ ямар түвшинд туссан байгаа вэ гэдгийг асуумаар байна. Дээрээс нь энэ 2025 оны төлөвлөгөөт хяналтаар 310 байгууллагад 50082 зөрчил давтан зөрчил хэд байгаа вэ гэдгийг ЭМЯ хэлж өгч туслаач. Дээрээс нь энэ 35 хувийн калоритой байгаа дутагдалтай байгаа шинжилгээнд дурдсан. Тэгээд энэ зөвлөмжийн суурийг нэг мөр тайлбарласан тийм аргачлал энэ тэр гаргаж өгч болох уу? ХХААХҮЯ-наас энэ 17 нийлүүлэгч байгууллагыг ер нь нэмэгдүүлэх, төрөлжүүлэх боломж байна уу гэдгийг асуумаар байна. Энэ өөрөө энэ гэрээний нийлүүлэгч өөрөө 17 байгаад хязгаарлагдаж байгаа нь өөрөө их.../минут дуусав/

**О.Номинчимэг:** Хэн эхэлж хариулах вэ? Хүнс, хөдөө аж ахуй, Нийслэл юм уу, ЭМЯ 3 номер.

**Д.Очирбат:** Мандхай гишүүний асуултад хариулъя. Ер нь саяын судалгаа дүгнэлтүүдийг шалгалт удирдамжуудыг манай салбарын хяналтаас гаргахдаа Хөдөө, аж ахуйн яам, Боловсролын яам, холбогдох мэргэжлийн байгууллагуудтай нь голцуу хамтарч хийдэг. Дүн үнэлэлтүүдийг нь яаман дээр Удирдлагын зөвлөлийн хурал дээр хэлэлцэхдээ энэ салбар салбартаа байгаа мэргэжлийн улсууд нь дүн мэдээллүүдийг нь хүргүүлээд, Удирдлагын зөвлөлийн хурлаас тодорхой шийдэлтэй хариунуудыг нь өгдөг байгаа.

**О.Номинчимэг:** Нийслэлээс хариулах уу? Боловсролын газар аа? Боловсролын яамнаас асуусан асуултад хариулъя. Тэгээд ХХААЯ юм байна. 1 номер.

**Д.Түмэнжаргал:** Сургуулийн хоол үйлдвэр, үйлчилгээний тухай хуульд яг энэ сургуулийн хоол үйлдвэр, үйлчилгээнд ЭМЯ, ХХААЯ, Боловсролын яам хамт хамтарч хяналт үнэлгээ хийнэ гэсэн заалттай. Энэ үнэлгээ хийх журмыг баталсан байгаа. Тэгэхээр энэ журмынхаа хүрээнд 2 яамтайгаа яг төлөвлөгөөт буюу төлөвлөгөөт бус шалгалттай нь уялдуулаад хамтраад хяналт шалгалтаа хийгээд явж байгаа хяналт шалгалтын хувьд.

Түрүүн би таны ярьсан нөгөө хоол зүйчийн хувьд хоол зүйч дээр нэлээн асуудал гараад байна. Энэ хоол зүйч өөрөө 2001 оноос Монгол Улсад бэлтгэгдсэн, ерөнхий яг хүний нөөцийнхөө тоогоор дутуу байгаа. Манай хууль дээр болохоор сургууль болгонд хоол зүйч ажиллана гэхээр өнөөдөр 700 гаруй хоол зүйчийн хэрэгцээ шаардлага байгаа. Гэсэн хэдий ч одоо сургууль дээр 300 гаруй хоол зүйч ажиллаж байгаа. Тэгэхээр уг суурь нь өөрөө энэ хоол зүйчийн хүний нөөцийн дутагдал байгаад байгаа дээр сургууль дээр хангагдахгүй байгаад байгаа юм. Түүнээс биш норматив дээр дээр, шинэчилж байгаа норматив дээр хоол зүйч ажиллана гээд орчихсон явж байгаа, шинэчлэгдчихсэн явж байгаа манай Боловсролын яаман дээр батлуулах гээд.

**О.Номинчимэг:** ХХААЯ хариулъя асуусан асуултад нь 5 номер.

**Т.Жамбалцэрэн:** Мандхай гишүүний асуултад хариулъя. Ерөнхий гэрээгээр бүтээгдэхүүн нийлүүлэгч ААН-үүдийн тоо нэмэгдэж байгаа. 23 онд 9 байсан, 24 онд 14, 2025 онд 17 гээд. Энэ ерөнхий гэрээгээр нийлүүлэх нь нээлттэй байгаад байгаа юм, ААН-үүд өөрсдийнхөө бүтээгдэхүүн, чанар баталгаажуулалтаа хийгээд, нийлүүлэх гэрээгээ байгуулаад явах боломж нь нээлттэй. Энэ тоог нэмэгдүүлэх боломжтой. Гол нь нөгөө бүтээгдэхүүний маань үнээс хамаараад байгаа учраас орох сонирхолтой ААН-үүд бага байгаад байгаа. Тэгээд ялангуяа энэ хүнсний хөтөлбөрийн хүрээнд зээл авсан ААН-үүдийг энэ ерөнхий гэрээгээр сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд хоол хүнс нийлүүлэх шаардлагыг салбарын яамнаас тавьж ажиллаж байгаа.

**О.Номинчимэг:** Би нэг юм тодруулаад асуучихъя. Асуулт дуусаж байх шиг байна. Бид ингээд хоол зүйчийн асуудал нэлээн хөндөгдөж байгаа тийм үү? Хэчнээн бид мөнгийг нь ихэсгээд, ихэсгээд дандаа гурил, будаагаар тэжээгээд байх юм уу, төмсөөр эсвэл яг зохистой nutrition буюу энэ шим тэжээлийг яахын тулд хоол зүйч их чухал гээд. Тэгээд хууль дээрээ бид чинь сургууль болгон хоол зүйчтэй болно гэчихсэн юм байна. Би яг нөгөө бодит практикийг нь сайн мэдэхгүй л байна л даа. Би нийслэл дээр байхдаа нэг ийм төсөл хэрэгжүүлж байсан юм. Энэ сургуулиудын

гал тогооны техник, тоног төхөөрөмжийг нь шинэчлээд хеликобактери эд нар байхгүй болгох нөгөө угаалгын машин хийгээд, тэгээд яг мэргэжлийн хоол зүйч юу гэдэг юм nutritionist ийм загвар меню гаргаж байсан байхгүй юу. 2500 төгрөгт хамгийн optimal-ний ийм, ийм орцтой, ийм, ийм меню, долоо хоногийн меню гаргаад, сургуулиудад өгөөд, тэгээд энүүгээр нь сургуулиуд хийж байя гэдэг. Тэгэхээр хоол зүйч өөрөө юу гэдэг юм нэг сургууль дээр бүтэн юу гэдэг юм 7 хоногийн 5 өдөр нь бүтэн нэг өдөр өглөөний 9-өөс, 8-аас 5 хүртэл хоол зүйн ажлаа хийгээд байж байдаг тийм асуудал байдаг юм уу эсвэл ийм маягаар үнэхээр хүний нөөц дутагдалтай байвал ийм хоол зүйчдийг ингэж юу гэдэг юм загвар меню гаргах замаар тийм үү, тэр юмыг яах замаар ингэж ашиглаж болох юм уу? Тэгэхээр байгаа нөөц бололцоогоо яаж бид ашиглах вэ?

Тэгээд энэ нөгөө өргөдөл дээр ирж байгаа хоол зүйчдээ сургаж байх бас нэг ийм хэрэгцээ шаардлага байна гээд байгаа шүү дээ. Энэ дээр та бүхэн ер нь шийдэл нь юу гэж бодож байна вэ? Одоо бид зөндөө, ер нь төсөв мөнгийг нь нэмэх ёстой юм байна, тэр ариун цэврийн байдлыг нэмэх ёстой юм байна бүгдийг нь мэдэж байгаа. Хоол зүйчийн асуудал дээр та бүхний шийдэл тэгвэл одоо ийм 2 дахин дутмаг нөгөө хүний нөөцтэй хууль нь ийм байдаг, амьдралд нийцэж байгаа юм уу, үгүй юм уу мэдэхгүй байна, шаардлагатай юм уу гэдгийг нь би мэдэхгүй байна. Тэгэхээр яаж, юуг, яаж шийдэх юм бол хоол зүйчийн асуудлаа шийдээд, шим тэжээлийнх нь орцыг нь сайжруулж, хүүхдүүддээ хүргэж чадна гэж бодож байгаа вэ? Энэ дээр нэг та бүхэн өөрсдийнхөө шийдлийг хэлээч тэгэх үү? 1 номер уу? 1 номер Боловсролын яам.

**Т.Түмэнжаргал:** Яг гишүүний хэлсэнчлэн яг энэ төсвийн асуудал нэг талын л асуудал. Төсөв батлагдлаа гэхэд энийг яг яаж хүртээмжтэй, шим тэжээлтэй өгөх юм бэ гэдэг яг мэргэжлийн хоол зүйчийн асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр хууль хэрэгжихээс өмнө бидэнд 9 хоол зүйч л байсан 20 онд, одоо 300 гаруй хоол зүйч болж байгаа. Тэгэхээр энэ дээр салбарын яамны зүгээс ямар бодлого авсан гэхээр ШУТИС-тай хамтраад бакалавраар төгссөн хүнсний чиглэлийн суурь бакалавраар төгссөн хүмүүсийг хөрвөх буюу богино хугацаанд хоол зүйчээр бэлтгэсэн 1 дүгээрт. Тийм учраас өнөөдөр 300 гаруй сургууль хангагдчихаад байгаа. Цаашдаа бид яах вэ гэхээр яг нэгдсэн энэ цэс менюг ингээд гаргаад хэрэгжүүлээд явж байгаа. Хоол зүйчтэй сургууль маань хоол зүйчгүй сургуулиуддаа яг нэгдсэн цэс менюг гаргаад ингээд аймгийн хэмжээнд, дүүргийн хэмжээнд, сургуулиудын хэмжээнд хэрэгжүүлээд явж байгаа.

Цаашдаа ер нь яг ийм зарим газруудад цахим хэлбэрээр, зарим газруудад дундын байдлаар энэ хоол зүйчийн мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгөөд ингээд явна бүрэн хангагдах хүртэл хугацаанд. Энэ арга хэмжээнүүдийг дундын арга хэмжээнүүдийг аваад явж байгаа.

**О.Номинчимэг:** Гишүүд асуулт асууж дууслаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Ганмаа гишүүнээр 3 гишүүнээр тасаллаа. Даваасамбуугийн Ганмаа гишүүн үг хэлье.

**Д.Ганмаа:** Чухал асуудал цөмөөрөө хэлэлцэж байна өнөөдөр. Хэдэн зүйлийг хэлье. Сая зүгээр хариулсан хариулт дээр үндэслээд 1 дүгээрт витамин биш, сая кальцийг цусанд үздэг гээд хариулчихлаа шүү дээ тийм ээ? Кальци цусанд үзээд ямар ч нэмэргүй байдаг юм. Яагаад гэхээр зэрэг наадах чинь тэртээ тэргүй нөгөө зүрх судас, тэгээд булчин, мэдрэлийн бүх бодисыг хангадаг учраас хүний бие бараг

л бүр болохоо л больчихгүй бол кальцийг яг барьдаг байхгүй юу. Яаж барьдаг вэ гэхээр зэрэг нөгөө нэг ясанд байгаа витамин Д-ээс дамжуулаад яснаасаа аваад л цусанд ихээр гаргаж ирээд байдаг байхгүй юу. Үнэхээр кальцийн хэмжих гэж байгаа болбол corrected calcium гэж нэрлэдэг albumin-тэй холбоотой нэг тийм кальци байгаа тэрийг үзэх хэрэгтэй. Тэгж байж үнэн зөв, бодитой мэдээлэл гарна. Тэгэхгүй бол нөгөө суурь чинь худлаа гарчих байх гэж бодоод хэлэхгүй өнгөрч чадахгүй нь.

Ер нь энэ НЭМГ гэж байгаа шүү дээ. НЭМГ-аас газраас ямар шинжилгээг, ямар шинжилгээг ямар байдлаар жишээлбэл заавал ер нь цусанд үзээд байх хүүхдийг цус авах хэрэггүй байхгүй юу. Шээсэнд үзэх боломжтой. Тийм corrected albumin нь бага байвал бага гарна, их байвал их гараад байдаг нарийвчилсан юмнууд их байгаа. Энд мэдээж 3 минутад багтаж ярих ямар ч боломжгүй. Тэгээд ерөнхий юм ярихгүйгээр, нарийвчлахын тулд эмнэлгийнхэнтэйгээ эд нар чинь зөвлөсөн юм уу, ер нь зөвлөсөн үү та нар ЭМЯ-ныхан, НЭМГ-ынхан тэр араар суугаад байгаа мэргэжилтнүүд гэдэг дээрээ.

2 дугаарт бүр наад захын юм хэрэгтэй байдаг юм байна лээ хүүхдүүдэд. Цэвэршүүлсэн ус, нөгөө ам нь аягүй хатчихсан, аягүй хуурай сургуулиуд 40, 50-иараа суудаг, агааржуулалт ордоггүй. Тэгээд би түрүүний нэрлэсэн өөрийнхөө судалгаан дээрээ дандаа нөгөө цэвэр усны диспенсерүүд авч тавьдаг байсан байхгүй юу. Тэгээд хүүхдүүд өөрсдөө очоод л өөрийнхөө аяганд юм уу, өөрийнхөө саваар ус авч уугаад байдаг. Усны дутагдал бүр яг тэгээд hydration гэж нэрлэдэг шүү дээ байгаад байдаг. Энийг зайлшгүй оруулмаар юм байна лээ. Энэ чинь ус гэдэг чинь өөрөө шим тэжээлдээ ордог зайлшгүй. Тэгээд юу судлаад байхгүй витамин Д энэ тэр үзээд цусанд мөнгө төгрөг зарцуулахгүйгээр хамгийн дутагддаг ийм эслэг байдаг манай Монгол хүүхдүүдэд. Эслэг сургуулийн насны хүүхдэд. Түрүүн ярьсан фолат буюу В9, витамин Д эд нар бараг 99-өөс 100 хувийн дутагдалтай гардаг. Одоо Д гайгүй болчихсон байна лээ. Бараг 20 гаруй судалгаа хийгээд, олон нийтэд юу яагаад, дараа нь ковидоор миний гаргасан нөгөө нэг тэр нэг юугаар алгоритмаар хүүхдүүдийг эмчлээд Д-г бол харьцангуй ер нь хүмүүс аймаар сайн мэддэг болчихсон.

Тэгэхлээр зэрэг Д харьцангуй гайгүй болж байгаа ч гэсэн дутагдалтай байгаа витамин Е байгаа, С байгаа, кальци, magnesium юм. Түрүүний ярьсан тэгээд нөгөө буюу нөгөө нэг amino acid дутагдлууд их байдаг юм, ..., Lysine энэ тэр гээд 9 орчим байгаа. Тэрэн дээр зайлшгүй юм нэмэлтээр өгмөөр юм байна лээ. Хэд хэдэн юмыг би санал болгож өгмөөр байна зүгээр чухам минутдаа багтах нь уу үгүй юу. 1 дүгээрт энэ үдийн хоол хөтөлбөрт хамрагдаж байгаа 300 гаруй мянган хүүхдийн хүүхдийн хоол шим тэжээлийн чанарт хийсэн яг сүүлийн үеийн үндэсний хэмжээний судалгааг нэг хийчихмээр л байгаа юм ЭМЯ, Боловсролын яам, Сангийн яамтайгаа нийлж байгаад. Тэгээд before after байвал их сайн. Тэрийгээ нөгөө хоол шим тэжээлтэй холбоотой эрүүл мэндийн үзүүлэлттэйгээ нэгтгэж явуулах хэрэгтэй. Тэгээд тэрийгээ олон нийтэд ил гаргаж тавимаар байна. Тэгэхгүй бол мөнгө нэмээд байдаг, санхүүжилт яваад байдаг, тэр нөгөө нэг хоол шим тэжээлийн цэс эсвэл нөгөө үдийн хоолтойгоо холбоотой сайн, бодитой, эерэг үр дүн гарахгүй байгаад байгаа бол энэ чинь наана чинь асуудал болоод явчих учраас.

3 дугаарт би Улсын Их Хурлын хороонд энэний тийм хяналтын механизмтай больё гэсэн надад ийм санаа байх юм. Жишээлбэл үйл ажиллагаандаа жил бүрийн үндэсний тайланг аймаг, дүүрэг, хот, хөдөөгийн бүсээр нь ялгаварлаж, макро, микро nutrient-ийн түвшин, тархалт, эрэгтэй, эмэгтэй насны бүлгээр нь, тэгээд дутагдалтай,

илүүдэлтэй, презентайлтай нь бүүр гаргаж ирээд, олон нийтэд нээлттэй гаргаж тавья.

2 дугаарт ийм сэдэвчилсэн сонсгол жишээлбэл орон нутгийг сая ярьж байна, мөнгө төгрөг ярьж байна, тэгээд тэдэнтэй холбоотойгоор яг бүтэц тус бүрээр нь гаргаж ирээд, тэгээд 3 дугаарт сургууль дээр санамсаргүй visit хийгээд бараг аудит маягийн юм хиймээр байна. Япон, Америкт хэрэглэдэг үндсэн үнэлгээний үзүүлэлт буюу энэ scorecard гэж юм гаргадаг.../минут дуусав/

**О.Номинчимэг:** Мэндбаярын Мандхай гишүүн үг хэлье.

**М.Мандхай:** Би саяын саналыг дэмжиж байна. Ер нь яах вэ хэдүүлээ нэгэнт энэ бодлого байгаа ч гэсэн энэ хэрэгжилтийн ийм нөгөө гол юу гэдэг юм архитектор жоохон талдаа ажиллахгүй бол болохгүй байгаад байгаа учраас энэ яамд, орон нутаг, сургууль хоорондын уялдааг сайжруулах тал дээр төлөвлөгөө гаргая гэж бодож байна. Санхүүжилт угаасаа үр ашиггүй байгаа. Тэгээд яг бодит нөгөө өртөг тодорхой бус санагдаад байна л даа. Тэндээс ч хувьсах зардал болно, ийшээгээ бас тодорхой төсөв байгаа гэж байгаа ч гэсэн нэг хүүхдэд яг ноогдох зардал бодит өртөгтэйгөө яг нийцэхгүй байгаа учраас энийг яг тодорхой, нэг дүнтэй бол хэдүүлээ гаргаж ирж харъя гэж бодож байна.

Яг энэ сургуулиуд болон энэ түрээсийн сургуулиудын зөрчилтэй холбоотой энэ хариуцлага механизмын асуудлыг нэлээн чанаржуулах хэрэгтэй юм байна гэдэг дээр нэгдэж байна. Тэгэхээр энэ байгууллага хоорондын энэ координац хийх тийм механизмыг ер нь бүтэц байхгүй болохгүй байгаад байна, тус тусдаа ингээд бие биедээ өөр, өөр ингээд бүтцүүд яваад байгаа учраас ийм яаж ийм координац хийгддэг механизмыг бүрдүүлэх вэ гэдэг дээр нэг нэгдсэн ийм байгууллага хооронд нэг сууж байгаад, вакумжаад ч болтугай нэг төлөвлөгөө гаргаад, тэгээд энийг нэг яг цогцоороо нэг хараад, тэгээд бүгд яг нэг нэгдсэн нэг мэдээлэлтэй болж байж энэ төлөлтийг яг хэрэгжүүлж гэдэг дээр би нэг санал дэвшүүлээд ажиллахад бэлэн байна. Шаардлагатай бол ажлын хэсэг гаргаад, тэр ажилд нь ороход бэлэн байна.

**О.Номинчимэг:** Баярлалаа. Ажил хэрэгч саналууд гарч байгаа. Ажлын хэсэг байгуулъя, ийм, ийм арга хэмжээнүүд хийе, чиглэл өгье гээд. Тэгээд санал нэгдэж байна. Тэгээд шүүмжлэх амархан, бид гэхдээ шийдэл хэрэгтэй. Тэгээд шийдэл нь хөрсөн дээрээ буудаг байх хэрэгтэй. Хоол гэж зүгээр орхилгүй энэ бол өөрөө Монгол хүний хөгжлийн эхлэлийн цэг байгаа учраас ажлын хэсэг байгуулж ажиллах дээр бол Байнгын хорооны даргын хувьд дэмжиж байна. Сэддорж гишүүн ирсэн байна. Түүрүүн би Байнгын хороо эхлэхдээ хэлсэн Сэддорж гишүүний хувьд яг энэ дээр маш санаачилгатай ажиллаж, өргөдөл санаачилга, уриалгыг гаргаж өөрийн сонгогдсон орон нутагтаа энэ ажлыг бол улсын төсвөөс хамааралгүйгээр хийсэн гишүүн байгаа. Сэддорж гишүүн үг хэлье.

**Р.Сэддорж:** Баярлалаа. Өнөөдөр Өргөдлийн байнгын хороо Номинчимэг даргатай Байнгын хороо чухал хэлэлцүүлэг явуулж байна. Тэгээд бид бүгдээрээ үр хүүхэдтэй, дүү нартай хүмүүс. Монгол даяар энэ хүүхдүүдийн цай дэлхийн 180 гаруй орноос бид хэд нэг үдийн цайгаа бүгдэд нь өгчихвөл 90 оронд л орох гээд байгаа юм байна лээ, 90 дэх орон ч юм уу. Тэгэхээр 2006 онд Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль батлагдаж, Монголчууд үдийн хүүхдийн үдийн цай гэдэг ийм зүйлд анхаарал тавих болсон. Тэгээд эхлээд бол 1-ээс 2 дугаар ангид өгч байсан. Улсын Их Хурлын гишүүддээ санаачилга

гаргаад, 2025 оны 10 сарын 21-нд гарын үсэг зуруулж, 30 гаруй гишүүдийн гарын үсэг цуглуулж, энэ үдийн цайг нийт хүүхдүүдэд өгье, нийт хүүхдүүдэд өгөх мөнгийг нь улсын төсөв дээр тавья гээд ингэж санаачилга гаргасан. 37 хүний нэрийг энд дурдахад цаг хугацаа орох байх. Энэ гишүүддээ баярлалаа.

Бид энэ хүүхдийн хоол, хүүхдийнхээ үдийн цайг нэг доллар хүрэх, нэг доллар гаруйтай мөнгөөр шийдэж чадаагүй байж том, том төсөл ярьж хэрэлдэх нь утгагүй болчхоод байгаа юм. Цаана чинь би нэг Улаанбаатар хотын сургуульд очиж үзсэн юм. Тэгэхэд багш нар ярьж байна. Би 2 багштай уулзсан. Манай зарим хүүхэд зөвхөн үдийн цай уух гэж хичээлдээ ирдэг. Гэрт нь үдийн цай байхгүй. Тэрнийхээ ирсэндээ хүүхэд маань сайн сурдаг болсон шүү гэж, манай зарим хүүхэд зөвхөн сургууль дээр дулаахан учраас хичээлдээ ирдэг. Гэрт нь түлш байхгүй гэж ингэж ярьж байгаа юм. Тэгэхээр бид манай улсын төсөв хэчнээн болсон, хэд дахин өссөн, 35 их наяд болсон. Саяхан бид 7 их наяд төсөв ярьдаг байсан. Тэгэхээр бид энэ сая гаруй, 1 сая 100 мянга орчим хүүхдээ 47 хувийг нь хооллож байгаа юм байна тийм үү, үдийн цай өгч байгаа юм байна. Одоо 52 хувийг нь хэдүүлээ ирэх 27 оны төсөвтөө суулгая, 26 оны төсвөөс батлахад болохгүй нь гээд ингээд ирэх оны төсөвт заавал суулгана гэж амласан. Сангийн яам амласан, Боловсролын яам энийг ойлгож байна уу, ойлгохгүй байна уу амласан. Ингээд 27 оны төсөвт бүгдээрээ суулгачихъя, одоо бол 323 тэрбум төгрөг энэ жилийн төсөв. Тэгээд ирэх жилийн төсвөө хэдүүлээ ингээд бүгдээрээ сайн эртхэн тооцоод, одоо төсвийн цаглавар хэлэлцэж эхлэх гэж байгаа учраас эртхэн тооцоод энийгээ заавал суулгана шүү.

Бид яах вэ говийн бүсээс сонгогдсон, миний хувьд Өмнөговь аймаг 100 хувь хүүхдүүдээ цайлж хооллож байгаа. Тэгээд чанарын асуудал дараагийн асуудал, яаж хооллох асуудал бол тэр тухайн сумын, аймгийн даргын асуудал хариуцах асуудал шүү. Дорноговь аймаг 100 хувь хооллож байгаа. Эцэг эхтэй нь хамтарч байгаа, 1600 төгрөгийн төгрөгийг эцэг эхээс, 900 төгрөгийг аймгийн төсөвтөө суулгаад Дорноговь аймаг сайн хангаж байгаа. Тэгээд аймаг болгон өөр өөрийн онцлогтой, бүс нутаг болгон өөр өөрийн онцлогтой. Тэгэхээр энэ хоол юу өгөхөө тэр аймгийнхан мэднэ дээ. Тэгэхээр энэ та бүгдийн маань энэ оролцож байгаа хэлэлцүүлэг маш чухал байна. Тэгээд бүгдээрээ 27 оноос эхлээд Монгол Улс нийт хүүхдүүдээ алагчлалгүй үдийн цай ядаж уулгачихъя.

**О.Номинчимэг:** Баярлалаа гишүүд үг хэлж дууслаа. Тэгээд өнөөдрийн манай энэ Өргөдлийн байнгын хороон дээрх хууль хэрэгжилтийн хэлэлцүүлэгт ирсэн та бүхэнд баярлалаа. Өнөөдөр бүхий л энд оролцож байгаа гишүүд хүүхдүүдийнхээ үдийн цайг сайжруулъя, шим тэжээлийг нь сайжруулъя гэсэн ийм л санаатай байгаа. Тэгэхээр та бүхэн маань санаачилгатай ажиллаад, сая хэлсэнчлэн, түрүүн хэлсэн шүү дээ дотуур байрны шим тэжээлээ сайжруулах ажил чинь нэн тэргүүнийх байна хөдөө, орон нутагт байгаа. Дээр нь ингээд дунд, ахлах сургуулийн хүүхдүүддээ үдийн цайг нь өгчихмөөр байна, угаасаа энэ чинь хуулийн хэрэгжилт шүү дээ. Энэ удаашраад байна. Тэгээд энэнийхээ тооцоог гаргаад өг. Сангийн яам энэ дээр төсөв мөнгөө харамлаад байх шаардлагагүй. Энэ бол ирээдүйгээ хорлох үйл явдал шүү.

Тэгээд хаанаас нь эх үүсвэрийг нь гаргах вэ гэдэг арга замыг нь гаргаад, архи, тамхи, энэ хортой бүтээгдэхүүний татвар маш бага байгаа, нэмээд энийгээ оруулъя, эндээсээ хүүхдийн хоолныхоо мөнгийг гаргачихъя гэхээр юу гэдэг юм сайдынхаа түвшинд байдаг юм уу, газрын даргынхаа түвшинд янз бүр болоод эсэргүүцээд ямар ч шаардлага байхгүй. Энэ дээр та нар анхаарч ажиллах хэрэгтэй. Эх үүсвэр байхгүй гэхгүй, тэр эх үүсвэрийг чинь гаргах шийдлийг нь гаргаж ирчхээд байхад. Тэгэхээр

энэ дээр Өргөдлийн байнгын хороон дээрээс ажлын хэсэг гаргая. Та бүхэн бас Төсвийн цаглаварт тусах тэр бүх тооцооллуудаа гарга. Бид ч гэсэн энэ дээр Улсын Их Хурлаас Засгийн газарт энэ асуудлаа шахаж, шаардлага тавьж ажиллах асуудал дээр анхаарч, хаана хаанаа хариуцлагатай хандаад энэ асуудал дээр нэг шийдэлтэй ийм байя л гэж хэлмээр байна.

18:15 цаг

Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан тул Байнгын хорооны хуралдааныг хаасныг мэдэгдье. Гишүүддээ, оролцсон хүмүүстээ бүгдэд нь баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА